



УЛС ТӨР ДЭХ ЗАЛУУЧУУД БОЛОН ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ТУЛГАМДАЖ БҮЙ СОРИЛТ БЭРХШЭЭЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР 2021

Энэхүү судалгааны тайланг америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтай, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд “Цогц Хөгжлийн Үндэсний Төв” ТББ бүтээв. Судалгааны тайланд илэрхийлэгдсэн үзэл санаанууд нь АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

БАГИЙН АХЛАГЧ

М.Энхбадрал

Социологийн магистр

ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ

Э.Гэрэлт-Од

Улс төр судлалын доктор

Д.Бумдарь

Улс төр судлалын доктор

Г.Түмэннаст

Социологийн доктор

СУДЛААЧ ГИШҮҮД

Г.Доржтүвдэн

Ахлах судлаач, социологич

Ж.Батболд

Дата шинжээч

Г.Мөнхтунгалаг

Дата шинжээч

Ш.Билгүүн

Улс төр судлаач, магистр

Г.Золзаяа

Улс төр судлаач, магистр

А.Түвшинбаяр

Улс төр судлаач, магистр

Г.Бадамдаш

Улс төр судлаач, магистр

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Графикийн жагсаалт	4
Хүснэгтийн жагсаалт	5
Товчилсон үгийн тайлбар	6
Судалгааны арга зүй	8
Судалгааны түүвэр	9
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УЛС ТӨР ДЭХ ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮДЭД УЛС ТӨРИЙН ИНСТИТУТИЙН ХҮЧИН ЗҮЙЛС НӨЛӨӨЛӨХ НЬ	11
1.1 Өнөөгийн эрх зүйн орчин дахь залуучууд, эмэгтэйчүүдийн улс төрийн сонгуульд нэр дэвших боломж	11
1.2 Улс төрийн намын дүрэм дэх залуучууд, эмэгтэйчүүдийн улс төрийн сонгуульд нэр дэвших боломж, харьцуулалт	19
1.3 Улс төрч залуучууд эмэгтэйчүүдийн амжилтад институтийн хүчин зүйл нөлөөлөх нь (чанарын судалгааны үр дүн)	29
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАЛУУ БОЛОН ЭМЭГТЭЙ УЛС ТӨРЧДИЙН КАРЬЕРТ НӨЛӨӨЛЖ БУЙ ХУВЬ ХҮНИЙ ХҮЧИН ЗҮЙЛС	44
2.1 Хүн ам зүйн мэдээлэл хийсэн шинжилгээ	44
2.2 Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд нөлөөлж буй хувь хүний хүчин зүйлс	55
ГУРАВДУГААР БҮЛЭГ. УЛС ТӨРЧ ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮДЭД НИЙГЭМ, СОЁЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС НӨЛӨӨЛӨХ НЬ	78
3.1 Өнөөгийн улс төрийн амьдрал дахь залуучууд болон эмэгтэйчүүдийн оролцооны нийгмийн суурь хүчин зүйлс	78
3.2 Улс төрч залуучууд эмэгтэйчүүдэд нийгэм соёлын хүчин зүйлс нөлөөлөх нь	84
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	94

График 1.	УИХ-д нэр дэвшигчид , НИТХ, ИТХ ,Засгийн газар, Засаг дарга нарын насны бүтэц /2016 болон 2020 оны нийт үр дүн/	44
График 2.	Хүйсийн харьцаа улс төрийн албаар	45
График 3.	2016 болон 2020 оны УИХ-н сонгуульд суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн мэргэжлийн ангилал.....	46
График 4.	УИХ-д нэр дэвших үедээ болон дэвшихээсээ өмнө эрхэлж байсан ажлын төрөл болон насны бүтцийн харьцаа. / 2016 болон 2020 оны УИХ-ын сонгуульд суудал бүхий намуудаас нэр дэвшигчид / ...	48
График 5.	2020 оны нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшигчид болон сонгогдсон төлөөлөгчдийн насны харьцаа.....	48
График 6.	2016 болон 2020 оны орон нутгийн сонгуулиар сонгогдсон НИТХ-ын төлөөлөгчдийн мэргэжлийн бүтэц.....	49
График 7.	Аймаг дүүргүүдийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын насны бүтэц.....	50
График 8.	Аймаг болон дүүргүүдийн ИТХ төлөөлөгчдийн нас болон хүйсийн харьцаа. /2016 болон 2020 оны сонгуулийн үр дүн/.....	51
График 9.	2020 оны орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид болон сонгогдсон төлөөлөгчдийн нас болон хүйсийн харьцаа.....	52
График 10.	2017-2020 он болон 2020-2021 онд томилогдон ажилласан Засгийн газрын сайд дэд сайд нарын насны бүтэц.....	52
График 11.	Аймаг, дүүргүүдийн засаг дарга, орлогч нарын мэргэжлийн ангилал /2016 болон 2020 оны томилгоо/.....	54
График 12.	2016 болон 2020 оны сонгуульд суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн боловсролын зэрэг хүйсээр.	60
График 13.	Аймаг дүүргүүдийн ИТХ-ын төлөөлөгчдийн мэргэжлийн байдал.	61



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нэр дэвшигчдэд тавигдах нийтлэг шаардлага	13
Хүснэгт 2. УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэй улс төрчид	16
Хүснэгт 3. УИХ-д сонгогдсон гишүүдийн хүйс, насны бүлэг (хувиар).....	17
Хүснэгт 4. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид	17
Хүснэгт 5. 2020 оны УИХ-д сонгогдсон нам, эвслийн дэмжлэг, суудлын тоо ...	19
Хүснэгт 6. Нэр дэвшигчдэд тавигдах ёс зүйн хэм хэмжээ, шалгуурыг дүрэмд тусгасан эсэх.....	21
Хүснэгт 7. Намын дүрэм дэх залуучууд, эмэгтэйчүүдийн квот	24
Хүснэгт 8. Улс төрийн албан хаагчдын дундаж нас хүйсийн харьцаа. /2016 болон 2020 оны дундаж/	45
Хүснэгт 9. УИХ-ын сонгуульд суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа.	46
Хүснэгт 10. 2016 болон 2020 онд сонгогдсон УИХ-ын гишүүдийн ажлын туршлага /жилээр/	47
Хүснэгт 11. НИТХ-ын төлөөлөгчдийн ажлын туршлага / 2016 болон 2020 оны сонгуулийн дараа/.....	50
Хүснэгт 12. Аймаг болон дүүргүүдийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хүйсийн харьцаа	51
Хүснэгт 13. Засгийн газрын сайд нар болон дэд сайд нарын хүйсийн харьцаа	53
Хүснэгт 14. 2017-2020 он болон 2020-2021 онд ажилласан засгийн газрын сайд дэд сайд нарын ажлын туршлага нийлбэр дүнгээр / Жилээр/.....	53
Хүснэгт 15. 2016 болон 2020 онд томилогдсон засаг дарга нарын нас хүйсийн харьцаа.....	54
Хүснэгт 16. Аймаг дүүргүүдийн Засаг дарга болон засаг даргын орлогч нарын ажлын туршлага /жилээр/.....	55

АНСДИТХСТХ	Аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
АН	Ардчилсан Нам
АЗХ	Ардчилсан залуучуудын холбоо
ЖЭТБХТХ	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ЗГ	Засгийн газар
ИЗН	Иргэний Зориг Нам
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МЗХ	Монголын залуучуудын холбоо
МУИХСТХ	Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль
МУЕСТХ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
НАШБ	Намын анхан шатны байгууллага
НАМЗХ	Нийгмийн ардчилал монголын залуучуудын холбоо
НАМОХ	Нийгмийн ардчилал залуучуудын холбоо
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн хурал
ОУБ	Олон улсын байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТЗА	Төрийн захиргааны алба
ТУТА	Төрийн улс төрийн алба
ТТА	Төрийн тусгай алба
ТҮА	Төрийн үйлчилгээний алба
УИХ	Улсын Их хурал
УТНТХ	Улс төрийн намын тухай хууль
ҮБХ	Үндэсний бодлогын хороо
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХҮН	Хөдөлмөрийн Үндэсний Нам

УДИРТГАЛ

Ардчилсан нийгэмд иргэдийн улс төрийн оролцоо, тэр дундаа нийгмийн бүлгүүдийн улс төрийн идэвхтэй оролцоо чухал нөлөөтэй байдаг. Үүн дотор эрэгтэй, эмэгтэй, ахмад болон залуу үеийн төлөөллийн хэмжээ чухал хэмжүүр болдог. Монгол улс 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш УИХ-ын сонгуулийг 8 удаа, орон нутгийн сонгуулийг 7 удаа зохион байгуулаад байна. Сонгуулиар дамжуулж иргэд төрийн эрх барих эрхээ эдэлдэг.

Монгол улсад 1992 оноос хойших сонгууль тус бүрд сонгогдсон төлөөлөгчдийн дунд залуучууд болон эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага байсаар ирсэн. 2020 оны УИХ-ын сонгуульд нийт 606 нэр дэвшигчид нэрээ дэвшүүлж өрсөлдсөн бөгөөд сонгуулийн үр дүнд 13 эмэгтэй гишүүн УИХ-д сонгогджээ. Түүнчлэн УИХ-ын гишүүдийн 7.8 хувь нь буюу 6 гишүүн 40-өөс доош насны залуу гишүүн байна. Мөн 35 хүртэлх насны 1 залуу гишүүн сонгондсон байна. Үүнээс харахад залуу болон болон эмэгтэйчүүдийн төлөөлөл төрийн шийдвэр гаргах түвшинд хангалтгүй байна. Нөгөөтээгүүр улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаа шалтгааны судалж тодруулах, тулгамддаг асуудал, нөхцөл байдал, улс төрийн намуудын дотоод ардчилал, УИХ болон орон нутгийн сонгуулийн үйл явцыг судалсан судалгаа шинжилгээний ажил хязгаарлагдмал байна. Улс төр дэх залуучууд эмэгтэйчүүдэд тулгамддаг асуудлыг судалснаар, асуудлыг шийдвэрлэх, залуучууд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

Судалгааны зорилго

Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамддаг сорилт бэрхшээлүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, тодруулах.

Судалгааны зорилт

- Залуу болон эмэгтэй улс төрчдөд тулгамдаж буй сорилт бэрхшээлүүдийг хувь хүн, институт, нийгэм соёлын хүчин зүйл тус бүрээр судалж тодруулах
- Засгийн газар болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын ялгаатай төлөөллийг судлах. (сонгогдсон болон томилогдсон албан тушаалтнууд. Үүнд: УИХ-н гишүүд, ИТХ-ын төлөөлөгчид, сайд болон агентлагуудын дарга нар, дүүрэг болон аймгуудын засаг дарга, орлогч дарга нар.
- Судалгааны үр дүнг олон нийтэд түгээх, залуу болон эмэгтэй улс төрчдөд тулгамддаг асуудлуудад нийтийн анхаарлыг хандуулах

1. Нэгдүгээр хэсэг. Улс төрч залуучууд болон эмэгтэйчүүдийн улс төрийн нөхцөл байдлыг тодруулах.

№	Арга зүй	Үйл ажиллагаа/Activity	Судалгаанд оролцогчид
1.1	Ганцаарчилсан сурвалжилга	Сонгогдсон хүмүүстэй ганцаарчилсан ярилцлага хийх	40-өөс доош насны УИХ-н 2020 сонгууль болон аймаг, нийслэл, дүүргүүдийн 2020 оны сонгуульд ялагдал хүлээсэн улс төрчид
1.2	Ганцаарчилсан сурвалжилга	Сонгогдсон хүмүүстэй ярилцлага хийх	Улс төрийн намуудын шийдвэр гаргах түвшний эрх мэдэл бүхий албан тушаалтнууд
1.3	Desk review	Улс төрийн намуудын дотоод дүрэм, нэр дэвшүүлэх журам, сонгуулийн тухай хуулийн заалтуудыг харьцуулан шинжлэх	Сонгуулийн тухай хууль, нам эвслүүдийн сонгуульд гишүүд дэвшүүлэх бодлого дүрэм, журмууд

2. Хоёрдугаар хэсэг: Томилгоо болон нэр дэвшигчдийн хүн ам зүйн төлөөллийг судлах

№	Арга зүй	Үйл ажиллагаа
2.1	Баримт бичгийн шинжилгээ	2016, 2020 онуудад УИХ-н гишүүнээр сонгогдсон гишүүд болон сонгогдсон аймаг дүүргүүд болон Нийслэлийн ИТХ-н төлөөлөгчдийн хүн ам зүйн мэдээлэлд шинжилгээ хийнэ
2.2	Баримт бичгийн шинжилгээ	2016, 2020 онуудын Засгийн газрын гишүүдийн томилгоо, агентлагийн дарга болон 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүргийн засаг дарга болон засаг даргын орлогч. Улаанбаатар хотын засаг дарга болон засаг даргын орлогчоор томилогдсон хүмүүсийн хүн ам зүйн мэдээлэлд шинжилгээ хийнэ.

Судалгааны түүвэр

1. Орон нутгийн сонгуулийн хүрээний түүвэр

Энэ хэсэг сонгогдсон 4 дүүрэг, 6 аймаг болон нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг хамарна



Орон нутгийн сонгуулийн түүвэр

№	Судалгааны талбар	Монгол ардын нам	Ардчилсан нам, МАХН, ХҮН, ШИНЭ	Нийт
1	Баянзүрх дүүрэг	3	2	5
2	Сүхбаатар дүүрэг	2	3	5
3	Баянгол дүүрэг	3	2	5
4	Налайх дүүрэг	2	1	3
5	Өвөрхангай аймаг	2	2	4
6	Хэнтий аймаг	2	2	4
7	Сүхбаатар аймаг	2	2	4
8	Хөвсгөл аймаг	2	2	4
9	Ховд аймаг	2	2	4
10	Өмнөговь аймаг	2	2	4
Нийт				42

Нийслэлийн ИТХ-ын түүвэр

№	МАН	АН	ХҮН	Нийт
1	5	4	1	10

Судалгааны түүвэр газарзүйн байршлаар



2. УИХ-ын сонгуулийн хүрээний түүвэр

Энэ хүрээний түүвэрт УИХ-д суудалтай улс төрийн намуудын залуу болон, эмэгтэй гишүүд хамаарна.

№	Нам эвслүүд	Сонгуульд нэр дэвших эрхээ авч чадаагүй улс төрч	Сонгуульд ялагдал хүлээсэн улс төрч	Сонгуульд ялсан улс төрчид	Түүврийн хэмжээ
1	МАН	3	2	4	9
2	АН	3	2	2	7
3	Зөв хүн электорат эвсэл	1	2	1	4
4	Та бидний эвсэл	1	2	1	4
Нийт		8	8	8	24

Баримт бичгийн шинжилгээ:

№	Баримт бичиг болон мэдээлэл	Хамрах хүрээ
1	Улс төрийн намуудын дотоод дүрэм Сонгуулийн тухай хууль Бусад холбогдох хууль тогтоомжууд	МАН АН Та бидний эвсэл Зөв хүн электорат эвсэл
2	2020 оны УИХ-н сонгуульд нэр дэвшигчдийн хүн ам зүйн мэдээлэл 2016 оны УИХ-н сонгуульд нэр дэвшигчдийн хүн ам зүйн мэдээлэл 21 аймаг, 9 дүүрэг болон НИТХ-н төлөөлөгчдийн хүн ам зүйн мэдээлэл (нас, хүйс)	2020 оны УИХ-н сонгуульд ялалт байгуулсан 76 нэр дэвшигч 2016 оны УИХ-н сонгуульд ялалт байгуулсан 76 нэр дэвшигч 2016 болон 2020 оны 21 аймаг, 9 дүүрэг болон Улаанбаатар хотын ИТХ-н нийт төлөөлөгч
4	Монгол Улсын Засгийн газрын бүтэц танилцуулга Албан ёсны веб сайтын мэдээлэл Бусад эх сурвалж	Ерөнхий сайд, Шадар сайд Сайд, дэд сайдууд Засгийн газрын 35 агентлагийн дарга 21 аймаг болон 9 дүүргийн засаг дарга нар, засаг даргын орлогчид

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УЛС ТӨР ДЭХ ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮДЭД УЛС ТӨРИЙН ИНСТИТУТИЙН ХҮЧИН ЗҮЙЛС НӨЛӨӨЛӨХ НЬ

1.1 Өнөөгийн эрх зүйн орчин дахь залуучууд, эмэгтэйчүүдийн улс төрийн сонгуульд нэр дэвших боломж

Монгол Улс нь чөлөөт ардчилсан сонгуулиар төрөө байгуулдаг ардчилсан улс болоод даруй 31 жилд өнгөрчээ. Энэ хугацаанд 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж, түүнд нийцүүлэн бусад хуулиа баталж, шинэчилсээр ирсэн.

Иргэний нэр дэвших эрхийг Үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулсан байдаг. Бусад хууль гэдэгт Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль (МУИХСТХ), Аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (АНСДИТХСТХ), Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХТХ), Улс төрийн намын тухай хууль (УТНТХ)-иудаар тус тус зохицуулсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.9-д шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг **арван найман наснаас** эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно¹ гэж заасан. Энэ дагуу Үндсэн хуулийн 21.3-т Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно, 30.2-т Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно, 59.3-т Аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно² гэж тус тус заасан байдаг.

Үндсэн хуулийн дээрх заалтуудад нийцүүлэн МУИХСТХ, МУЕСТХ, АНСДИТХСТХ-иудад нэр дэвшигчдэд тавигдах шалгуурыг тодорхойлсон. Үүнд:

- МУИХСТХ³-ийн 3.1.3-т “нэр дэвшигч” гэж 25 нас хүрсэн, энэ хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын иргэнийг;
- МУЕСТХ⁴-ийн 3.1.2-т “нэр дэвшигч” гэж 50 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын уугуул иргэнийг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. <https://www.legalinfo.mn/law/details/367>

² Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. <https://www.legalinfo.mn/law/details/367>

³ Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2019 он. <https://www.legalinfo.mn/law/details/14869>

⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 2020 он. <https://www.legalinfo.mn/law/details/15826?lawid=15826>

• АНСДИТХСТХ⁵-ийн 3.1.2-т “нэр дэвшигч” гэж 18 нас хүрсэн, энэ хуульд заасан журмын дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын иргэнийг хэлнэ. Мөн “нэр дэвшигч”-ийг энэ хуулийн 5.2.3-т 18 нас хүрсэн, ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй, 5.3-т ээлжит бус, нөхөн, дахин сонгуульд 18 нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө шилжин суурьшиж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй гэж заажээ.

Улс төрийн намууд МУИСТХ, АНСДИТХСТХ-д заасан хугацаанд улс төрийн нам, эвсэл болон бие даагчид нэрээ дэвшүүлэх, МУЕСТХ-д зөвхөн УИХ-д суудалтай нам нэр дэвшүүлэх эрхтэй. Нам, эвсэл нэр дэвшигчийг тодруулахдаа **хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахихыг** хуулиар зааж өгсөн.

• УИХ-сонгуульд МУИХСТХ-ийн 30.4-т намаас нэр дэвшүүлэх асуудлыг тухайн намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ.

• Орон нутгийн ИТХ-ын сонгуульд АНСДИТХСТХ-ийн 29.3-т намаас нэр дэвшүүлэх асуудлыг тухайн намын аймаг, нийслэл, сум, дүүргийн байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэсэн байхыг үүрэг болгосон.

МУИХСТХ, МУЕСТХ, АНСДИТХСТХ-аар нэр дэвшигчдэд эдийн засгийн, эрүүл мэндийн, албан тушаалын, улс төрийн болон эрх зүйн нийтлэг шаардлагыг тодорхойлсон байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁵ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль. 2020 он. <https://www.legalinfo.mn/law/details/15125>

Хүснэгт 1. Нэр дэвшигчдэд тавигдах нийтлэг шаардлага

№	Нийтлэг шаардлага	МУИХСТХ-ийн заалт	МУЕСТХ-ийн заалт	АНСДИТХСТХ-ийн заалт
1	Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх;	29.3.1.	26.2.1.	28.3.1.
2	Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх.	29.3.2.	26.2.2.	28.3.2.
3	Сэтгэцийн эмгэггүй байх.		26.2.3.	
4	Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирлын ажил, албан тушаал эрхэлж байгаа бол ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байх	229.4.	26.3	28.4.
5	Засгийн газраас байгуулсан хамтын удирдлагын байгууллагын орон тооны болон орон тооны бус гишүүн.		26.3.4.	28.4.4.
6	Нэг намын гишүүнийг өөр намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно.	29.5.	26.4.	28.5.
7	Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно.	29.6.		28.6.
8	Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.	29.7.	26.5.	28.7.
9	Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.	29.8.	26.6.	28.8.

МУИХСТХ-д нэр дэвшигчдэд нийт 8, АНСДИТХСТХ-д нийт 8, МУЕСТХ-д нийт 6 шаардлагыг хангасан байх үүрэгтэй. Сонирхолтой нь сэтгэцийн эмгэггүй байх гэсэн эрүүл мэндийн шаардлага зөвхөн МУЕСТХ-д туссан байна. Харин засгийн газраас байгуулсан хамтын удирдлагын байгууллагын орон тооны болон орон тооны бус гишүүн байхыг МУЕСТХ, АНСДИТХСТХ-иудад, нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг МУИХСТХ, АНСДИТХСТХ-иудад тус тус хоригложээ.

Энэ судалгаа нь Монгол улсад улс төрч залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамддаг сорилт бэрхшээл тэр дундаа улс төрийн гол үйл явц болох нэр дэвших боломж, эрх зүйн орчин, нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж байгаа тул залуучууд, эмэгтэйчүүдийг дэмжсэн эрх зүйн орчин бий эсэхийг судаллаа.

- Залуучууд нэр дэвших тухайд тусгайлсан нэмэлт шаардлага байхгүй байна. Харин Үндсэн хуулийн шаардлагаар нэр дэвшигч нь УИХ-ын сонгуульд 25 нас, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн нэр дэвших эрхтэй гэж зааснаар залуучуудыг насны босгоор хамруулжээ.
- Эмэгтэйчүүд нэр дэвших тухайд Үндсэн хуулиар дэмжсэн тусгайлсан заалт байхгүй. Харин Үндсэн хуулийн 16.11 дэх хэсэгт *улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй*⁶ гэж мөн ерөнхийлж заасан байдаг.

Гэвч бодит байдал дээр залуучууд, эмэгтэйчүүдийн төлөөлөл улс төрийн шийдвэр гаргах түвшинд бага байсаар байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол улс Хүний эрхийн түгээмэл тунхаглал⁷ (1946 он), Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн конвенц⁸ (1954 он), Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1981 он)-уудад нэгдэж залуучууд болон эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн.

Мөн Мянганы хөгжлийн зорилт⁹ (2000-2015), Тогтвортой хөгжлийн зорилт¹⁰ (2016-2030)-ыг хэрэгжүүлэх хүрээнд улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх жендерийн тэгш байдлыг хангахад зарим дэвшил гарсан байдаг. Тодруулбал, хамгийн анх 2005 оны МУИХСТХ¹¹-ийн 28.2-т “Нам, эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь эмэгтэй байх” гэсэн заалтыг баталсан. Гэвч хуулийн энэ заалтыг огт хэрэглэхгүйгээр 2007 онд УИХ цуцалсан байдаг. Дараа

⁶ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. <https://www.legalinfo.mn/law/details/367>

⁷ Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946 он. <https://www.legalinfo.mn/law/details/1271>

⁸ Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн конвенц 1954 он. <https://www.legalinfo.mn/law/details/1293>

⁹ Мянганы хөгжлийн зорилтууд. www.undp.mn

¹⁰ Тогтвортой хөгжлийн зорилтууд. <http://sdg.1212.mn/>

¹¹ Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2005 он. <https://gec.gov.mn/list/79>

нь 2011 онд МУИХСТХ¹²-ийн 27.2-т “Сонгуульд оролцож байгаа нам, эвслээс нэр дэвшиж байгаа хүний 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна” гэдэг заалтыг баталсан. Мөн 2015 оны Сонгуулийн тухай хууль (СТХ)¹³-ийн 126.2-т “нам, эвслээс нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна” заалтыг баталсан. Гэвч УИХ 2016 оны тавдугаар сарын 05-ны өдөр 20 хувь болгож бууруулсан түүхтэй.

Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулийн хүрээнд Улсын Их хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуульд нам, эвслээс нэр дэвшүүлэхэд эмэгтэйчүүдийн квотыг заасан. Үүнд:

- МУИХСТХ¹⁴-ийн 30.2-т нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
- АНСДИТХСТХ¹⁵-ийн 29.2-т нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.

Дээрх хуулийн шаардлагыг хангаагүй нам, эвслийн нэр дэвшигчдийг сонгууль зохион байгуулж байгаа байгууллага бүртгэж авахгүй байхаар хуульчилсан нь уг заалтыг хэрэгжих хөшүүрэг болж иржээ.

Мөн Улс төрийн намын тухай хууль (УТНТХ)-аар залуучууд, эмэгтэйчүүдийн нэр дэвших эрхийг баталгаажуулсан байдаг. Тухайлбал, УТНТХ¹⁶-ийн 5 зүйлд зааснаар намууд үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримтална. Үүнд:

- Үйл ажиллагаагаа ил тод явуулах;
- Гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох үүрэгтэй.

Өөрөөр хэлбэл Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх улс төрийн намууд¹⁷ дээрх зарчмыг баримтлах, намын дүрэмдээ тусгах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэвч намууд залуучууд болон эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх улс төрийн хүсэл зориггүй байгаа харагддаг. Учир нь

- Залуучууд, эмэгтэйчүүдээ бэлтгэх, сургах ажлыг хийдэггүй, намын дэргэдэх ТББ, клубүүдэд даатгадаг.

¹² Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2011 он. <https://gec.gov.mn/list/79>

¹³ Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2015 он. <https://gec.gov.mn/list/79>

¹⁴ Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2019 он. <https://www.legalinfo.mn/law/details/14869>

¹⁵ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль. 2020 он. <https://www.legalinfo.mn/law/details/15125>

¹⁶ Улс төрийн намын тухай хууль. 2005 он. <https://www.legalinfo.mn/law/details/508>

¹⁷ УДШ-д бүртгэлтэй 36 улс төрийн нам байгаа. <http://www.supremecourt.mn/nam>

- Залуу болон эмэгтэй улс төрчдийг олны танил байх, тойрогтоо хүлээн зөвшөөрөгдсөн байх, зардлаа өөрөө хариуцах шаардлага тавигдаг нь бэрхшээл болж байна.

Ийм бэрхшээлийг туулж ирсэн учраас өнгөрсөн гуч гаруй жилд улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх залуучууд, эмэгтэйчүүдийн төлөөлөлд дорвитой ахиц гарахгүй байсаар байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын 430 депутатаас сонгогдсон 50 гишүүнтэй Улсын Бага Хурал нь 1990-1992 онд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд 2 эмэгтэй гишүүнтэй байсан.

№	Хурал	Нийт төлөөлөгчид	Эмэгтэй төлөөлөгчид
1	Ардын Их хурал	430	918 (2%)
2	Улсын Бага хурал	50	219 (4%)

Харин 1992 оноос байнгын ажиллагаатай Улсын Их Хуралтай болсноор залуучууд, эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хуулиар баталгаажсан. Үндэсний статистикийн хорооны мэдээллээс харахад нэр дэвсэн эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байна. УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо нэг үеэ бодвол нэмэгдсэн.

Хүснэгт 2. УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэй улс төрчид

№	Эмэгтэй улс төрчид	1992 он	1996 он	2000 он	2004 он	2008 он	2012 он	2016 он	2020 он
1	УИХ-д нэр дэвшигчдийн тоо		8	9	33	66	174	129	151
2	УИХ-д сонгогдсон гишүүдийн тоо	4	7	9	5	3	11	13	13

1996, 2000 оны УИХ-ын сонгуульд нийт нэр дэвшигчдийн 1.5-2.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол 2004 оны сонгуулиас хойш нэр дэвшигчдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж, 2012 онд хамгийн өндөр 32.0 хувьд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, 2004 оноос өмнөх сонгуулиудад нэр дэвшигч 100 хүн тутмын 2-3 нь эмэгтэй байсан бол түүнээс хойш 14-32 болж нэмэгджээ.

¹⁸ Үндсэн хууль батлалцсан эмэгтэй парламентчдад хүндэтгэл үзүүлэв <http://www.shuud.mn/a/47617> 2012-01-10 нийтэлсэн.

¹⁹ Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо Үндэсний Статистикийн хороо. 2019 он. https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Civil_servants_2019.pdf&ln=Mn

Мөн УИХ-д нэр дэвшигчдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь сонгууль явагдсан онуудаар нэмэгдсэн хандлагыг дагаж сонгогдсон эмэгтэйчүүдийн нийт гишүүдэд эзлэх хувь мөн адил нэмэгдсэн байна. Тухайлбал, УИХ-ын гишүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1992 онд 5.3 хувь байсан бол 2016, 2020 онуудад 17.1 хувь болж өсөж байна.

Гэвч УИХ-д сонгогдсон гишүүдийг нас, хүйсийн төлөөллөөр задлан харахад УИХ дахь сонгогчдын төлөөлөл хөгширсөн, эрэгтэйчүүд давамгайлах хандлага илт харагдаж байна. Үүнийг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 3. УИХ-д сонгогдсон гишүүдийн хүйс, насны бүлэг (хувиар)

№	Статистик үзүүлэлт	УИХ-ын гишүүдийн хүйс	1992 он	1996 он	2000 он	2004 он	2008 он	2012 он	2016 он	2020 он
1	25-35	Эрэгтэй	10.53	25.00	3.95	6.58	1.32	3.95	2.63	1.32
		Эмэгтэй		2.63						
2	36-45	Эрэгтэй	56.58	44.74	23.68	38.16	22.37	27.63	30.26	25.00
		Эмэгтэй	3.95	6.58	10.53	3.95		6.58	5.26	6.58
3	46+	Эрэгтэй	27.63	21.05	60.53	48.68	72.37	53.95	50.00	56.58
		Эмэгтэй	1.32		1.32	2.63	3.95	7.89	11.84	10.53
Нийт			100	100	100	100	100	100	100	100

1992, 1996 оны буюу эхний хоёр УИХ илүү залуучуудын төлөөллөөс бүрдэж байжээ. Өөрөөр хэлбэл, нийт гишүүдийн 50 хувь нь 36-45 насны төлөөлөл сонгогдож байжээ. Мөн 1996 онд сонгогдсон УИХ-ын гишүүдийн 27 хувь нь 25-35 насны залуу үеийн төлөөлөл байжээ.

Харин 2000 оны УИХ -аас эхлэн сонгогдсон гишүүдийн 50-75 хувь нь 46-аас дээс насны төлөөлөл болж байгаа бөгөөд 25-35 насны төлөөлөл буурсаар байгаад 2020 оны УИХ-д нэг ч төлөөлөл сонгогдоогүй байна.

Мөн бид энэ судалгаанд шууд хамааралгүй хэдий ч 1993 оноос хойш болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 7 удаагийн сонгуулийн нээлттэй өгөгдлийг санг судаллаа. Сонгуульд нийт 19 хүн нэр дэвшигч дэвшсэнээс 1 л нэр дэвшигч эмэгтэй байсан бөгөөд энэ нь 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшигч Н.Удвал юм. Тэрээр нийт 1,223,737 сонгогчийн саналаас 80,563²⁰ буюу 6,58 хувийн дэмжлэг авч байсан юм.

Хүснэгт 4. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид

№	Нэр дэвшигч	1993 он	1997 он	2001 он	2005 он	2009 он	2013 он	2017 он
1	Эрэгтэй	2	3	3	4	2	2	3
2	Эмэгтэй	0	0	0	0	0	1	0
Нийт		2	3	2	4	2	3	3

²⁰ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Үндэсний статистикийн хороо. www.1212.mn

Эндээс дүгнэхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн сонгогдох эрх өнгөрсөн онуудад тасралтгүй нэмэгдэж байгаа ч улс төрийн шийдвэр гаргах төвшинд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл дэлхийн болон бүс нутгийн дунджаас доогуур байсаар байна.

Анзаарахгүй орхиж болохгүй зүйл нь 2011 оны МУИХСТХ-д туссан эмэгтэйчүүдийн нэр дэвших эрхийн квотыг хэрэглэснээс хойш эмэгтэйчүүд нэр дэвших, сонгогдох нь илт нэмэгджээ. Гэхдээ л улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн үзүүлэлтээр Дэлхийн болон Азийн дунджаас доогуур байсаар байна

Учир нь 2021 оны байдлаар дэлхийд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 25,5%²¹, Ази тивд 20,5% байна. Харин 40-өөс доош насны төлөөлөл дэлхийн хэмжээнд 15,5%, 30-оос доош насны төлөөлөл 2,2%²²-тай байна.

Мөн бидний анхааран судлах ёстой нэг хууль бол 2011 онд баталсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХТХ) юм. Уг хуулийн 8 зүйлд Улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдлын баталгааг хуулиар зааж²³, бүх улс төрийн намуудад дээрх заалтыг хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байдаг. Үүнд:

- 8.1-д Улс төрийн намд гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 8.2-т Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.
- 8.3-т Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна.
- 8.4-т Улс төрийн нам нь энэ хуулийн 8.2, 8.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийн тайланг энэ хуулийн 18.1-д заасан Жендерийн үндэсний хороонд хоёр жил тутам хүргүүлж байна.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хууль болон бусад хуулиудад залуучууд, эмэгтэйчүүдийг дэмжсэн эрх зүйн орчин бий эсэхийг дүгнэхэд Үндсэн хуулиараа залуучууд, эмэгтэйчүүдийг нэр дэвших эрхийг ерөнхий заажээ.

²¹ Women in politics 2020. IPU. <https://www.ipu.org/resources/publications/infographics/2020-03/women-in-politics-2020>

²² Youth empowerment. IPU. <https://www.ipu.org/our-impact/youth-empowerment>

²³ Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль. 2011 он. <https://www.legalinfo.mn/law/details/253>

МУИХСТХ, АНСДИТХСТХ-иудад эмэгтэйчүүдийн нэр дэвших эрхийг нам эвслийн нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна гэж заажээ.

УТНТХ-д намын үйл ажиллагааны зарчимд шударга, ардчилсан, нас хүйсээр ялгахгүй байхаар заажээ.

ЖЭТБХТХ-д улс төрийн намууд эвлэлдэн нэгдэхэд жендерийн тэгш байдлыг хангах, сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигчдээ намаас хүйс харгалзахгүй дэмжих, намын бүх шатны төлөөллийн байгууллагад аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байх, энэ талаарх мэдээллээ хоёр тутам мэдээлэх үүргийг хүлээлгэсэн байна.

Харамсалтай нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд залуучуудын төлөөлөл буурч байна, эмэгтэйчүүдийн төлөөлөл дорвитой ахиц гарахгүй байсаар байна. Мөн ЖЭТБХТХ-ийн дээрх заалтын дагуу намууд жендерийн хэрэгжилтийн тайланг хийхгүй байсаар байна.

☉ 1.2 Улс төрийн намын дүрэм дэх залуучууд, эмэгтэйчүүдийн улс төрийн сонгуульд нэр дэвших боломж, харьцуулалт

Монгол Улсад үйлчилж буй ерөнхий эрх зүйн орчны хүрээнд сонгуульд оролцох нам, эвслүүд нэр дэвшигчээ тодруулахдаа тус тусын намын дүрэм, журмаар дотоод харилцаагаа зохицуулах үүрэгтэй.

2020 оны УИХ-ын сонгуульд 15 нам, 4 эвсэл, бие даагч нийт 606 нэр дэвшигч өрсөлдсөн. МАН сонгогчдын 44,93 хувийн дэмжлэгээр 62, АН 24,49 хувийн дэмжлэгээр 11, Та бидний эвсэл 8,1 хувийн дэмжлэгээр 1, Зөв хүн электорат эвсэл 5,23 хувийн дэмжлэгээр 1, бие даагч 1 тус тус сонгогдсон.

Хүснэгт 5 2020 оны УИХ-д сонгогдсон нам, эвслийн дэмжлэг, суудлын тоо²⁴

№	Нам	Саналын тоо	Хувь	Суудлын тоо
1	Монгол Ардын Нам	1,795,793	44.93	62
2	Ардчилсан Нам	978,890	24.49	11
3	Та бидний эвсэл	323,675	8.10	1
4	Зөв хүн электорат эвсэл	209,104	5.23	1

Шинээр бүрдсэн УИХ-д 25-35 насны төлөөлөл 1.3 хувь, 36-45 насны төлөөлөл эрэгтэй 25 хувь, эмэгтэй 6.58 хувь, 46-аас дээш насны төлөөлөл эрэгтэй 56.58 хувь, эмэгтэй 10.53 хувь байна. Өөрөөр хэлбэл залуучуудын төлөөлөл 1 сонгогдсон, эмэгтэйчүүдийн төлөөлөл сүүлийн хоёр УИХ дараалан 17,1 хувь байна.

²⁴ 2020 оны УИХ-д сонгогдсон нам, эвслийн дэмжлэг, суудлын тоо. <https://ikon.mn/elections/2020>

УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн 606 нэр дэвшигчдийн 455 нь буюу 75,08 хувь нь эрэгтэй, 151 нь буюу 24,92 хувь нь эмэгтэй нэр дэвшигчид байна.

Үүнээс МАН 76 нэр дэвшигчээс 16 буюу 21,05 хувь нь эмэгтэй, АН 76 нэр дэвшигчээс 17 буюу 22,36 хувь нь эмэгтэй, “Та бидний эвсэл”-ийн 74 нэр дэвшигчээс 17 буюу 23 хувь, “Зөв хүн электорат эвсэл”-ийн 53 нэр дэвшигчээс 16 буюу 32,07²⁵ хувь нь тус тус эмэгтэй нэр дэвшигч байсан.

Улс төрийн намууд МУИХСТХ²⁶-ийн 30.2, АНСДИТХСТХ²⁷-ийн 29.2-т нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна гэсэн заалтыг хүчээр биелүүлж байгаа харагдаж байна.

Харин намууд ЖЭТБХТХ-ийн 8 зүйлд заасны дагуу эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хангах, бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байх, өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байлгах үүргийг хүлээсэн.

Тиймээс МАН-ын дүрэм²⁸, АН-ын дүрэм²⁹, МАХН-ын дүрэм³⁰, ХҮН-ын дүрэм³¹-үүдэд залуучууд, эмэгтэйчүүдийн нэр дэвших боломжийг хэрхэн тусгасан талаар судаллаа. Үүнд:

1. УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх үйл явц, тавигдах шалгуур бий эсэх,
2. Нэр дэвшүүлэхэд залуучууд, эмэгтэйчүүдэд зориулсан квот байдаг эсэх,
3. Намын бүх шатны төлөөллийн байгууллагад нэр дэвшихэд залуучууд, эмэгтэйчүүдэд зориулсан квот байдаг эсэхийг тус тус судаллаа.

Нэр дэвшигчдэд тавигдах шалгуур

Намууд дүрэмдээ нэр дэвших үйл ажиллагааг дэлгэрэнгүй заадаггүй юм байна. Харин бүх нам дүрэмдээ нийцүүлсэн нэр дэвшигчийг тодруулах журам, нэр дэвшигчдэд тавигдах ёс зүйн хэм хэмжээг дүрмээр зааж өгсөн байна.

²⁵ ТАНИЛЦ: АН, МАН-аас сонгуульд нэр дэвшиж буй эмэгтэйчүүд. <https://ikon.mn/n/1vvs> 2020 оны 5 сарын 18

²⁶ Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2019 он. <https://www.legalinfo.mn/law/details/14869>

²⁷ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль. 2020 он. <https://www.legalinfo.mn/law/details/15125>

²⁸ МАН-ын дүрэм. 2017 он. <http://www.nam.mn/rules>

²⁹ АН-ын дүрэм. 2017 он. <http://www.ivote.mn/parties/view/4>

³⁰ МАХН-ын дүрэм. 2019 он. <https://maxh.mn/%D0%BC%D0%B0%D1%85%D0%BD-%D1%8B%D0%BD-%D0%B4%D2%AF%D1%80%D1%8D%D0%BC/>

³¹ ХҮН-ын дүрэм. 2018 он. <http://www.hunnam.mn/?id=248>

Хүснэгт 6 Нэр дэвшигчдэд тавигдах ёс зүйн хэм хэмжээ, шалгуурыг дүрэмд тусгасан эсэх

№	Журам	МАН	АН	МАХН	ХҮН
1	Төр, улс төрийн болон намын удирдах албан тушаалуудад санал болгож сонгогдох, томилогдох гишүүний ёс зүйн хэм хэмжээ	36.1	27.8	38.2	
2	Намаас сонгуульд нэр дэвшигчид тавих шалгуурыг баталсан журам	36.2	27.10	38.3	8.1

МАН, АН, МАХН-ууд УИХ-ын болон орон нутгийн сонгуульд нэр дэвших гишүүн нь намаас тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байхыг шаарддаг. Үүнд:

- МАН “Монгол Ардын Намаас төр, улс төрийн болон намын удирдах албан тушаалуудад санал болгож сонгогдох, томилогдох гишүүний ёс зүйн хэм хэмжээ”
- АН “Намын гишүүний ёс зүй, сахилгын тухай”
- МАХН “Намаас сонгогдож, томилогдох гишүүдийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ”

МАН, АН, МАХН, ХҮН тус бүр сонгуульд нэр дэвшигчдэд тавигдах шалгуурыг журмаар баталсан байна. Үүнд:

- МАН-ын Бага хурлаас баталсан “Намаас сонгуульд нэр дэвшигчид тавих шалгуурын тухай”
- АН-ын ҮБХ-оос баталсан “Гишүүний төрийн улс төрийн албан тушаалд нэр дэвших, сонгох, сонгогдох, томилогдох үйл ажиллагааны тухай”
- МАХН-ын Бага чуулганаас баталсан “Намаас сонгуульд нэр дэвшигчдэд тавих шалгуур тухай”
- ХҮН-ын Удирдах зөвлөлөөс баталсан дотоод сонгуулийн журмыг тус тус баримталж нэр дэвшигчийг тодруулна гэжээ.

Намуудын нэр дэвшүүлэх үйл ажиллагааг шууд харьцуулах боломжгүй, нам бүр өөр өөрийн процедураар зохион байгуулж байна. Тухайлбал

МАН-ын хувьд УИХ-ын болон бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал нэр дэвшигчийг анхан шатны нэгжээс санал авах замаар хэлэлцэж шийдвэрлэдэг байна.

- УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг НАШБ гишүүд болон гишүүн бус иргэдийн өргөн оролцоотой чөлөөт, ардчилсан, шударга өрсөлдөөнт хэлэлцүүлгээр тодруулна. Тодруулахдаа нэг тойрогт 2 нэр дэвшигчийг сонгож Бага хуралд уламжилна. Бага хурал хэлэлцээд уламжилж, Удирдах Зөвлөл эцсийн шийдвэрийг гаргахаар журамласан байна.

- Аймаг, нийслэлийн намын хороо нэр дэвшигчийг хурлаараа хэлэлцэж саналаа нууцаар хураан шийдвэрлэнэ.
- Сум, дүүрэг, хорооны ИТХ-ын төлөөлөгчид нэр дэвшүүлэх асуудлыг сум, дүүрэг, хорооны намын хороо, үүрийн хурлаар хэлэлцэн нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

АН-ын хувьд төрийн болон намын бүх шатны сонгуульд оролцох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй Төрийн сонгууль зохион байгуулах байгууллага /Сонгон шалгаруулах хороо, Тойргийн зөвлөл, Сонгуулийн штаб/, Дотоод сонгууль зохион байгуулах байгууллагатай.

- Сонгон Шалгаруулах Хороо нь намаас төрийн сонгуульд нэр дэвшигчдийг Үндсэн дүрэм, бусад журмын хүрээнд тодруулж шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад уламжлах, шаардлагатай тохиолдолд нэр дэвшилтийн талаар тухайн тойргийн нийт гишүүдийн дунд санал хураалт явуулах тухай санал гаргах чиг үүрэгтэй байгууллага мөн.
- Тойргийн Зөвлөл нь төрийн сонгуульд намыг амжилттай оролцох бэлтгэл хангах, компанит ажлыг зохион байгуулах, төрийн сонгуульд тухайн тойргоос нэр дэвших хүсэлтэй, боломжтой гишүүдийн жагсаалтыг сонгон шалгаруулах хороонд хүргүүлэх, тойрог дахь намын гишүүдийн хүрээнд хэлэлцүүлэг, санал хураалт явуулах үүрэгтэй.
- Дотоод сонгуулийн хороо нь Намын Их Хурлын төлөөлөгч, Намын Дарга, ҮБХ-ны гишүүн, нийслэл, аймаг, дүүргийн намын даргын сонгууль, Ерөнхийлөгч, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг тодруулах сонгуулийг, түүний салбар байгууллага Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо, Сонгуулийн хэсгийн хороо нь нийслэл, дунд, анхан шатны намын хорооны гишүүн, нийслэл, аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох сонгуулийг Үндсэн дүрэм, бусад журмын дагуу зохион байгуулж, дүнг нэгтгэн мэдээлэх, Үндсэн дүрэм, журамд заасан хугацаанд багтаан эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага мөн.

МАХН-ын хувьд шат шатны сонгуульд нэр дэвшигчийг тодруулахдаа намын анхан ба дунд шатны байгууллагын саналыг харгалзан үзнэ.

- УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгохдоо намын дарга, намын Гүйцэтгэх товчоо хамтран санал оруулж, намын Бага чуулган хэлэлцэж, нууц санал хураалт явуулна.
- Нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийн талаар нийслэлийн Түмтийн зөвлөлийн оруулсан саналыг нийслэлийн Түмтийн бага хурал хэлэлцэж, нууцаар санал хураалт явуулах бөгөөд хамгийн олон санал авсан намын гишүүнийг нэр дэвшүүлнэ.

- Аймаг, дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийн талаар намын Мянгатын бага хурал хэлэлцэж, нууцаар санал хураалт явуулах бөгөөд хамгийн олон санал авсан намын гишүүнийг нэр дэвшүүлнэ.
- Сумын ИТХ-ын сонгуульд Хорооны дарга, Хорооны иргэдийн нийтийн хурлын даргад нэр дэвшигчийн талаар намын Зуутын хурлаар хэлэлцэж, нууцаар санал хураалт явуулах бөгөөд олонхын санал авсан гишүүнийг нэр дэвшүүлнэ.

ХҮН-ын хувьд

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг Төлөөлөх зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүнд нэр дэвшигчийг тухайн намын байгууллагын хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, хорооны иргэдийн нийтийн хуралд нэр дэвшүүлэх асуудлыг сум, хорооны намын үүрийн хурлаар шийдвэрлэнэ гэж тус тус заажээ.

Намууд УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдэдээ ямар шалгуур тавьдаг журам тодорхойгүй байна. Хэдийгээр бүх намууд дүрэмдээ журамтай байхыг, журмыг МАН Бага хурлаас, АН ҮБХ-ноос, МАХН Бага чуулганаас, ХҮН Удирдах зөвлөлөөс баталсан байна.

МАН-ын хувьд УИХ, шат шатны ИТХ-д нэр дэвших хүмүүст мэдлэг боловсрол, ажил мэргэжлийн дадлага туршлага, хүнтэй ажиллах арга барил, ёс суртахууны зарчмыг үндсэн шалгуур болгодог³² байна. Мөн МАН-ын гишүүний ёс зүйн дүрэмд заасан дараах зарчмыг мөрдлөг болгоно гэжээ. Үүнд:

1. Тухайн албан тушаалд ажиллахад мэргэжлийн хувьд бэлтгэгдсэн байдал, ажлын дадлага туршлага, идэвх зүтгэл, нэр хүнд, ажлын үр дүнгийн үнэлгээ
2. Хүнтэй ажиллах, удиран зохион байгуулах, манлайлах, ажил гүйцэтгэх, хариуцлага хүлээх, багаар ажиллах чадвар, харилцааны соёл, ёс зүйтэй байх,
3. Олонхын шийдвэрийг хүндэтгэн хэрэгжүүлэх, улс төрийн мэдрэмжтэй байх,
4. Гэмт хэрэгт холбогдоогүй байх

Бусад намуудын хувьд УИХ болон ИТХ-д нэр дэвшигчдэд ямар шалгуур тавьсан нь тод биш байна.

Нэр дэвшүүлэхэд залуучууд, эмэгтэйчүүдэд зориулсан квот байдаг эсэх

³² МАН-ын Хүний нөөцийг бүрдүүлэх, шилж сонгох, дэвшүүлэх, хариуцлага тооцох журам. Бага хурлын 2015 оны 12 сарын сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралт.

МАН, АН, МАХН-уудын дүрэмд залуучууд, эмэгтэйчүүдийг УИХ болон ИТХ-д нэр дэвшихийг дэмжсэн зохицуулалт байхгүй байна.

Харин ХҮН 2020-ны УИХ-ын сонгуульд орохдоо эвслээс нэр дэвшүүлэх дотоод журамд эмэгтэйчүүдийн квотыг МУИХСТХ-д нийцүүлэн тусгажээ.

Харин намын бүх шатны сонгуульд залуучууд, эмэгтэйчүүд нэр дэвшихэд дэмжсэн бодлогыг олон янзаар тусгажээ. Тухайлбал, МАН бүх шатны төлөөллийн байгууллагад эмэгтэйчүүдийг дэмжсэн квотыг хэрэглэж байна. АН зөвхөн Үндэсний бодлогын хороондоо залуучууд болон эмэгтэйчүүдийг дэмждэг зохицуулалттай байна. МАХН болон ХҮН-ын дүрэмд дотоод төлөөллийн байгууллагадаа залуучууд, эмэгтэйчүүдийн квотыг тусгаагүй байна.

Хүснэгт 7 Намын дүрэм дэх залуучууд, эмэгтэйчүүдийн квот

№	Сонгууль	Квот	МАН	АН	МАХН	ХҮН
1	УИХ-ын сонгуульд	Эмэгтэйчүүдийн	-	-	-	-
		Залуучуудын	-	-	-	+
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд	Эмэгтэйчүүдийн	-	-	-	-
		Залуучуудын	-	-	-	-
3	Намын бүх шатны сонгуульд	Эмэгтэйчүүдийн	+	+	-	-
		Залуучуудын		+	-	-

- МАН-ын хувьд дүрмийн 1.5.8-д намын бүх шатны сонгуульд байгууллагад 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна гэж заажээ. Харин залуучуудыг дэмжсэн зохицуулалт байхгүй байна.
- АН-ын хувьд дүрмийн 13.5-т ҮБХ-ны гишүүний бүрэн эрх 4 жил байна. ҮБХ-ны гишүүний суудалд төрийн сонгуулийн өмнөх жилээс бусад жилд тогтоосон хуваарийн дагуу эргэлт /ротаци/-ийн сонгууль явуулна. / бүрэн эрхийн эхний жилд 1 суудалд, дараагийн жилд 1 суудалд болон залуучуудын суудалд, гуравдах жилд 1 суудалд болон эмэгтэйчүүдийн суудалд/. УИХ-ын гишүүн бүрэн эрхийн хугацаандаа ҮБХ-ны эргэлтийн сонгуульд орохгүй гэж заажээ.
- ХҮН-ын хувьд 2020 оны УИХ-ын сонгууль “Электорат” эвсэл байгуулж оролцсон бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуульд “Зөв хүн электорат” эвслээс нэр дэвшүүлэх дотоод журмын 2.1.4-т эвслээс нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх гэж заасан байна.

Улс төрийн намуудын дүрэмд нэр дэвшигчийг тодруулах үйл явцыг журмаар зохицуулсан боловч журам нь нууц байна.

Нэр дэвшигчдэд ёс зүйн болон нийтлэг шалгуур тавих журам мөн нууц байна.

Улс төрийн намууд дүрэм, журамдаа жендерийн эрх тэгш байдлыг хангах зохицуулалтууд дутуу, хэлбэр төдий байна.

Намууд УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуульд зориулж залуучууд, эмэгтэйчүүдийг дэмжсэн эрх зүйн орчин байхгүй байна. ХҮН л УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг торуулах “Электорат” эвслийн дотоод журамдаа 20 хувийн дэмжлэгийг МУИХСТХ-д нийцүүлэн оруулжээ.

МАН, АН-ууд дотоод бүтцийн байгууллагуудад залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн ялгаатай аргыг ашиглаж байна. Бусад намуудын дүрэмд залуучууд, эмэгтэйчүүдийг дэмжсэн зохицуулалт тусаагүй байна.

2020 оны УИХ болон орон нутгийн сонгуульд намуудын нэр дэвшигчээ тодруулсан процессын нийтлэг зураглал

Намууд нэр дэвшигчийг тодруулахдаа дүрэм журам хэрэглэдэг үү? Түүнийгээ мөрддөг үү?	Таныг нэр дэвшихэд хамгийн чухал дэмжлэг болсон хүн, бодлого, хүрээлэл байсан уу?	Нэр дэвшигчийг тодруулах гол шийдвэр хаана гарсан бэ?
Дүрэм журмын хувьд бол нэгдүгээрт намын дүрмээрээ, хоёрдугаар тухайн орон нутагтаа танигдсан хүн гэдгээ бодлогоор дэмжсэн. /МАН-ын гишүүн, эмэгтэй, НИТХ-н төлөөлөгч/	НАМЗХ-ын дарга маань маш их нөлөөлсөн. Дээрээс нь намын хорооны тэргүүлэгчид, гишүүд маань нэлээн сайн дэмжсэн. Дарга нар ч гэсэн адил. Ер нь тал талын л бүх талын дэмжлэгийг авсан даа. /МАН-ын гишүүн, эрэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, 36 настай/	Намын дарга дээр гарсан. Албан бусаар баталгаажуулаад, байгуулсан комисс дээрээ ирж танилцуулаад л явчихсан. Хүмүүсийн саналыг хүлээж аваагүй. /АН-ын гишүүн, эмэгтэй, УИХ-д нэр дэвшигч, 50 настай/
Дүрэм журмаа бидэнд гарт өгдөггүй. Хурал дээр дэлгэцээр харуулдаг ч уншиж тунгаах боломж олгодоггүй. Хурлын дараа ямар дүрэм дээр өөрчлөлт, санал оруулсан нь ч тодорхой бус байдаг. /АН-ын гишүүн, эмэгтэй, УИХ-ын сонгуульд нэр дэвшигч, 50 настай/	Надад бол намын гишүүд маань дэмжлэг үзүүлсэн. Мөн нэг бизнесмен надад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Гэхдээ зөвхөн хувь хүн гэдэг талаас л дэмжсэн. /АН-ын гишүүн, эмэгтэй, дүүргийн ИТХ-д нэр дэвшигч, 35 настай/	Намын дарга дуудаж уулзаад нэр дэвших үү гэсэн. Би хэд хоног бодож үзээд дэвшье гэдгээ хэлсэн. Миний хувьд бол үндсэндээ намын даргатай уулзаад дэвших эсэх маань шийдэгдсэн. /МАН-ын гишүүн, эрэгтэй, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, 30 настай/
За яах вэ, дүрэм журам гэдэг зүйл хэрэгжинэ. Гэхдээ 100 хувь хэрэгжүүлдэг гэвэл мэдээж үгүй. Тэгээд тэр дунд нөгөө л тодорхой санхүүтэй гэдэг юм уу, мөнгөний боломжтой тийм хүмүүс ар өврийн хаалгаар хүч түрэн орж ирэх зүйл бол ажиглагддаг. /МАН-ын гишүүн, эрэгтэй, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, 30 настай/	2016 оноос хойш гэхээр одоо аймгийн засаг дарга хийж байгаа хүн байгаа. Энэ хүн бол намайг залуу хүнд бол боломж олгоно гээд дэмжсэн. 2012 оноос хойш өдийг хүртэл бид 2 хамтарч ажиллаж байгаа. Боломж олгосон итгэлийн алдахгүй гээд хичээж явна даа. /МАН-ын гишүүн, эрэгтэй, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, 30 настай/	Нэр дэвшүүлэх гол шийдвэр бол манай аймгийн намын тэргүүлэгчдийн хүрээнд болж байгаа юм. Энэ нь 25 хүнтэй, ерөнхийдөө нэг нэр дэвшүүлэлтийн бол бараг 70 хувийг нь ярилцаад шууд шийдчихэж байгаа. Гэхдээ яг албан ёсоор албан ёсны шийдвэр бол аймгийн намын хорооноос гарч байгаа. /АН-ын гишүүн, эрэгтэй, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, 34 настай/
Манай нам дээр нэр дэвшүүлэх журмын дагуу л явагддаг. Эцсийн шийдвэрийг үндэсний хороогоор шийдвэрлэдэг. /АН-ын гишүүн, эмэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, 35 настай/	Яг хүрээлэл гэх юм бол яг залуучуудын байгууллага байна. Мэдээж би нөгөө талдаа намын дэд дарга учраас аймгийн намын дарга маань шууд улс төрийн дэмжлэг үзүүлсэн. /АН-ын гишүүн, эрэгтэй, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, 34 настай/	Дүүргийн намын хороо, дүүргийн бага хурлын гишүүд. Тэнд дүүргийн намын дарга бодлогоо тодорхойлдог. Энэ, энэ хүнийг дэвшүүлбэл зовлонгүй гараад ирнэ гээд. Тэр бодлогоо тэргүүлэгчдийн хурлаар оруулаад намын бага хурлаар хэлэлцүүлээд тэндээсээ 35 хүнээ сонгуулаад нэгдсэн сонгууль болоод түүнээс гарч ирнэ. Тэгээд ер нь тэргүүлэгчдийн 9 хүнээр л хэлэлцүүлээд тодорхойлно. /МАН-ын гишүүн, эмэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч/
Дээд түвшинд удирдлагад байгаагүй болохлоор сайн мэдэхгүй байна. Гэхдээ тодорхой шаардлага тавиад бид нарт ёс зүйг баримтлах, сонгогдсон тохиолдолд авлига хулгайн хэрэгт оролцохгүй, улс эх орны эв нэгдлийг хангана, намын дотоод эв нэгдлийн хангана гэх мэт гэрээ байгуулж байсан. /ХҮН-ын гишүүн, эрэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, 37 настай/	Миний хувьд бол хүрээлэл нь байсан. Яагаад гэвэл би нэг хороон дээр 20-оод жил анхан шатнаас нь эхлээд ажиллаж байсан учир нөхцөл байдлаа бүгдийг нь мэдэж байсан. /МАН-ын гишүүн, эмэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, 52 настай/	Сонгууль дөхөөд ирэхээр бужигнаад л байсан. Хамгийн сүүлийн өдөр л гаргасан шүү дээ. Бараг удирдлагууд гаргачхав уу гэж бодсон. /АН-ын гишүүн, эмэгтэй, УИХ-д нэр дэвшигч, 43 настай/

Та нэр дэвших тойргоо өөрөө сонгосон уу?	Та нэр дэвшихдээ намдаа дэнчин, эсхүл хандив төлж байсан уу?	Танай намын 2020 оны сонгуульд нэр дэвшүүлэх үйл явц ардчилсан, ил тод байсан уу?
<p>Өрсөлдөөн шахалт байсан. Гаднаас хүн орж ирэх гээд байсан. Би намын хорооны даргад би 8-р хорооны 3-р үүрийн дарга эндээ л дэвшмээр байна гэдгээ хэлсэн. Миний саналыг хүндэтгэсэн. Эхэндээ бол бараг хасаад хаячихсан байх шиг байсан. Нэр дэвших хүсэлтээ өгсөн ч гэсэн тэрнийхээ араас хөөцөлдөх шаардлагатай. /МАН-ын гишүүн, эрэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч/</p>	<p>Төлж байсан, энэ бол аль ч улс төрийн намд байдаг зүйл, дэнчин гэдэг нь тухайн сонгуульд нэр дэвшинэ ээ одоо хариуцлага үүрнэ гэдгээ хүлээж байгаа юм. Би дэвшинэ гэдэг нь одоо хувиасаа дэвшчихээд байгаа асуудал биш намын өмнөөс намын мянга мянган гишүүдийн өмнөөс хариуцлага хүлээж байгаа асуудал болохоор дэнчин төлж байсан. 5 сая төгрөг байсан дүүргийн сонгууль дээр. /АН-ын гишүүн, эрэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, 31 настай/</p>	<p>Ил тод байж чадсан. Яагаад гэвэл бас судалгаа явуулсан шүү дээ. Жишээлбэл 17 эмэгтэй дэвшиж байгаа. Квотоороо дэвших эрхээ авсан. За гуч гаруй эмэгтэйдээ арван долоо нь эрхээ авч байна. Нэг өдөр гучин хэдэн эмэгтэй дотроо эмэгтэйчүүдийн рейтингийн судалгаа хийгээд үр дүнг нь харуулсан. Хэдийгээр мөнгөний дэнчин байсан ч гэсэн тэр судалгаа нэр дэвшүүлэхэд нөлөөлсөн. /АН-ын гишүүн, эмэгтэй, НИТХ-ын сонгуульд нэр дэвшигч/</p>
<p>Сонгож чадаагүй. Тэгш байх боломжгүй юм шиг надад санагдсан. Зоргоороо би энийг сонгоё гэдэг сонголт бол байх боломжгүй. /АН-ын гишүүн, эмэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч /</p>	<p>Бид нараас дүүргийн намын хороон дээр тус бүр 3 сая төгрөг авсан. Тэр нь сонгуулийн штабын зардал, хэвлэл сонинны мөнгө гэж байсан. /МАН-ын гишүүн, эмэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, 52 настай/</p>	<p>Огт болоогүй. Манай намын дотоод ардчилал маш муу байсан. Унаган тамираараа бол дотоод ардчилалтай. Гэхдээ дотоод ардчиллаа устгаад байгаа. /АН-ын гишүүн, эрэгтэй, нэр дэвшигч, 34 настай/</p>
<p>Ер нь бол санал өгсөн, тухайн үед хоёр баг хэлээд надад за, энэ нь боломжтой юм байна гээд чи одоо сонго гэдэг л юм байна лээ л дээ. Одоо илүү олон хүн таньдаг уу, хийсэн ажилтай ч гэдэг юм уу, тийм тойрог чамд байна уу гэж надаас бас асуусан. Зарим хүмүүсийн хувьд бол тэгээд олдсонд нь сонголтгүйгээр очдог л юм байна лээ л дээ. /МАН-ын гишүүн, эмэгтэй/</p>	<p>Байхгүй. “Зөв хүн академи” гэж зохион байгуулж, хүмүүсийг уриад түүн дээрээ сургалт хийж, тэндээсээ хэрвээ амбицаа илэрхийлэх юм бол дэвшиж болно гэж явдаг. Түүнээс биш мөнгө аваад дэвшүүлэх өгдөг юм байхгүй. Цаашдаа ч байхгүй байх болов уу л гэж бодож байна. /ХҮН-ын гишүүн, эрэгтэй, 44 настай/</p>	<p>Ер нь ил тод байгаагүй. Намын хороон дээрээсээ нэр дэвшигчид тодорч гарна гэж байгаа. Нэр дэвшигчдээ зарлаад. Гэтэл ингэх үү тэгэх үү гэсэн хэлэлцүүлэг байхгүй. Шууд гарч ирээд л нэр уншина. Тэгээд л дуусаа. Тэрийг батална. Ардчилсан байдал байхгүй. 100 хүн оруулж ирээд тэндээсээ шигшээд авдаг бол болж байгаа юм. Тэгэхгүй байна. дөчин хэдэн хүнээ оруулж ирээд л шууд нэрийг нь хэлээд баталсан. /МАН-ын гишүүн, эрэгтэй, аймгийн ИТХ-ын төлөөлөгч/</p>

<p>За одоо би өөрөө сонгосон гэж хэлж бол чадахгүй. Яах вэ зүгээр санал болгосон, би өөрөө тэндээ амьдардаг байсан учраас. Тэгээд 2016 онд бол яг Монгол ардын намаас тэнд дэвших хүн байгаагүй. Тийм учраас би энэ саналыг нь хүлээж авсан. /МАН-ын гишүүн, эрэгтэй, аймгийн ИТХ-д нэр дэвшигч/</p>	<p>Дэнчин өгсөн. Эмэгтэй нэр дэвшигч 10 сая, эрэгтэй нэр дэвшигч 15 сая өгсөн. Адилхан 15 байж байгаад эмэгтэйчүүдийнхийг 10 сая болгосон. Надад аятайхан л санагдсан. Нэгдүгээрт хуулийн шалгуурын материалуудаа бүрдүүлнэ. Тэгээд намынхаа дэнчинг өгч байж анхан шатанд нэр дэвших эрхээ авдаг, баталгааждаг. /АН-ын гишүүн, эмэгтэй, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч/</p>	<p>Учиргүй тийм ил дотоод ардчилсан бол байгаагүй. Энэ эхлээд намын даргын бодлого гэдэг юм заавал орж ирдэг. Ингэхлээр би нэр дэвших хүсэлтэй байвч намын даргын бодлогод нэр орж ирэхгүй байх тохиолдол байна. Тэгэх юм бол би заалнаас нэр дэвшиж болно. Намын даргын нэр дэвшилтэд ороод ирсэн бол заалнаас нэр дэвшсэн хүнтэй би нэр өрсөлдөнө гэсэн үг. Нэгдүгээрт, заалнаас нэр дэвшиж байгаа бол ардчилсан гэж бид хэд харж байгаа юм. Намын дарга өөрөө нэрээ гаргахдаа яаж гаргаж байгаа гэдэг нь ил тод биш байдаг.</p>
<p>Ерөөсөө сонголт бол байгаагүй. Шууд томилгоогоор явсан. Тэр тойрог дээр яв.Тэр тойрог нь залуу хүнийг тавьчихъя гэсэн ялах магадлал багатай торгуулийн суманд тавьж байсан. Тэр бол миний хувьд том сорилт байсан. Тэрнээс өөр миний өсөж төрсөн нутаг тэнд .Миний төрсөн нутаг тэр , ах дүү хамаатан садан тэнд их байдаг маягаар залуучууд ялангуяа миний хувьд сонгогдоход туйлын хүнд. Үнэхээр зоригтой ч байсан , хаашаа яв гэнэ тэр газар нь очъё гэсэн маягтай явсан. Тэгээд очоод сонгогдож байсан. / МАН-ын гишүүн, эрэгтэй аймгийн ИТХ-ын төлөөлөгч/</p>	<p>Төлсөн. Минийх бол 100 саядаа хүрээгүй. Яагаад гэвэл эхнийхээ хэсгийг төлж байгаад бүдрэх нь тодорхой болчихсон байхгүй юу. Бас 100 сая аа төлөөд хохирсон хүн ч нэг их байхгүй. Дийлэнх хэсэг нь 100 саяар зүгээр шоудсан. Тойргоо авахгүйгээ ч мэдэж байсан. /АН-ын гишүүн, эрэгтэй, УИХ-н сонгуульд нэр дэвшигч /</p>	<p>/МАН-ын гишүүн, эмэгтэй, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, 25 настай/</p>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

◎ 1.3 Улс төрч залуучууд эмэгтэйчүүдийн амжилтад институтийн хүчин зүйл нөлөөлөх нь (чанарын судалгааны үр дүн)

Сонгуульд залуучууд, эмэгтэйчүүд нэр дэвшихэд ерөнхий болон корпоратив эрх зүйн орчин нь сайн дэмждэггүй юм байна гэдгийг өмнөх хэсгүүдэд дүгнэсэн. Ердөө МУИХСТХ-ийн 30.2 болон АНСДИТХСТХ-ийн 29.2 дахь нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх заалтыг мөрдөж байна. Гэхдээ МАН, АН-уудын хувьд уг заалтыг хангах төдий хэрэглэж байна.

1.3.1. Эрх зүйн болон институтийн хүчин зүйлсийн нөлөө.

Улс төрийн намууд залуу болон эмэгтэй улс төрчдийг нэр дэвшүүлэх асуудалд улс төрийн манлайлал үзүүлэх дургүй байгаа нь хууль, эрх зүйн тогтолцоо болон улс төрийн намуудын төлөвшилт болон санхүүгийн зэрэг институтийн хүчин зүйлс нөлөөлж байна.

Эрх зүйн тогтолцоо. УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуульд залуучууд, эмэгтэйчүүдийг дэмжсэн эрх зүйн орчин хангалтгүй байна. Үүнд:

1. Сонгуулийн тогтолцоо залуучууд болон эмэгтэйчүүдийг дэмждэггүй,
2. Улс төрийн намууд сонгуулийн хуульд байгаа хүйсийн квотыг доод хязгаар гэж ойлгохгүй, тулгаж хэрэглэж байна.

Монгол улс 1992 оноос хойш УИХ болон орон нутгийн ИТХ-ын сонгуульд сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцоог хэрэглэж ирсэн. Тодруулбал, УИХ, ИТХ-ын 1992, 2008, 2020 оны сонгуулиудад олон мандаттай том тойргийн тогтолцоог, 1996, 2000, 2004, 2016 оны сонгуулиудад нэг мандаттай жижгэрүүлсэн тойрог, 2012 онд олонх дийлэнхийн болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулан хэрэглэсэн байдаг. Бүхэлдээ сонгуулийн олонх дийлэнхийн тогтолцоог хэрэглэж ирсэн улсын хувьд улс төрийн намуудын төлөвшилд сул, нэр дэвшигчдээс их хэмжээний хөрөнгө зарцуулахыг шаарддаг, сонгогчдын саналыг худалдаж авдаг учраас залуу болон эмэгтэй улс төрчид шударгаар өрсөлдөх, сонгогдох боломж хязгаарлагдмал байна. Мөн сонгогчид саналаа өгөхдөө намыг бус хүнийг харж сонголтоо хийдэг болсон учир улс төрчид олны танил байх, сонгуулийн ба сонгуулийн бус үед өөрийгөө таниулахыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл, залуу болон эмэгтэй улс төрчид улс төрийн шийдвэр гаргах түвшинд сонгогдох боломж хязгаарлагдмал байгаа нь сонгуулийн тогтолцооноос шууд хамаарч байна гэж судалгаанд оролцогч үзэж байна. Үүнийг тодруулах зорилгоор судалгаанд оролцогчдын хариултыг харвал:

- ХҮН-ын гишүүн: *Хамгийн түрүүнд сонгуулийн хуулийн хамгийн том хязгаарлалт бол мажоритар тогтолцоо шүү дээ. Мааш яаралтай 100 хувь пропорциональ болж чаддаггүй юмаа гэхэд холимог тогтолцоо руу шилжих ёстой. Пропорциональ тогтолцоо л залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог*

нэмэгдүүлнэ. Мөн сонгуулийн зардлыг өсгөөд байдаг заалтуудыг авч хаях ёстой. Хэвлэл мэдээлэл дээр том хязгаарлалт байдаг. Зардлыг СЕХ эсвэл төсвөөс ижил боломж бүрдүүлэх хэрэгтэй. (48)

Мөн МУИХСТХ, АНСДИТХСТХ-д байгаа нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь аль нэг хүйсийн төлөөлөл байх хуулийн квот хэдий байгаа ч цаашид нэмэгдүүлэх ёстой гэж Нийслэл болон орон нутгийн улс төрчид үзэж байна.

• МАН-ын гишүүн: Квотыг дээд хязгаар гэж ойлгогчоод байдаг нь нэг талаараа саад болоод байгаа. Ухуулагч нарт урамшуулал өгөхийн тулд их мөнгө зарцуулдаг. Энийг сонгуулийн хуульд хориглож, зөвхөн хоол, нэгжний зардал хариуцна гэх, сайн дурынхныг ажиллуулах зэргээр тодорхой зааж өгөх хэрэгтэй. (2)

Улс төрийн намын төлөвшилт: Монгол Улсын Дээд Шүүхэд бүртгэлтэй улс төрийн 36 нам үйл ажиллагаа явуулж байна. Улс төрийн нам, намын системийн төлөвшилт нь сонгуулийн тогтолцооноос шууд хамааралтай байдаг. Судлаач М.Дювержигийн үзсэнээр сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцоо нь хоёр намын системийг төлөвшүүлдэг бол хувь тэнцүүлсэн тогтолцоо нь плюраль намын системийг төлөвшихөд нөлөөлдөг гэж үздэг. Тэгвэл Монгол улсын хэрэглэж ирсэн сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцоо нь МАН, АН гэсэн олонхын дэмжлэг авдаг намын системийг бий болгожээ. Гэвч намуудын өрсөлдөөн, чадавхын тэнцвэргүй байдал нь дотоод ардчилал сул байх, дүрэм, журмыг хэрэгжилтийг сулруулах, ил тод биш байхад нөлөөлж байна.

Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалт. Намууд дотоод бүтэц, зохион байгуулалтаараа залуу болон эмэгтэй улс төрчдийг дэмждэггүй. ЖЭТБТХ-ийн 8.3-т заасны дагуу төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байх заалтыг л хэрэгжүүлж байна. Судалгаанд оролцогчид залуучууд, эмэгтэйчүүдийг хүчтэй, зоригтой байхыг хүсэж байгаа ч, намын үйл ажиллагаанд оролцох, сонгуульт гишүүн болох зэрэг нь залуу болон эмэгтэй улс төрчдөөс санхүү ихээхэн шаардаж байгаа нь харагдлаа. Хамгийн сонирхолтой нь дунд шатны улс төрчдийн хувь залуу, эмэгтэй байхаас илүү нам доторх фракц улс төрийн карьерыг тодорхойлж байгаа, шат шатны намын дарга нарын дэмжлэггүй бол улс төрчдийн карьер зогсонги байдалд орох хандлага ажиглагдаж байхад үндэсний түвшний улс төрчид намын зохион байгуулалт залуу болон эмэгтэй улс төрчдөд саад болдоггүй, харин өөрсдөө л хүчтэй байх, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

- Үндэсний түвшний улс төрчид:

МАН-ын гишүүн (эмэгтэй): Намд байгаа эмэгтэйчүүд боловсрол эсхүл нийгмийн капитал, санхүүгээр жаахан голлогддог. Эмэгтэйчүүд зориг муутай. Улс төрч хүн чинь тэмцэгч байх ёстой. Тийм чанар бага байна.

АН-ын гишүүн (эрэгтэй): Манайх үе хооронд дэмжлэг байдаггүй, лидерийн ур чадвар дээр босдог нам. Тиймээс нэг лидерийн үе дуусан дуустал дараагийн лидер гарч ирж чаддаггүй. Гэхдээ нэг босоод ирсэн лидер удаан хугацаанд байдаг. АН-ынхан хөрвүү аргаар өсдөг. (40)

МАХН-ын гишүүн: Намын толгой дээр хэдэн том дарга нар суучаад доошоо үүрэг, даалгавар өгөөд сууж байдаг. Тэгэхээр залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоо сул байх нь аргагүй.

- Орон нутгийн түвшний улс төрчид:

Нийслэлийн МАН-ын гишүүн: Намд ороод өөрийнхөө орон зайг бий болгох боломж хангалттай байдаг. Гол нь өөрийн сэдэвтэй болох чухал байдаг. Түүгээр өөрийн имиждээ бүрдүүлдэг.

Нийслэлийн АН-ын гишүүн: Сөргөөр ажиглагдсан юм ерөөсөө байдаггүй. Бодит амьдрал дээр мөнгөний босго тавьдаг. Үгүй бол квотын босго байдаг. Сая 2020 оны сонгууль дээр АН дээр яригдаж байсан. Энэ бол том хаалт болдог.

Өвөрхангай аймгийн МАН-ын гишүүн: Яг намд орж ирээд аль гайгүй фракц руу орохгүй бол тэр хүний улс төр амжилт олохгүй. Ямар фракцад орохоос үндсэндээ амжилттай явах нөхцөл бүрдэнэ. Тэгэхээр залуучууд, эмэгтэйчүүдийн хувьд төвөгтэй.

Ховд аймгийн АН-ын гишүүн: Намын ахмад үе нь залуу үеэ хүлээн зөвшөөрөхгүй байх, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээ хүлээн зөвшөөрөхгүй байх асуудал нэлээд байдаг.

Залуучууд, эмэгтэйчүүдийг дүрэм, журмаар дэмждэггүй. Улс төрийн намууд дотоод дүрмээрээ залуу, болон эмэгтэй улс төрчдийг дэмжсэн зохицуулалт байхгүй. Зөвхөн МУИХСТХ, АНСДИТХСТХ-ийн нэр дэвшигчдэд тавигдах квотын заалт л нөлөөлдөг гэж хариулжээ.

Үндэсний түвшний буюу УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн улс төрчдийн хариултаас харахад улс төрийн намууд залуу болон эмэгтэй улс төрчдийг дэмждэггүй. Тэдний хариултыг дэлгэрүүлж үзвэл:

Үнэндээ фракцын нөлөөгөөр явчихдаг. (эмэгтэй, АН-ын гишүүн) Намын дүрэмд дэмжлэг байхгүй. Сонгуулийн хуулийн квот л байдаг. Үүнийг хангалттай дэмжлэг гэж харахгүй байна. (эмэгтэй, МАХН-ын гишүүн) Харин ХҮН-ын гишүүн: Намын дотоод журам дээр квот бий. Гэхдээ бид энийг аль болох 50/50 хувь болгох гэж зорьж ажилладаг. Харамсалтай нь эмэгтэйчүүд орж ирэхгүй байна. Мөн манай нам чинь залуучууд шүү дээ. (эрэгтэй, ХҮН-ын гишүүн)

Орон нутгийн ИТХ-ын сонгуульд МАН, АН-аас бусад намууд мандатаа дүүртэл нь нэр дэвшүүлж чадаагүй. Залуучууд, эмэгтэйчүүдийн дэмжлэгийн тухайд:

- Нийслэлийн АН-ын гишүүн: Залуучууд, эмэгтэйчүүд олны танил болоогүй байдаг тул хүссэн тойргийг нь өгөхгүй тохиолдол бий. Дэнчингээ төлөх боломж тааруу байхад нь нөхөн төлөх дэмжлэг мөн бий.
- Нийслэлийн ИЗН-ын гишүүн: Манай нам эмэгтэйчүүдээ дэмжиж квотыг дүрэмдээ заасан. Харин залуучуудын квотыг хуульчлаагүй.
- Нийслэлийн ХҮН-ын гишүүн: Харьцангуй шинэ нам болохоор нэр дэвших эрхээ авахын тулд дотроо өрсөлдөх нь бага. Сая УИХ-ын сонгуулиар ч гэсэн бид хоёр өөр намтай эвсэл болж орсон. Тэгсэн ч гэсэн 53 хүнийг л нэр дэвшүүлж чадсан.
- Сүхбаатар аймгийн МАН-ын гишүүн: Эмэгтэйчүүдийн квот өгдөг төдий дэмжлэг байгаа. 30 хувиас доошгүй байх ёстой. Залуучуудын хувьд ч бас иймэрхүү байгаа. Дүрэмдээ зааж өгөөгүй ч залуучуудыг дэвшүүлдэг.
- Өмнөговь аймгийн МАН-ын гишүүн: Тийм дэмжлэг байхгүй. Одоо ч залуучууд эмэгтэйчүүдийн төлөөллийг хангана гэсэн тодорхой заалт байхгүй.
- Өмнөговь аймгийн АН-ын гишүүн: Сонгуулийн менежментэд дэмждэг. Тухайлбал хэвлэл мэдээллээр дэмждэг.

Намын дэргэдэх залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагын үүрэг. Намын дэргэдэх Залуучууд, Эмэгтэйчүүдийн байгууллага нь нас болон хүйсээр гишүүдийг ялгаж, намын ажилд татан оруулах, улс төрийн боловсрол олгох, өөрсдийн төлөөллийг намын болон бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, төлөөлөгчөөрөө дамжуулан улс төрийн шийдвэр гаргах түвшинд оролцох үүрэгтэй. Судалгаанд оролцогчид намын дэргэдэх байгууллагуудыг чухал үүрэгтэй гэж үзэж байхад ХҮН-ын улс төрч ийм байгууллага байхыг дэмждэггүй, гол нам дотроо олон фракцад хуваагдах, гишүүний ёс зүй алдагдах аюултай. Манай нам бол залуучуудын нам гэж онцолж байна.

Нийслэлийн улс төрчид намын дэргэдэх залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллага маш чухал боловч үүргээ гүйцэтгэдэггүй гэж хариулж байна.

- МАН-ын гишүүд: Ер нь намын дэргэдэх ТББ-ын дарга нь хэн байх вэ гэдгээс их юм хамаарна. Залуучууд бие биеэсээ суралцах боломж байгаа, тэр нь чухал (ДИТХ-ын төлөөлөгч, эмэгтэй). Ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй. Залуучуудын холбооныхон бэлэн юманд дуртай, сургууль төгсөж ирээд дарга болох сонирхолтой. Намын дэргэдэх байгууллагын нөлөө бага. (ДИТХ-ын төлөөлөгч, эрэгтэй)
- АН-ын гишүүд: Маш чухал. Эмэгтэйчүүдийн байгууллагыг дарга, гишүүн

бол тэндээс зохион байгуулж байгаа сургалтад суудаг, нийгмийн идэвхээ харуулдаг, баяраа хамтаар тэмдэглэдэг. Энэ бол сайн зүйл. (эмэгтэй, дүүргийн намын хорооны гишүүн)

Харин орон нутгийн улс төрчид намын дэргэдэх залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагыг чухал, үүргээ гүйцэтгэдэг, энэ байгууллагад элсэх, үйл ажиллагаанд нь оролцох нь цаашид давуу тал болдог гэж харж байна.

1.3.2. 2020 оны УИХ-ын болон ИТХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх үйл явц ба залуучууд, эмэгтэйчүүд

2020 оны УИХ-ын болон ИТХ-ын сонгууль олон мандаттай том тойргийн тогтолцоогоор явагдсан. Энэ тогтолцоо нь залуу болон эмэгтэй нэр дэвшигчдэд хатуу, олны танил болохын тулд санхүүжилт их шаарддаг. Дээр нь намуудын төлөвшил муу, ардчилал хангалтгүй, нам нэр дэвшүүлэх үйл ажиллагаа ил тод шударга болоогүй гэж үзэж байна. Тиймээс намууд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг дүрэм, журмын хүрээнд зохион байгуулсан эсэх, залуучууд эмэгтэйчүүдийг дэмжсэн бодлого байсан эсэхийг бүх шатны сонгуульд нэр дэвшсэн, өрсөлдсөн, нэр дэвших эрхээ авч чадаагүй улс төрчдөөс тодруулсан юм.

Намууд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг дүрэм журмын хүрээнд зохион байгуулсан эсэх. Судалгаанд оролцогчдын байр суурь ялгаатай байсан бөгөөд ажиглахад нэр дэвших эрхээ авсан улс төрчид ардчилсан болсон, дүрэм журмаа сайн хэрэглэсэн гэж үзэж байна. Харин нэр дэвших эрхээ авч чадаагүй улс төрчид ардчилалгүй байсан, шударга бус болсон гэж дүгнэж байна. Мөн орон нутгийн түвшний ардчилалгүй болсон, хэлбэр төдий зохион байгуулсан, дүрэм, журмаа хэрэглээгүй гэж үзэж байна. Тухайлбал,

- АН-ын гишүүд: *Олонх нэр дэвшүүлэх үйл явц ардчилсан, ил тод явагдаагүй гэж үзэж байна. Харин зарим нь нэр дэвшүүлэхдээ судалгаан дээр тулгуурлаж шийдвэр гаргасан. Тухай бүрд нь судалгаа танилцуулж байсан. Судалгаан дээр тулгуурлаж нэр дэвшигч тодорсон. (эмэгтэй, ҮБХ-ийн гишүүн)*
- МАН-ын гишүүд: *Нэр дэвшилт нэлээд ширүүн байсан. Нэг их ардчилсан байгаагүй. (46, 47)*
- ХҮН-ын гишүүн: *Хамгийн ардчилалтай нь манайх байсан байх. Манайх нь 5 жилийн түүхтэй нам шүү дээ. (48) Ардчилсан болсон. Гэхдээ Электорат хөдөлгөөнтэй эвссэн учир бас нөлөө орсон. (49)*

Нийслэлийн ИТХ-ын сонгуульд АН, МАН-аас өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид бүгд ардчилсан байгаагүй гэж хариулсан. Харин ИЗН МАХН-тай эвсэж орсон тул үзэл баримтлалын зөрүү их байсан. Намууд тойргоо хуваагаад авсан учир тойрогтоо бэлтгэлээ хангаж байсан улс төрчдийн хувьд хүнд байсан гэж хариулж байна. Гэтэл ХҮН-ын нэр дэвшигчид ардчилсан нээлттэй байсан гэж хариулж байна.

Аймгийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид МАН, АН-ын нэр дэвших үйл явц ардчилсан болоогүй, болсон гэдэг янз бүрээр гэж хариулж байна. Өөрөөр хэлбэл, орон нутгийн төвшинд ардчилалгүй, хэлэлцдэггүй, санал авсан нэр төдий зохион байгуулдаг гэсэн дүгнэлт түгээмэл байна.

- МАН-ын гишүүн: Намын хороон дээр хэлэлцүүлэг болсон. Дарга индэр дээрээс дээш нь уламжлах хүний нэрийг уншсан. Тэгээд л болоо. Юун ардчилал, хэлэлцэх тийм юм болоогүй. (Өвөрхангай аймгийн МАН-ын гишүүн) Аймгийн хэмжээнд ардчилсан байж чадсан. Бусдыг нь мэдэхгүй байна. (Өвөрхангай аймгийн МАН-ын гишүүн)

Намуудад нэр дэвшүүлэхдээ залуу болон эмэгтэй улс төрчдийг дэмжих дүрэм журам бий эсэх. Намуудын дүрэмд залуу болон эмэгтэйчүүдийг бүх шатны сонгуульд нэр дэвшихэд нь дэмжих зохицуулалт байхгүй. Харин нэр дэвшигчийг тодруулах журамдаа ХҮН тусгайлсан журам гаргаж хэрэглэсэн. АН нэр дэвшигчдээс авах дэнчинг эмэгтэй нэр дэвшигчдээс тодорхой хувийг хөнгөлсөн байна. Намуудын нэр дэвшүүлэхэд хэрэглэсэн дотоод журам нь ил тод бус байсан. Тухайлбал,

- АН-ын гишүүд: Мөнгөө төл гэдэг л шаардлага л байдаг.(эмэгтэй, АН-ын гишүүн), 1-т намын гишүүн байх, 2-т УБХ-ны гишүүн байх, 3-т 100 сая төгрөг л гол шалгуур, бас намын дарга байх гол шалгуур болсон. Үндсэн 3 том шалгуурыг орхигдуулсан. Үүнд олон нийтийн судалгаа, рейтинг, Бодлогын зөвлөлүүдээс санал авах ёстой байсан. (эрэгтэй, АН-ын гишүүн). Намын өөр нэг гишүүн үндсэн шалгуур судалгаа байсан. Бидэнд тогтмол судалгаа танилцуулж байсан.(эмэгтэй, АН-ын гишүүн)
- МАН-ын гишүүд: Нэр цэвэр, өндөр боловсрол, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байх гол гол шалгуур шүүдээ. (46, 47)
- ХҮН-ын гишүүн: Үнэт зүйлтэй байх. (48, 45), Сонгуулийн хуулиар тавигдсан шаардлагыг хангах, дээр нь тойрогтоо ажилласан байдал чухал шалгуур байсан. Мөн мерит зарчим гэхээр боловсрол, туршлагаас гадна хүн байх, зөв хүн байх, хулгай хийж, худал хэлж байгаагүй, авлигад автчихаагүй, ёс зүйн код биелүүлж байсан, намдаа хэр удаан гишүүн байсан гэж хардаг. Гэхдээ энэ удаа бид эвсэл болж орсон. (49)

Нийслэлийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид нэр дэвшүүлэх үйл явц дүрэм, журмын дагуу болсон. Дүрмээ дагахгүй бол маргаан үүснэ, энэ н намыг удирдахад эрсдэлтэй гэж хариулж байна. Тухайлбал,

- МАН-ын гишүүд: Ер нь дүрмээ барьсан. Гэхдээ ковидын нөхцөл нэлээд нөлөөлсөн. Манай хороо онлайнаар саналыг нь авсан. Манай хороонд

надтай өрсөлдөх хүн байгаагүй. Тэгэхээр их тайван болсон. Гэхдээ ихэвчлэн намын хороо, намын хорооны дарга, дүүргийн намын хорооны дарга нь намын гишүүдтэйгээ зөвшилцсөний үндсэн дээр намын хорооны тэргүүлэгчид хэлэлцэж бодлого гардаг гэж ойлгосон. (1), Яахав дүрмийн дагуу л явж байгаа л даа. Заваан заваан юм болно. Гэхдээ арай АН шиг биш. Ер нь тухайн тэр дунд болон анхан шатны нэгжгийг хэн удирдаж байгаа гэдгээс шалтгаална. (7)

- АН-ын гишүүд: Яг мөрддөг, Яг адилхан цензур, яг адилхан болзол тавиад яг адилхан хуралдаан зарлаад тэрийгээ ягштал мөрдөөд тийм л байдаг. (4)
- ИЗН-ын гишүүн: Манай нам бол нэр дэвшүүлэх журмын дагуу л явагддаг. Эцсийн шийдвэрийг Үндэсний бодлогын хороо л гаргадаг. (10)
- ХҮН-ын гишүүн: Намын дээд түвшний удирдлагад байдаггүй болохоор мэдэхгүй байна. Гэхдээ тодорхой шаардлага тавиад бас бид нарт ёс зүйг баримтлах, сонгогдсон тохиолдол авлига, хулгайн хэрэгт оролцохгүй, улс эх орны эв нэгдлийг хангана, намын дотоод эв нэгдлийг хангана гэх мэт гэрээ байгуулж байсан. (12)

Аймгийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон болон нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид МАН, АН-ын нэр дэвших үйл явц дүрэм, журмын хүрээнд болсон гэдэгт эргэлздэг хүн нэлээд байна. Тухайлбал,

- МАН-ын гишүүн: Намын удирдлагууд эхлээд тэр өрсөлдөгчтэй энэ хүнийг ингэж өрсөлдүүлэх боломжтой юм байна гэж өөртөө эхлээд шүүсэн байна. Тэгээд дараа нь квотыг харна. Эцэст нь хувь хүний өөрийнх нь байр суурийг сонсдог байх. Энэ бүгд нийлээд тухайн хүний ажил мэргэжил, олон нийтэд танигдсан байдал, нутаг орондоо байрин суурин олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа байдлыг харгалзаж санал тавина. (Хөвсгөл аймгийн МАН-ын гишүүн. 29) Манай аймагт дүрэм журмаа мөрдөг юм ерөөсөө байхгүй. (Өмнөговь аймгийн МАН-ын гишүүн. 26) Ер нь бол дүрэм бий. Гэхдээ түүнийг хэрэгжүүлдэггүй. (Өвөрхангай аймгийн МАН-ын гишүүн. 28)
- АН-ын гишүүн: Нэр дэвшихэд дүрэм, журам хэрэглэнэ. Намын дотоод дүрэм гэж бий. Түүндээ захирагдаж байгаа. За яахав төрийн албан хаагч хүн түдгэлзээд нэр дэвшиж болно л доо. Яг одоо өөр хүмүүс намд элсээд дэвшээд байна. нэр дэвших хүсэлтээ намын даргад тавина. Намын хороо хэлэлцээд эцсийн шийд гарна. Өрсөлдөгчгүй байвал шууд баталдаг. (Өвөрхангай аймгийн АН-ын гишүүн. 30) Дунд шатанд хэрэглэх ёстой. Гэвч тэрийгээ мөрддөггүй. Дээд шатанд бол өөр байх. (Хэнтий аймгийн АН-ын гишүүн. 31) Ямар ч байсан ил тод бүүр нээлттэй явагдсан. Сонгуулийн өмнө санал асуулга гээд авч байсан. Нэг тойрог дээр 3-4 хүн гарч ирээд, тэндээсээ 2 нь нэр дэвисэн. (Сүхбаатар аймгийн АН-ын гишүүн. 36)

Намын дэргэдэх ТББ-ууд залуучууд болон эмэгтэйчүүдийг нэр дэвшихэд дэмжсэн эсэх. МАН, АН-ын дэргэдэх залуучууд болон эмэгтэйчүүдийн байгууллагууд идэвхтэй ажилладаг бол МАХН-ын дэргэдэх байгууллага дүрмээр байдаг ч үйл ажиллагаа нь жигдрээгүй, ХҮН-ын дэргэд ийм байгууллага байхгүй байна. Судалгаанд оролцогчдоос энэ байгууллагууд нэр дэвшүүлэхэд хэр оролцдог вэ гэж асуухад оролцоо маш муу, удирдлагад байдаг хүмүүс өөртөө нэр дэвших мандатаа авахын тулд ажилладаг. УИХ-ын түвшинд залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагаас асуудаггүй гэсэн бол орон нутгийн төвшинд асуудаг гэсэн хариултууд давамгайлж байна. Тухайлбал,

- АН-ын гишүүн: Аваагүй, нэр дэвших комисс гэж байгуулаад түүндээ хэдэн хүмүүсийг оруулсан. Эцсийн дүндээ тэд нар нь ч нөлөө байгаагүй. (41)
- МАН-ын гишүүд: Намын бүх байгууллагаас авдаг ш дээ. (46), Асуудаг байх гэж бодож байна. (47)
- МАХН-ын гишүүн: Тийм зүйл байхгүй. (42),
- ХҮН-ын гишүүн: Эмэгтэйчүүд гэх мэт тухайлсан байгууллага байхгүй. Залуу ХҮН гэж клуб бий. Гэхдээ тэр клубээс асуугаагүй. Саналын эрхтэй оролцоогүй, квотын асуудал яригдаагүй. (45)

Нийслэлийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид нам нэр дэвшүүлэхдээ намын дэргэдэх байгууллагаас асуудаг, асуудаггүй гэж янз бүр хариулж байна. Тухайлбал,

- МАН-ын гишүүд: Санал авдаг. НАМЗХ-ээс бол авсан. Бүх аймаг, дүүргүүд авсан. Төв НАМЗХ нэр дэвших сонирхолтой ямар хүмүүс байна вэ гэж бүртгэл гаргаад, улс төрийн идэвх, оролцоо сонирхлыг хүндэтгээд залуучуудыг нэр дэвшүүлэхэд дэмжлэг үзүүлээч гээд албан бичиг явуулж байсан. (2) Дүрмээр бол асуух ёстой. Гэхдээ манай нам харьцангуй асуусан, бас л өөр байсан шүү. (8) Сүхбаатар дүүрэг бол асуугаагүй шүү дээ. Ер нь намын хорооны дарга УИХ-ын гишүүн байх ч буруу юм билээ. Сая сонгуулиар харж байхад бүх эрх мэдэл тэр хүнд байсан. Манай 20 хорооны намын хорооны даргыг барьчихаж байна шүүдээ. (14)
- АН-ын гишүүд: Санал авна. Жишээ нь манай нам АЗХ, АОХ, АЭХ, АХ зэрэг бүх байгууллагууд саналаа оруулдаг. Тэгээд хорооны хурлаар бүгдийг хэлэлдэг. (18)
- ИЗН-ын гишүүн: Манай нам цөөхөн гишүүнтэй учир албан ёсоор санал асууж байгаагүй, дотоод өрсөлдөөн бага. (10)

Аймгийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид залуучууд, эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэхдээ намын дэргэдэх байгууллагаас санал авдаг, авдаггүй гэж ялгаатай хариулж байна. Тухайлбал,

- МАН-ын гишүүн: Намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагаас асуусан л гэсэн. Би тухайн тэр байгууллагад нь байдаггүй болохоор сайн мэдэхгүй. (Өмнөговь аймгийн МАН-ын гишүүн. 28) Намын шат шатны байгууллагаар хэлэлцээд олонхын дэмжлэг аваад явдаг. Гэхдээ нэлээд хүмүүс энийг алгасан байгаа л харагддаг. (Хэнтий аймгийн МАН-ын гишүүн. 32) Асуухгүй ээ. Тийм юм байхгүй. Хэзээ ч залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагад тэрийг дэвшүүлэх үү гэж асууж байгаагүй. (Өвөрхангай аймгийн МАН-ын гишүүн. 28)
- АН-ын гишүүн: Намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагаас санал авна. Жагсаалтаа албан ёсоор намын даргад өгдөг. Тэгээд эцсийн сонголтыг санал хураалтаар шийднэ. (Өвөрхангай аймгийн АН-ын гишүүн. 30)

Нэр дэвшигчид тойргоо сонгох, чөлөөтэй өрсөлдөх боломж байдаг эсэх.

2020 оны УИХ-ын болон ИТХ-ын сонгуульд хэрэглэсэн сонгуулийн олон мандаттай том тойрог нь нэр дэвшигчдийг сонгуулийн бус үед тойрогтоо ажиллахыг шаарддаг тул олон нэр дэвшигч тойргоо өөрөө сонгосон. Гэхдээ орон нутагт тойргоо өөрөө сонгосон, өрсөлдөөн бага байсан бол нийслэлийн тойргуудад олон нэр дэвшигч байсан, намаас нэр дэвшихийг хүсэгчид их байсан.

Нийслэлийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид ер нь бол гайгүй, эрхээ эдэлж чаддаг, төгс гэж хэлэхгүй ч дотоод ардчилалтай гэж хариулж байна. Харин зарим улс төрчид тэс өөр байр суурьтай байна. Тухайлбал,

- МАН-ын гишүүд: Манай Сүхбаатар дүүрэг дээр дотоод ардчилал байхгүй. Тойргоо сонгох боломж байхгүй. (14) Хязгаарлагдмал. Хайрцаглагдана, бүх зүйл шүүдээ. (8)
- АН-ын гишүүд: Төгс гэж хэлэхгүй. Ялгаварлах, үл хүлээн зөвшөөрөх зэрэг асуудал бий. Гэхдээ бусад намуудтай харьцуулбал харьцангуй ардчилалтай. (9)

Аймгийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид намын дотоод ардчилалд ялгаатай хариулж байна. Тухайлбал,

- МАН-ын гишүүн: Тийм ерөөсөө байхгүй. Манай аймагт ч байхгүй. (Өмнөговь аймгийн МАН-ын гишүүн. 26) Дотоод ардчилал бол ер нь байхгүй шүү. МАН чинь өөрийн тогтолцоотой. Нэг асуудал үүсэхэд намын хороонд өргөдөл өгнө, хороо УЗ-д явуулна. УЗ намын бага хурлаар шийднэ. Бага хурлаар гарсан шийдвэр явсаар явсаар буцаад анхан шатны нэгж дээр ирнэ. (Өвөрхангай аймгийн МАН-ын гишүүн. 28)
- АН-ын гишүүн: Ардчилалтай гэх ч хаашаа юм, ардчилалгүй гэх хаашаа юм. Саяны УИХ-аар бол ардчилалгүй байсан. (Хэнтий аймгийн АН-ын гишүүн.

(31) Дотоод ардчилал бол байгаа. гэхдээ 100 хувь хараахан биш. Зарим сонгогдсон хүний тойргийг авах тохиолдол гарсан. (Хөвсгөл аймгийн АН-ын гишүүн. 22)

2020 оны УИХ, ИТХ-ын сонгуульд нэр дэвшихэд нөлөөлсөн хүчин зүйлс судлахад орон нутагт нам, намын гишүүд нөлөөлсөн гэж хариулж байхад УИХ-ын түвшинд нэр дэвшсэн улс төрчид гэр бүл хамт олон нөлөөлсөн гэж хариулж байна.

Мөн нэр дэвшигчийг тодруулах явцад гол шийдвэр хаана гарсныг судалгаад оролцогчдоос тодруулахад УИХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид эцсийн шийдвэр намын ҮБХ, Бага хурал дээр гарсан. Аймгийн болон Нийслэлийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн, сонгогдсон, нэр дэвших мандатаа авч чадаагүй улс төрчид намын дарга, намын хороо шийдсэн гэж хариулж байна. Эндээс харахад намын дарга нар нэр дэвшигчийг тодорхойлж байгаа нь намууд дотоод ардчилал сул байгаа, нэр дэвшихийг хүсэгчид намын шат шатны удирдлагад ойр, нөлөөтэй байх нь улс төрийн эрхээ эдлэхэд нөлөөлдөг болох нь харагдаж байна.

Харин нэр дэвшиж чадаагүй улс төрчдөд юу хамгийн их нөлөөлсөн бэ гэдгийг судлахад судалгаанд оролцогчдын ихэнх нь санхүүгийн хүчин зүйлийн улмаас нэр дэвших эрхээ авч чадаагүй гэж хариулж байна. Санхүүгийн хүчин зүйл сонгуульд их хэмжээний мөнгө зарцуулж чадахгүй, олонд танигдаагүй, намд хандив өгөөгүй учраас нэр дэвшиж чаддаггүй байх гэж хариулсан.

Учир нь улс төрийн намын санхүүжилт нууц байна, намаас нэр дэвших эрхээ авах нь асар их хөрөнгө зарцуулсан ажил болж байна. Үүнд, олны танил болохын тулд тойрогтоо ажиллах, намын анхан болон дунд шатны нэгжийг санхүүжүүлэх, намыг ивээн тэтгэхийг ил болон далд хэлбэрээр шаарддаг болохыг дурдаж байна.

Мөн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй сонгуулийн хуулийн санхүүжилттэй холбоотой зохицуулалт нь мөнгөтэй хүнд илүү үйлчилсэн, тэлсэн заалт байна. Үүнд зардлын дээд хязгаарыг хэт өндөр тогтоож байгааг дурдаж байсан. Энэ бол их хэмжээний хөрөнгө зарцуулахыг шаардаж байгаа бөгөөд сонгуулийн өрсөлдөөнд залуучууд, эмэгтэйчүүд чирэгдэж байна гэж хариулж байна.

Цаашид улс төрийн намууд залуу болон эмэгтэй улс төрчдийг дэмжихийн тулд эрх зүйн ямар шинэчлэлт хийвэл зохилтой вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчид дараах бодолтой байна. Үүнд:

1. Нэр дэвших квотыг нэмэгдүүлэх,

ХҮН-ын гишүүн: Намууд манайхаас үлгэрлээд квотынхоо хувийг нэмж болно шүү дээ. Эмэгтэйчүүд угаасаа улс төрд өрсөлдөхөд хүнд, санхүү,

зориг шаарддаг. Эмэгтэйчүүд зориг гаргаад ороод ирвэл сургаад, менторшип гэх зүйлүүд намын дүрэмд байж болно. Мөн сонгуулийн хууль, намын тухай хуулиар зардлыг бууруулах, төсвөөс дэмжих заалтуудыг ирэх хэрэгтэй. (49)

2. Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх,

МАН-ын гишүүн: хуулийн түвшинд бол намын санхүүжилтийн асуудал чухал. Намуудын дүрэм, журам тодорхой ахиц гарч байж санхүүжилтийн хуулийг ярих нь чухал байх. Байгууллагын дүрэм журам институтчилэгдэж байж цаашаа явна гэж харж байгаа. (41)

3. Намууд залуу болон эмэгтэй улс төрчдийг сургах, менторшип хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

4. Сонгуулийн зардлын дээд хязгаарыг бууруулах

ХҮН-ын гишүүн: Сонгуулийн хууль, намын тухай хуулиар зардлыг бууруулах, төсвөөс дэмжих заалтуудыг ирэх хэрэгтэй. (49)

5. Улс төрийн намыг санхүүжүүлэх шаардлага болзолд эмэгтэйчүүд болон залуучуудыг дэмжих нөхцөлийг тусгаж өгөх

- АН-ын гишүүн: Дэмжинэ. Яагаад гэвэл хүмүүст гарааны тэгш боломж байгаа юм. Дөнгөж хорь гаруй насны залуу хөрөнгө өвлөж аваагүй л бол бизнесийн хуримтлал байхгүй. Тэгэхээр манайх гарааны тэгш боломж олгохын тулд зорилтот хүмүүстээ дэмжлэг олгох нь зөв гэж боддог.. (Баянзүрх дүүргийн АН-ын гишүүн) 2.
- МАН-ын гишүүн: Ингэж заах нь үр нөлөөтэй. Ер нь хараад байхад эмэгтэйчүүдийн нуруун дээр хамаг ачааг үүрээд явж байна шүү. Төрд эмэгтэйчүүд олноор гарахад зөв бодлого шийдвэр гаргаад яваад байх юм болов уу гэж боддог. (Сүхбаатар дүүргийн АН-ын гишүүн) 14.

Өмнөх хэсэгт сонгуулийн тухай хуулийн дагуу нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна гэсэн заалт нь эмэгтэйчүүд аливаа шатны улс төрийн сонгуульд өрсөлдөх мандат авахад дэмжлэг болдог тухай дурдсан. Энэ заалтыг эс тооцвол залуучууд, эмэгтэйчүүд улс төрд оролцох болон сонгуульд нэр дэвшихэд дэмжлэг болох тусгайлсан заалт Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд байдаггүй ба энэ судалгааны хүрээнд ярилцсан олонх оролцогчид үүнтэй санал нэг байв.

Хэдийгээр олонх оролцогчид дээрх квот нь эмэгтэйчүүдэд дэмжлэг болдог гэсэн ч зарим оролцогч дурдсанаар 20 хувийн квотын дагуу эмэгтэй нэр дэвшигчдийг олох хүндрэлтэй байдаг тухай ярьж байв. Үүнд сонгуулийн санхүүжилт гол хүндрэлүүдийн нэг болдог байна. Ялангуяа анх удаа сонгуульд дэвшиж буй нэр дэвшигчдэд энэ нь томоохон хүндрэл болдог тухай 2020 оны орон нутгийн сонгуульд БЗД-т анх удаа дэвшсэн нэг эмэгтэй оролцогч хэлж

байв. Тэрээр “Нэр дэвших квот олдож байгаа ч гэсэн санхүүжилтээс болоод буцаж байгаа маш олон эмэгтэйчүүдийг харсан” гэдгийг онцлон сонгуулийн зардал өндөр байсан тэр дундаа ухуулагчийн цалин сонгуулийн нийт зардлын 70 орчим хувь болж байсан нь сонгуулийн зардал өндөр болох үндсэн шалтгаан гэдгийг дурдсан.

Мөн зарим оролцогч 20 хувийн квот нь намуудын хүрээнд эмэгтэйчүүдийг нэр дэвших мандат авах тооны доод хязгаар бус дээд хязгаар гэсэн ойлголт байдгийг онцолсон. Жишээ нь дээр дурдсан 2020 онд БЗД-т нэр дэвшсэн оролцогч ярьснаар МАН тус орон нутгийн сонгуульд 20 хувийн квотыг эмэгтэйчүүдийн мандатын дээд хязгаар гэж үзэн хуулийн шаардлагад нийцсэн учраас нэмж олон эмэгтэйчүүд дэвшүүлэх сэдэл байгаагүй гэжээ. Нэгдүгээр бүлэгт дүгнэсэнчлэн эмэгтэйчүүдийн улс төр дахь оролцоо болон УИХ-ын сонгуульд өрсөлдөх эмэгтэйчүүдийн тоо, сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо аажим өсөх хандлага байгаа ч эмэгтэйчүүдийн өрсөлдөх эрх хязгаарлагдах үзэгдэл байсаар байгаа нь ирээдүйд хүйсийн квотыг өндөрсгөх үндэслэл болох боломжтой юм.

Хүйсийн квот нь эмэгтэйчүүдийн сонгуульд өрсөлдөх эрхийг хангахад чухал нөлөөтэй ч гэсэн намуудын дотоод бүтэц, зохион байгуулалтын хүрээнд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихэд чиглэсэн хууль эрх зүйн зохицуулалтууд сул буюу энэ үйл явц нь намуудын бүтэц, зохион байгуулалтаас хамаарч намуудын албан ба албан бус дүрмийн хүрээнд шийдэгддэг байна.

Судалгаанд оролцогчдоос намын залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагын үүрэг цаашлаад сонгуульд нэр дэвшүүлэх процесст ямар нөлөөтэй байдаг тухай лавлахад МАН-аас орон нутгийн сонгуульд сонгогдсон төлөөлөгчид НАМЗХ-г намын залуучуудын оролцоонд өндөр ач холбогдолтойг онцолж байсан бол бусад намын оролцогч нар намын залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллага сонгуульд нэр дэвшүүлэх процесст төдийлөн нөлөөтэй оролцдоггүй эсвэл намын залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллага өргөн хүрээнд идэвхтэй ажилладаггүй гэж байв.

2020 оны орон нутгийн сонгуульд БЗД-т сонгогдсон МАН-ын өөр нэгэн төлөөлөгч НАМЗХ дүүргийн намын хороо болон сонгуулийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэйг онцолж байв. Тэрээр 2013 онд МАН-д элссэн даруйдаа НАМЗХ-д элсэж үүрийнхээ НАМЗХ-ны салбарын даргаар сонгогдсон ба тэр үеэс хойш НАМЗХ-нд идэвхитэй ажилласаар ирсэн байна. Тус төлөөлөгчийн ярьсанаар БЗД-ийн ИТХ-ын сонгуулийн 43 мандатаас 8 мандатыг НАМЗХ-ны гишүүд авсан бөгөөд 7 гишүүн сонгогдож чадсан байна. Тус оны БЗД-ийн сонгуулиар МАН 23 суудал авч АН болон ХҮН бусад суудлуудыг авчээ. Өөрөөр хэлбэл тус дүүргийн ИТХ болон МАН-ын хорооны үйл ажиллагаанд дүүргийн НАМЗХ ихээхэн нөлөөтэйг харж болох юм.

Харин 2020 онд БЗД-т “АН-МАХН”-ын эвсэлээс нэр дэвшиж сонгогдсон төлөөлөгч АН-ын залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллага сонгуульд нэр

дэвшүүлэх процесст идэвхитэй оролцдоггүй онцолсон. Тэрээр энэ тухай:

“Залуучууд эмэгтэйчүүдийн байгууллага огт үүрэг гүйцэтгэдэггүй гэж хэлж болно Яагаад гэвэл дүүргийн намын хорооны хурлаар дүүргийн намын хорооны тэргүүлэгчид хэн нэр дэвших вэ гэдгийг шийднэ... оюутнуудын, эсвэл АЗХ гээд холбооны тэргүүнүүд манай холбооноос тэр дэвшинэ энэ дэвшинэ гээд ингээд байх юм бол бас учир дутагдалтай. Энэ байгууллагуудын гишүүн байх нь бол нэр дэвшихэд давуу тал болж чадахгүй.”

Өмнө нь ИЗНН-д гишүүн байсан боловч 2020 оны орон нутгийн сонгуульд АН-д элсэж БГД-т “АН-МАХН”-ын эвсэлээс сонгогдсон төлөөлөгч ИЗНН-ын залуучуудын байгууллага сонгуульд нэр дэвшүүлэх процесст залуучуудын байгууллагуудаас санал авдаггүй ба цөөн гишүүнтэй, дотоод өрсөлдөөн багатай нь үндсэн шалтгаанууд гэж байв.

Цаашлаад НАМЗХ бусад намуудын залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагатай харьцуулахад гишүүдийнхээ улс төрийн нийгэмшилд намын төв аппаратаас илүү нөлөөтэй байдаг бөгөөд аливаа сонгуульд өрсөлдөхөд НАМЗХ-д байсан туршлага, харилцаа холбоонд ач холбогдолтой байдаг талаар ярилцлагаас дүгнэж болохоор байна. 2020 онд БГД-ээс НИТХ-д сонгогдсон МАН-ын гишүүн НАМЗХ-д 2013 онд элссэн тухайгаа ярихдаа:

“Тэнд /НАМЗХ/ үе тэнгийнхэн найзлах, нэтворкинг буюу харилцаа холбоо үүсгэх нь залуу хүнд илүү сонирхолтой байдаг. Юу юугүй улс төрч болоод сонгуульд ороод өрсөлдөнө гэж би бодож ороогүй. Маш гоё боловсролтой, өөрийгөө илэрхийлэх чадалтай залуучууд нэгдсэн юм байна гээд орсон.”

2020 оны сонгуульд БЗД-т МАН-аас сонгогдсон өөр нэгэн төлөөлөгч НАМЗХ-ны дээрх онцлогийг мөн онцолж тус сонгуульд өрсөлдөхөд нэтворкинг үүсгэсэн байсан зэрэг нь тус болсон тухай дурдаж байв. Мөн тус төлөөлөгч ярилцлагадаа НАМЗХ-ны салбар буюу дүүргийн хорооны тэргүүлэгч гишүүд жилд 1,200,000 төгрөгийн хураамж төлдгийг дурдсан бөгөөд энэ нь намын гишүүний хувьд өгдөг жилийн 12,000 төгрөгөөс үлэмж их юм. Хэдийгээр салбар нэгжийн тэргүүлэгч гишүүд жирийн гишүүдээс их хэмжээний хураамж төлөх үүрэгтэйг ярилцагч нар дурдсан ч НАМЗХ нь МАН-д ихээхэн нөлөөтэй буюу хэдий нэг үндсэн намд харьяалагдаж буй ч намын төв аппаратаас тусдаа санхүүжилт болон дүрэм, харилцаа холбоогоор зохицуулагдсан зохион байгуулалттай буй нь ажиглагдаж байна. Энэ үйл явц нь намын дэргэд ТББ-ын зохион байгуулалтаар ажиллах боломж хуулийн дагуу олгогдсонтой холбоотой ба МАН-ын харьцангуй том бүтэц буюу гишүүнчлэлийн тоо, түүхэн хөгжлөөс шалтгаалж буй юм.

МАН нь бусад намуудтай харьцуулахад Монголын хамгийн олон жилийн түүхтэй намын хувьд хамгийн олон гишүүнтэй, улс орон даяар тархсан намын салбар нэгжүүдтэй байсан нь намын дэргэд НАМЗХ болон түүнтэй ижил төстэй

байгууллага байгуулахад шинэ үүссэн намуудтай харьцуулахад илүү хялбар байдаг.

Дээр дурдсан БГД-ээс сонгогдсон төлөөлөгч НАМЗХ-д байхдаа 21 аймгаар тойрч, олон залуучуудтай уулзаж байсан мөн БЗД-ийн өөр нэг төлөөлөгч НАМЗХ-оос зохион байгуулдаг улс орон даяарх залуучуудыг хамруулсан “1000-Залуучуудын чуулган”, “1000-Залуучуудын шинэ жил” гэх мэт үйл ажиллагаануудыг зохион байгуулж байсныг онцолсон юм. Мөн НАМЗХ нь “Алтан сарнай” хэмээх нийгмийн төрөл бүрийн салбарт онцгой амжилт гаргасан хүмүүст шагнал гардуулдаг үйл ажиллагааг жил болгон зохион байгуулдаг нь дээр дурдсан арга хэмжээнүүдтэй адил тус байгууллагын гишүүдэд үе тэнгийн болон намын албан тушаалтан гишүүдтэй харилцаа холбоо үүсгэдэг нь аливаа сонгуулийн үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг олох боломж олгодог байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол улс иргэд Үндсэн хуулиар олгогдсон сонгогдох эрхтэй. Гэвч сонгогдох эрхийг хэрэгжилтийг ерөнхий болон корпоратив эрх зүйн хүрээнд хэрхэн зохицуулсан, 2020 оны бүх шатны сонгуульд залуу болон эмэгтэй улс төрчид нэр дэвших эрхээ хэрхэн эдэлсэн, ямар саад бэрхшээл байсныг судлаад дараах дүгнэлтийг хийлээ.

1. Ерөнхий эрх зүйн орчны хүрээнд Үндсэн хууль болон бусад хуулиар хуульд заасан насны босго болон нийтлэг шаардлагыг хангасан нэр дэвшигчдэд нэр дэвших эрх нээлттэй байна. МУИХСТХ болон АНСДИТХСТХ-иудад эмэгтэйчүүдийн 20 хувийн квот үйлчилж байна. Харин залуучуудын оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Мөн бүх намууд ЖЭТБХТХ-ийн дагуу өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна үүрэг хүлээсэн байна. Намууд жендерийн тайлангаа хоёр жил тутам гаргаж байх ёстой ажээ. Гэвч ЖЭТБХТХ-ын хэрэгжилт сул байсаар байна.

2. Корпоратив эрх зүйн орчны хүрээнд намууд ЖЭТБХТХ-ийг өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байх хуулийг хэрэгжүүлж байна. Намууд жендерийн тайлангаа хоёр жил тутам гаргаж байх ёстой ажээ. Гэвч ЖЭТБХТХ-ын хэрэгжилт сул байсаар байна. Намууд сонгуульд нэр дэвших үйл ажиллагааг журмаар зохицуулсан байна. Гэхдээ уг журам залуу болон эмэгтэй улс төрчдийг дэмжсэн заалт МАН, АН, МАХН-уудад байхгүй байна. Журам нь ил тод биш байна. ХҮН “Зөв хүн электорат” эвслээс нэр дэвшүүлэх дотоод журамд тусгасан байна.

3. Чанарын судалгааны үр дүнг харахад квот болон залуучууд, эмэгтэйчүүдийн нэр дэвших эрхийг хангах, дотоод ардчилал зэрэг асуудалд улс төрчид ялгаатай байр суурьтай байна. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх, эмэгтэйчүүдийн квотыг нэмэгдүүлэх, УТНТХ болон бүх шатны сонгуулийн хуулиудыг залуучууд болон эмэгтэйчүүдэд ээлтэй болгох, намуудыг залуу болон эмэгтэй улс төрчдийг хөгжүүлэх, сургах, менторшип хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

4. Залуучууд, эмэгтэйчүүд сонгуульд нэр дэвшихэд учирч буй институтийн саад бэрхшээлүүд нь юуны өмнө улс төрийн намын өргөн хүрээндээ сонгуулийн тогтолцоонд агуулагдаж байна.

5. Тухайн улс төрчийн намын рейтинг нь нийт гишүүдийнхээ улс төрийн амжилтад үлэмж нөлөөтэй.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАЛУУ БОЛОН ЭМЭГТЭЙ УЛС ТӨРЧДИЙН КАРЬЕРТ НӨЛӨӨЛЖ БҮЙ ХУВЬ ХҮНИЙ ХҮЧИН ЗҮЙЛС

2.1 Хүн ам зүйн мэдээлэл хийсэн шинжилгээ

2016 болон 2020 оны Улсын их хуралд суудал бүхий намуудын тухайн сонгуульд нэр дэвшсэн дэвшигчид, мөн онуудын НИТХ, аймаг дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, 21 аймаг 9 дүүргийн засаг дарга нар, 2017-2020 болон 2020-2021 онд ажилласан засгийн газрын сайд, дэд сайд нарын хүн ам зүйн мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.

Уг судалгааны мэдээллийг Монгол улсын Сонгуулийн ерөнхий хороо, Нийслэлийн архивын газар, аймаг дүүргүүдийн ИТХ-ын ажлын алба, засаг даргын тамгын газруудад албан хүсэлт тавьж тухай бүр албан ёсны зөвшөөрлийн дагуу цуглуулсан. Мөн төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудас дахь нээлттэй мэдээллийг эх сурвалж болгон ашиглалаа.

График 1. УИХ-д нэр дэвшигчид, сонгогдсон НИТХ, ИТХ, Засгийн газар, Засаг дарга нарын насны бүтэц /2016, 2020 оны нийт үр дүн/



- 2016,2020 оны УИХ-ын сонгуульд суудал бүхий намаас нэр дэвшигчдийн насны бүтэц
- 2016, 2020 оны сонгуульд сонгогдсон НИТХ, аймаг болон дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид
- Засгийн газрын сайд, дэд сайд нар,
- 2016, 2020 оны аймаг дүүргүүдийн засаг дарга нарын насны бүтцийг дээрх графикт харуулав.


НИТХ болон аймаг дүүргийн ИТХ-н төлөөлөгчдийн насны бүтцэд 35 хүртэлх насны төлөөлөгчид болон 36-45 насны төлөөлөл дийлэнх хувийг эзэлж байна. Засгийн газрын болон УИХ-д 46-55 насны улс төрчид хамгийн өндөр хувийг эзэлж байна.

*Хүснэгт 8. Улс төрийн албан хаагчдын дундаж нас хүйсийн харьцаа.
/2016 болон 2020 оны дундаж/*

	Эмэгтэй	Эрэгтэй	Ерөнхий дундаж
УИХ	48	55.0	53.6
НИТХ	44.3	40.3	41.1
ИТХ	45.8	41.6	42.5
ЗГ	46.2	47.8	47.5
Засаг дарга	47.3	42.0	42.8

Хүснэгтэд 2016-2020 онд ажилласан болон 2020 онд сонгогдсон УИХ-д суудал бүхий намаас нэр дэвшигчдийн дундаж нас, бусад улс төрийн байгууллагуудад сонгогдсон болон томилогдсон улс төрчдийн дундаж насыг хүйсээр ялган харуулав.

График 2. Хүйсийн харьцаа улс төрийн албаар



Улс төрийн байгууллагууд дахь томилогдсон болон сонгогдсон төлөөллүүдийг хүйсээр нь харьцуулбал аймаг болон дүүргийн ИТХ дахь эмэгтэйчүүдийн эзлэх хэмжээ бусдаасаа хамгийн өндөр дүнтэй байна.

Харин 2020 онд сонгогдсон УИХ дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь сүүлийн хоёр жил өөрчлөгдсөнгүй. Харин орон нутгаас сонгогдсон гишүүдийн 11.6 хувийг, Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүдийн 24.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. 2016 онд уг үзүүлэлт орон нутгийн гишүүдийн 12 % нийслэлийн дүүргүүдийн гишүүдийн дунд 19.4%-тай байжээ. Үүнээс харахад эмэгтэй улс төрчид сонгогдох магадлал нийслэл Улаанбаатарт орон нутгаас илүү өндөр магадлалтай байна.


Улсын их хуралд нэр дэвшигчдийн хүн ам зүйн үзүүлэлт

Хүснэгт 9. УИХ-ын сонгуульд суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа.

		МАН	АН	МАХН	ХҮН
2016 он	Эр	77.9%	78.9%	82.5%	
	Эм	22.1%	21.1%	18.5%	
2020 он	Эр	78.9%	77.6%	88.5%	73.6%
	Эм	21.1%	22.4%	21.5%	26.4%

*МАХН болон ХҮН нь эвсэл бүрдүүлж сонгуульд оролцсон бөгөөд дээрх үзүүлэлт нь эвслийн бус намын үзүүлэлт болно

График 3. 2016 болон 2020 оны УИХ-н сонгуульд суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн мэргэжлийн ангилал.



УИХ-д нэр дэвшигчдийг мэргэжлээр нь ангилан харвал санхүү эдийн засаг, эрх зүй, инженер технологийн мэргэжлүүд дийлэнх хувийг эзэлж байна. 2016 онд хамгийн их хувийг инженерүүд эзэлж байсан бол 2020 онд санхүү эдийн

засгийн мэргэжилтнүүдэд тэргүүлэх байраа алджээ. Мөн сүүлийн 30 жилийн хугацаанд бүрэлдсэн найман удаагийн УИХ-ын танхимын гишүүдийн дунд ч инженер, эрх зүйч, санхүү эдийн засгийн мэргэжилтнүүд давамгайлсаар иржээ³³. Харин эмч болон багш мэргэжилтнүүдийн эзлэх хувь буурсаар ирсэн бөгөөд 1992 оны анхны сонгуулиар парламентын 7.9 хувийг бүрдүүлж байсан эмч нар 2016 онд сонгуульд сонгогдоогүй. 2020 оны УИХ-ын гишүүдийн 3.9 хувийг эмч мэргэжилтэн бүрдүүлж байна.

Сүүлийн хоёр удаагийн сонгуульд УИХ-д суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн боловсролын төвшнийг хүйсээр нь харьцуулан харвал эмэгтэйчүүдийн боловсрол эрчүүдээс илүү байна. Тухайлбал эмэгтэй нэр дэвшигчдийн дунд докторын зэрэгтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрчүүдээс 10 хувиар илүү байна. Харин бүрэн дунд боловсролтой бүх нэр дэвшигч эрэгтэй байна. Улсын их хуралд нэр дэвшигч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс боловсролын зэргээр илүү байна.

Хүснэгт 10. 2016 болон 2020 онд сонгогдсон УИХ-ын гишүүдийн ажлын туршилага /жилээр/


Ажилласан салбар	2016 он			2020 он		
	Жил	Хувь	Нэг хүнд ноогдох жил	Жил	Хувь	Нэг хүнд ноогдох жил
ТУТА	548	30.6%	7.21	609	30.6%	8.01
ТЗА	244	13.6%	3.21	355	17.8%	4.67
ТҮА	244	13.6%	3.21	172	8.6%	2.26
ТТА	75	4.2%	0.99	97	4.8%	1.28
Хувь	372	20.8%	4.89	475	23.8%	6.25
ИНБ/ОУБ	130	7.2%	1.71	120	6.0%	1.58
Нам	173	9.6%	2.28	161	8.0%	2.12
Нийт	1786	100%	23.50	1989	100%	26.17

**Нам- Уг ангилалд тухайн хүний үндсэн ажил эрхлэлт нь намын албан тушаал байсан хугацааг оруулсан болно*

УИХ-ын гишүүдийн ажлын туршлагыг дээрх хүснэгтэд харуулахдаа нээлттэй эх сурвалжид үндэслэн намтрын мэдээллээс нь нийт ажлын туршлагыг салбараар ангилж бүртгэн дүнг гаргалаа. Гишүүдийн улс төрийн алба хашиж байсан туршлага нь хамгийн өндөр, түүний дараагаар хувийн хэвшил, төрийн захиргааны байгууллагад ажилласан туршлага удаалж байна.

³³ 1212.mn


График 4. УИХ-д нэр дэвших үедээ болон дэвшихээсээ өмнө эрхэлж байсан ажлын төрөл болон насны бүтцийн харьцаа. / 2016 болон 2020 оны УИХ-ын сонгуульд суудал бүхий намуудаас нэр дэвшигчид /



Нэр дэвшиж байх үедээ эрхэлж байсан албан тушаал болон насны харьцаагаар 2016 болон 2020 онд суудал бүхий намаас нэр дэвшигчдийн дунд наснаас хамаарсан ялгаа өндөр байна. Тухайлбал 35 хүртэлх насны залуу нэр дэвшигчдийн дийлэнх хувь нь намын байгууллага болон хувийн хэвшилд ажиллаж байсан. Энэ үзүүлэлт нь нас ахих тусам багасаж, улс төрийн албан тушаал эрхэлж байсан нэр дэвшигчдийн хувь нэмэгдсээр 55-с дээш насны нэр дэвшигчдийн 72% нь улс төрийн алба хашиж байх үедээ Улсын их хурлын сонгуульд нэр дэвшсэн байна.


Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын хүн ам зүйн үзүүлэлт

График 5. 2020 оны нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшигчид болон сонгогдсон төлөөлөгчдийн насны харьцаа



Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд 2020 оны орон нутгийн сонгуулиар нэр дэвшигчид болон сонгогдсон төлөөлөгч нарын насны бүтцийг графикт харьцуулав. Уг сонгуулиар 131 нэр дэвшигчийн 3.1% нь 56-аас дээш насны нэр дэвшигч байсан боловч сонгогдож чадаагүй. Нэр дэвшсэн болон сонгогдсон насны харьцуулбал залуучууд давамгайл сонгогджээ. Тухайлбал 36-45 нас, 35 хүртэлх насны залуучууд нэр дэвшсэн хувиасаа давж сонгогдсон байгаа нь нийслэлд залуучуудын улс төрийн оролцоо илүү идэвхтэй байгааг илтгэж байна. Нэр дэвшигчдийн 20.6% нь эмэгтэй нэр дэвшигчид байсан ч сонгогдсон төлөөлөгчдийн дунд 17.8% болж буурсан үзүүлэлттэй байна.

График 6. 2016 болон 2020 оны орон нутгийн сонгуулиар сонгогдсон НИТХ-ын төлөөлөгчдийн мэргэжлийн бүтэц



Төлөөлөгчдийг мэргэжлээр нь ангилахад бусад улс төрийн албаны адил эдийн засаг, эрх зүй, инженерийн мэргэжлүүд давамгайл байна. Боловсролын төвшнөөр нь авч үзвэл 2016 онд сонгогдсон төлөөлөгчдийн 77.8% нь магистрын зэрэгтэй, 2020 онд сонгогдсон төлөөлөгчдийн 91.1% нь магистрын зэрэгтэй үлдсэн нь бакалаврын зэрэгтэй байна. 2016 онд докторын зэрэгтэй 1 төлөөлөгч байсан бол 2020 онд докторын зэрэгтэй төлөөлөгч хараахан сонгогдсонгүй.


Хүснэгт 11. НИТХ-ын төлөөлөгчдийн ажлын туршлага / 2016 болон 2020 оны сонгуулийн дараа/

	2016			2020		
	Жил	Хувь	Нэг хүнд ноогдох жил	Жил	Хувь	Нэг хүнд ноогдох жил
ТУТА	109	14.2%	2.42	165	21.8%	3.67
ТЗА	160	20.9%	3.56	142	18.7%	3.16
ТҮА	50	6.5%	1.11	42	5.5%	0.93
ТТА	9	1.1%	0.20	12	1.5%	0.27
Хувь	343	44.8%	7.62	347	45.9%	7.71
Нам	39	5.1%	0.87	23	3.0%	0.51
ИНБ/ ОУБ	55	7.1%	1.22	25	3.3%	0.56
Нийт	765	100%	17	756	100%	16.8

НИТХ-ын төлөөлөгчдийн хувийн салбарт ажилласан туршлага хамгийн өндөр байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал уг үзүүлэлт нь засгийн газрын гишүүдээс 4 дахин, УИХ-д нэр дэвшигчдээс 2 дахин их бөгөөд НИТХ-ын төлөөлөгчдийн нийт ажлын туршлагын 45 орчим хувийг бүрдүүлж байгаа юм.


Аймаг, дүүргүүдийн ИТХ-ын төлөөлөгчдийн хүн ам зүйн үзүүлэлт

График 7. Аймаг дүүргүүдийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын насны бүтэц



Сүүлийн хоёр удаагийн орон нутгийн сонгуульд сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчдийг насны бүтцээр нь харьцуулахад ихээхэн ялгаа гарчээ. Тухайлбал аймгуудад 35 хүртэлх насны төлөөлөгчид дүүргүүдээс даруй 10 гаруй хувиар бага байна. 2016 онд уг үзүүлэлт 17 хувийн зөрүүтэй байжээ.

График 8. Аймаг болон дүүргүүдийн ИТХ төлөөлөгчдийн нас болон хүйсийн харьцаа. /2016 болон 2020 оны сонгуулийн үр дүн/




Тоон мэдээллээс үзэхэд бүх шатны сонгуульд 35-аас доош насны залуу нэр дэвшигчдийн дунд эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь хамгийн бага байна. Харин насны бүлэг ахих тусам эмэгтэй төлөөлөгчдийн төлөөлөл нэмэгджээ. Аймгуудын ИТХ-д эзлэх эмэгтэйчүүдийн тоо нийслэлийн 9 дүүргээс даруй хоёр дахин бага байгаа нь хөдөө орон нутагт эмэгтэйчүүдийн оролцооны төвшин хангалтгүй байгааг харуулж байна. Нөгөөтгээгүүр орон нутаг дахь эмэгтэйчүүд улс төрд оролцоход Улаанбаатарт байгаа эмэгтэйчүүдээс илүү их саад бэрхшээлтэй тулгардгийг илтгэж байна.

Хүснэгт 12. Аймаг болон дүүргүүдийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хүйсийн харьцаа

	Хүйс	Дүүрэг	Аймаг
2016 он	Эр	72.4%	84.2%
	Эм	27.5%	15.7%
2020 он	Эр	70.7%	84.2%
	Эм	29.2%	15.8%

Аймаг болон дүүргүүдийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн хүйсийг харьцаа ихээхэн зөрүүтэй байна. Сүүлийн хоёр удаагийн сонгуулийн дүнгээр эмэгтэй төлөөлөгч нийслэлд 28 хувь, хөдөөд 15 хувийг эзэлж байна. Энэ нь орон нутгийн хэмжээнд эмэгтэй улс төрчдийн оролцоо сул, мөн сонгогч иргэдийн хандлага эмэгтэй улс төрчийг дэмжиж саналаа өгөх нь дүүргүүдээс бага байгааг харуулж байна.

График 9. 2020 оны орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид болон сонгогдсон төлөөлөгчдийн нас болон хүйсийн харьцаа.




2020 оны орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид болон сонгогдсон төлөөлөгчдийн нас хүйсийг харьцуулахад бүх насны төлөөлөлд эмэгтэй нэр дэвшигчдийн эзлэх хувь багасжээ. Квотын дагуу нийт нэр дэвшигчдийн 20-оос дээш хувь нь эмэгтэйчүүд байгаа ч сонгогдсон төлөөлөгчдөд эзлэх эмэгтэйчүүдийн хэмжээ буурсан байна. Энэ үр дүн УИХ, НИТХ-д мөн адил байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хүн ам зүйн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр залуучууд болон эмэгтэйчүүдийн төлөөлөл аймгуудын ИТХ-д тун хангалтгүй байна. Хүйсийн хувьд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд өрсөлдөж буй эмэгтэйчүүдээс Улаанбаатарт дүүргийн ИТХ-д өрсөлдөж буй эмэгтэйчүүд сонгогдох магадлал илүү өндөр байна.

Засгийн газрын сайд, дэд сайд нарын хүн ам зүйн үзүүлэлт

График 10. 2017-2020 он болон 2020-2021 онд томилогдон ажилласан Засгийн газрын сайд дэд сайд нарын насны бүтэц.



*Дундаж нас: Сайд-49.5 , Дэд сайд-45.5

МАН-ын дарга У.Хүрэлсүх 2017-2020 болон 2020-2021 онуудад хоёр удаа Монгол улсын ерөнхий сайдаар томилогдон засгийн газрыг тэргүүлэн ажилласан. Энэхүү судалгаанд тус хоёр засгийн газрын сайд, дэд сайд нарыг сонгон авч дүн шинжилгээ хийсэн болно. Уг хоёр загийн газрууд нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдсаны өмнөх болон дараах гэдгээрээ гол онцлогтой юм. Графикаас харахад 2020-2021 оны засгийн газар нь бага зэрэг залуужсан байна. Тухайлбал 201-2020 онд ажилласан засгийн газрын сайд, дэд сайд нарын дундаж нас 49 байсан бол 2020-2021 оны засгийн газрын сайд нарын дундаж нас 46.1 болж багасжээ.

Хүснэгт 13. Засгийн газрын сайд нар болон дэд сайд нарын хүйсийн харьцаа

Хугацаа	Хүйс	Албан тушаал		Нийт
		Дэд сайд	Сайд	
2017-2020	Эм	4	2	6
	Эр	10	13	23
2020-2021	Эм	2	3	5
	Эр	12	14	26

Хүснэгт 14. 2017-2020 он болон 2020-2021 онд ажилласан засгийн газрын сайд дэд сайд нарын ажлын туршлага нийлбэр дүнгээр / Жилээр/

Салбар	2017 он			2020 он		
	Жил	Хувь	Дундаж	Жил	Хувь	Дундаж
ТУТА	221	29.5%	7.62	146	20.6%	4.71
ТЗА	165	22.0%	5.69	205	29.0%	6.61
ТҮА	64	8.5%	2.21	89	12.5%	2.87
ТТА	28	3.7%	0.97	43	6.0%	1.39
Хувь	104	13.9%	3.59	95	13.4%	3.06
Нам	76	10.1%	2.62	55	7.7%	1.77
ИНБ	89	11.9%	3.07	74	10.4%	2.39
Нийт	747	100%	25.76	707	100%	22.81

**Нам- Уг ангилалд тухайн хүний эрхэлж байсан үндсэн ажил нь намын албан тушаал байсан хугацааг оруулсан болно/*

Засгийн газрын сайд, дэд сайд нарын ажлын туршлага нийлбэр дүнгээрээ багассан үзүүлэлттэй байна. 2017-2020 оны засгийн газрын гишүүдийн ажлын туршлага дотор “төрийн улс төрийн алба”-д ажилласан туршлага хамгийн өндөр байсан бол 2020-2021 оны засгийн газарт төрийн захиргааны албанд ажилласан туршлага жин даржээ. Иймд Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2020 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан засгийн газрыг өмнөх засгийн газартай харьцуулбал улс төрийн нөлөө буурсан илүү мэргэжилтнүүдээс бүрдсэн мэргэжлийн засгийн газар гэж дүгнэж болохуйц байна.


Аймаг, дүүргүүдийн засаг дарга, орлогч дарга нарын хүн ам зүйн үзүүлэлт

Хүснэгт 15. 2016 болон 2020 онд томилогдсон засаг дарга, орлогч дарга нарын нас хүйсийн харьцаа.

Хугацаа	Нас	Дүүрэг			Аймаг		
		Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт
2020	35 хүртэл	18.5%	0.0%	18.5%	6.7%	0.0%	6.7%
	36-45 нас	37.0%	3.7%	40.7%	66.7%	4.4%	71.1%
	46-55 нас	22.2%	14.8%	37.0%	15.6%	0.0%	15.6%
	56-с дээш	0.0%	3.7%	3.7%	4.4%	2.2%	6.7%
	Нийт	77.8%	22.2%	100%	93.3%	6.7%	100%
2016	35 хүртэл	30.8%	0.0%	30.8%	6.8%	0.0%	6.8%
	36-45 нас	30.8%	7.7%	38.5%	61.4%	6.8%	68.2%
	46-55 нас	11.5%	19.2%	30.8%	15.9%	2.3%	18.2%
	56-с дээш	0.0%	0.0%	0.0%	6.8%	0.0%	6.8%
	Нийт	73.1%	26.9%	100%	90.9%	9.1%	100%

Засаг дарга, орлогч нарын нас хүйсийн бүтцийг аймаг, дүүргүүдээр ялган харвал залуу болон эмэгтэйчүүдийн эзлэх хувь аймгуудаас илүү дүүргүүдэд өндөр байна. Тухайлбал 2020 онд томилогдсон аймаг дүүргийн засаг дарга болон орлогч нарын хувьд нийслэлийн хэмжээнд 22% нь эмэгтэй байгаа бол аймгуудын хэмжээнд эмэгтэйчүүд ердөө 6.7% -ийг бүрдүүлж байна. Мөн дүүргүүдийн засаг дарга, орлогч нарын дундаж нас 41.8 байгаа бол аймгуудад 43.3 байна. Энэ нь өмнөх иргэдийн төлөөлөгчдийн хурлын хүн ам зүйн үзүүлэлтийн онцлогтой тохирч байна. Өөрөөр орон нутагт залуу болон эмэгтэй улс төрчдийн оролцооны төвшин нийслэл Улаанбаатар хотоос харьцангуй сул байна.

График 11. Аймаг, дүүргүүдийн засаг дарга, орлогч нарын мэргэжлийн ангилал /2016 болон 2020 оны томилгоо/



Засаг дарга, орлогч дарга нарын дунд багш мэргэжилтний эзлэх хувь бусад улс төрийн сонгуульт албанаас илүүтэй өндөр хувьтай байлаа. Энэ нь орон нутагт багш мэргэжилтнүүд илүүтэй олонд танигдсан, нэр хүндтэй байдагтай холбоотой.

Хүснэгт 16. Аймаг дүүргүүдийн Засаг дарга болон засаг даргын орлогч нарын ажлын туршлага /жилээр/

	2016-2020 он			2020 он		
	Жил	Хувь	Дундаж	Жил	Хувь	Дундаж
ТУГА	291	23.7%	4.55	414	31.4%	6.47
ТЗА	295	24.0%	4.61	341	25.8%	5.33
ТҮА	129	10.5%	2.02	134	10.1%	2.09
ТТА	40	3.2%	0.63	33	2.5%	0.52
Хувь	296	24.1%	4.63	239	18.1%	3.73
Нам	86	7.0%	1.34	80	6.0%	1.25
ИНБ	88	7.1%	1.38	76	5.7%	1.19
Нийт	1225	100%	19.14	1317	100%	20.58

*Нам- Уг ангилалд тухайн хүний эрхэлж байсан үндсэн ажил нь намын албан тушаал байсан хугацааг оруулсан болно

Аймаг болон дүүргүүдийн засаг дарга, орлогч дарга нарын ажлын туршлагад улс төрийн, төрийн захиргааны албан хашиж байсан туршлага хамгийн өндөр, удаад нь хувийн байгууллагад ажиллаж байсан туршлага оржээ. Энэ нь орон нутгийн улс төрийн түвшинд хувийн хэвшлээс улс төрд шилжин орох үйл явц түгээмэл байгааг харуулж байна.

☉ 2.2 Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд нөлөөлж буй хувь хүний хүчин зүйлс

Судалгааны уг хэсэгт залуу болон эмэгтэй улс төрчдийн улс төрийн амжилтад голлох нөлөө үзүүлдэг хувь хүний хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон. Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдоос улс төрчдийн дүр төрх /хүн ам зүйн хүчин зүйлс/, хувь хүний амьдралын замнал, олон нийтэд танигдсан байдал /цахим орчин дахь нөлөө/, санхүүгийн нөөц гэсэн ерөнхий агуулгын хүрээнд 20 гаруй асуултыг багцлан асуусан.

Ярилцлагын үр дүнд голлох нөлөөтэй хувь хүний хүчин зүйлсийг багцлан тодорхойлсон. Эдгээр хүчин зүйлс улс төрч залуучууд эмэгтэйчүүдийн амжилтад голлох нөлөөтэй байна. Үүнд:

1. Хөрөнгө санхүү
2. Боловсрол
3. Гэр бүлийн байдал
4. Олон нийтэд танигдсан байдал
5. Туршлага
6. Танилын сүлжээ
7. Тууштай байдал
8. Ур чадвар

Дараах хэсэгт залуу улс төрчдийн амжилтад хувь хүний хүчин зүйлийн хувьд голлох нөлөө үзүүлдэг хүчин зүйлсийг тус бүр дэлгэрүүлэн авч үзлээ.

☉ 2.2.1 Хөрөнгө санхүү

Залуу болон эмэгтэй улс төрчдөд тулгамдаж буй хувь хүний шинжтэй хүчин зүйлсийг ач холбогдлын түвшнээр нь ихээс бага руу дараалуулан авч үзвэл тэдний хувьд хамгийн тулгамдсан асуудал нь хөрөнгө санхүү байна. Нэгдүгээрт улс төрийн сонгуульд оролцоход сонгуулийн зардал өндөр байдаг, хоёрдугаарт намын зүгээс залуучуудыг хөрөнгө санхүүгээр дэмжих боломжгүй байдагтай холбоотой. Залуу улс төрчдийн хувьд улс төрийн үйл ажиллагаа явуулах болон сонгуульд нэр дэвшихэд санхүүгийн чадамжтай байдлыг нь хардаг бөгөөд хэрэв сонгуульд нэр дэвшихээр зорьж байгаа бол санхүүгээ өөрөө даах чадавхтай байх нь голлох үзүүлэлт болдог. Энэ бол дийлэнх улс төрчдөд тулгардаг хамгийн эхний ерөнхий сорилт болоод байна. Хэрэв залуу улс төрч санхүүгийн хувьд баталгаатай бол тэр хүний улс төрийн замнал өнөөгийн улс төрд харьцангуй дардан байх бололтой.

“Яг одоо бол мөнгөтэй байх нь чухал байна. Яагаад гэвэл одоо явж байгаа сонгуулийн тогтолцоо ба улс төрийн намуудад хэвшчихсэн, намын хатуу гишүүнд шүүмжлэлтэй холбоотой, тэд нарыг барьж тогтоох нэг бодлого байдаг шүү дээ. Бүх намуудад л байдаг, тэр бас нөлөөлж байна. Яг одоогийн нөхцөл байдалд улс төрд орохын тулд, сонгуулийн зардлаа чи өөрөө даах юм уу, үгүй юу гэдэг бол хамгийн том шалгуур байдаг. Жишээлэх юм бол би ингээд нэр дэвших сонирхолтой байна, улс төрөөр явах хүсэлтэй байна, сонирхолтой байна гээд л хүмүүстэй уулзахад чи сонгуулийн зардлаа гаргаж чадна гэвэл ороод ир, чадахгүй гэвэл өөр цаана нь хүмүүс байна гэдэг”

35 настай, МАН –ын гишүүн

Нөгөөтээгүүр улс төрийн намын гол зорилго нь сонгуульд ялалт авах тул намаас нэр дэвшигчид илүү мөнгөтэй хүчирхэг байх нь давуу тал болдог. Учир нь судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар улс төрийн үйл ажиллагаа явуулах нь өөрөө маш их зардал шаардсан ажил. Энэ зардал, санхүүгийн бэрхшээл нь дөнгөж карьераа эхлүүлж байгаа залуучууд эмэгтэйчүүдэд хүндээр тусдаг.

Нэгэнт нөхцөл байдал ийм тул залуу болон эмэгтэй улс төрчид хандив босгох чадамжтай байх, эсвэл хувийн бизнестэй байх бүр эсвэл томоохон хандивлагчтай байх гэсэн хувилбарууд гарч ирдэг байна. Манай судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар хандив босгох чадвар бол улс төрч хүнд зайлшгүй байх ёстой сайн чадвар юм. Харин томоохон хандивлагчийн тухайд, дараа нь хандивлагчийнхаа барьцаанд орох зэрэг сөрөг талтай гэж судалгаанд оролцогчид үзсэн. Улс төрд амжилттай байхын тулд бусад олон хүчин зүйлс нөлөөлж байгаа ч хөрөнгө мөнгөтэй байж улс төрд оролцдог энэ байдал цаашлаад улс төрчид бие биеэсээ, бизнесийн байгууллагаас, хувь хүнээс хараат болох, мөнгөний байнгын хамааралтай болохоос өөр замгүй сүлжээ рүү татан оруулж байна.

“Сонгууль мөнгөөр хийгддэг учраас сонгуульд их мөнгө зарцуулж байгаа учраас ялахын тулд намууд мөнгө их гаргаж байгаа юм. Мөнгө их олох хэрэгтэй болж байгаа юм. Үүнээс шалтгаалаад нам шууд санхүүгийн хараат болж байгаа. Тийм учраас хэн их санхүүжилт өгч чадсан хүн тойрог авч байгаа. Тэгээд нэг ийм чөтгөрийн, химийн хичээлээр ярих юм бол гинжин урвал гэж юманд орчихоод байна. Ингээд хөрөнгөтөндөө барьцаалагдчихдаг, дараагийн сонгуульд ялах шаардлага гардаг хөрөнгө хэрэгтэй болдог. Тэгэхээр бид нар бол суурь тогтолцоо, Сонгуулийн тухай хууль, ялангуяа Үндсэн хуульд л бүр маш тодорхой, энийг өөрчилж зааж байж сонгуулийг бага мөнгөөр хийдэг болж байж боловсролтой, эрдэмтэй залуучууд ер нь төлөвшсөн залуучуудын хувьд сонгуульд гарах боломжтой.”

Дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, эрэгтэй

Улс төр дэх мөнгө санхүүгийн байдал нь намаас тухайн нэр дэвшигчийг нэр дэвшүүлэхэд чухал хүчин зүйл болдог бол иргэдийн дунд тэр дундаа сонгуулийн сана хураах үед мөнгө тараах нь үр дүнд хүрэх нөлөөлөл буурч байна. Энэ нь судалгаанаас харагдаж байгаа бөгөөд “Уг нь улс төрд мөнгөнөөс илүү боловсролтой хүн илүү амжилттай явах ёстой” гэсэн хандлага хүчтэй хэвээр байгаа нь анхаарууштай.

Одоо бол иргэдийн харах өнцөг өөрчлөгдсөн мянга мөнгө тараагаад гарч чадахгүй байна шүү дээ. Сая дүүрэг дээр би дүүргийн төлөөлөгч 8 удаа хийсэн том том хүмүүстэй өрсөлдсөн “За мөнгөө авчхаад чамд өгчихсэн шүү” гэсэн хүмүүс зөндөө байна.

Ерөнхийдөө улс төрийн үйл ажиллагаа нь бүхэлдээ зардал байдаг бөгөөд шинэ залуу улс төрчдөд ирж байгаа энэ хөрөнгө санхүүгийн бэрхшээл нь аль ч түвшний улс төрд эхлэх босгыг тэгш тавьж өгдөггүй, хөрөнгө санхүү дээр тулгуурласнаар хүн бүр адил тэнцүү өрсөлдөх боломжийг үгүй хийж байна. Муу талаас нь харвал энэ нь мэдлэг боловсролтой залуучуудыг улс төрд оролцохоос зайлсхийх, улс төр нь дан ганц мөнгөтэй хүмүүсийн оролцох зүйл болгож харагдуулах сөрөг нөлөөтэй байна. Судалгаанд оролцогчдын хувьд санхүүгийн бэрхшээл нь улс төрийн бэрхшээлийн номер нэг шалтгаан болж байгааг энд дахин дурдах хэрэгтэй. Залуу улс төрчдийн хувьд санхүүгийн бэрхшээлээс ангид байхын тулд сонгуулийн тогтолцоог системээр нь өөрчлөх, намын хатуу гишүүнчлэлийг болиулах зэрэг саналуудыг гаргаж байгаа бол зарим хэсэг нь улс төрд орж байгаа хүн өөрийн зүгээс шалтгаалах хөрөнгө санхүүгээ бэлтгэх нь угаас улс төрч хүний давах ёстой даваа гэж харж байгаа тохиолдол ч байна. Ямартай ч санхүүгийн хувьд тогтвортой байдлаа бүрэн хангаж чадахгүй ч, хамгийн багадаа сонгуулийн зардлаа даах бололцоотой байх нь залуу болон эмэгтэй улс төрчдөд тавигддаг нэн тэргүүний шалгуур болж байна. 2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгээс харахад нэр дэвшигчдийн хувийн орлого нь анхаарал татахуйц өндөр байгаа юм. Жишээлбэл

2020 оны УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойрогт АН-аас нэр дэвшиж ялалт байгуулсан С.Одонтуяа гишүүний нийт орлого нь 159078.93 мянган төгрөг, УИХ-ын сонгуулийн 11 дүгээр тойрогт АН-аас нэр дэвшиж ялалт байгуулсан Д.Бат-Эрдэнэ гишүүний нийт орлого нь 1589600.00 мянган төгрөг байна. АН-аас УИХ-ын сонгуулийн 3 дугаар тойрогт нэр дэвшиж ялалт байгуулсан А.Адьяасүрэн гишүүний хөрөнгө орлогын мэдүүлэг 800000.00 мянган төгрөг, МАН-аас УИХ-ын сонгуулийн 16 дугаар тойрогт нэр дэвшиж ялалт байгуулсан Ш.Адьяаа гишүүний хөрөнгө орлогын мэдүүлэг 950000.00 мянган төгрөг. Эдгээр нь санамсаргүй байдлаар тодруулсан цөөн жишээ бөгөөд үүнээс харахад хөрөнгө санхүүгийн хувьд чадамжтай улс төрчдийн хувьд улс төрд амжилттай байх боломж нь илүү өндөр байна.

Мөнгө санхүүгийн нөлөөлөл улс төрд том байр суурь эзлэх тусмаа тухайн улс төрчийн бусад капиталуудад нөлөө үзүүлэх магадлал нь өндөр. Тухайлбал тухайн улс төрчийн санхүүгийн хамааралтай байдал нь шийдвэр гаргалтуудад нь нөлөөлөх, нийтийн эрх ашгийн төлөө зарчимтай улс төр хийх боломжийг нь хааж боогдуулах, цаашлаад улс төр дэх мөнгөний харилцан хамаарлыг дэвэргэх сөрөг талуудтай байна.

2.2.2 Боловсрол

Боловсрол нь хувь хүний нийгмийн давхраажилд эзлэх байр суурийг илэрхийлэх чухал шалгууруудын нэг бөгөөд нийгмийн шилжих хөдөлгөөнд чухал нөлөө бүхий хүчин зүйл билээ. Цаашлаад орчин үеийн нийгэмд байр сууриа баталгаажуулах, тодорхой хэмжээний карьер хөөх зэрэгт мөн тухайн хүний эзэмшсэн мэргэжил боловсрол чухал нөлөөлөх болжээ. Улс төрийн карьер хөөхөд мөн адил боловсролын шалгуур үзүүлэлт нөлөөтэй бөгөөд тухайн хүний эзэмшсэн мэдлэг ур чадварыг илэрхийлэх тул сонгогчдын зүгээс ч улс төрчид тавих чухал шалгууруудын нэг болдог байна.

Аймаг, нийслэл, дүүргүүдийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хэмжээнд

Иргэдийн төлөөлөгчийн хуралд нэр дэвших процесст боловсрол нөлөөлөх эсэх нь тухайн хүний өөрийн сонгосон улс төрийн нам, аль шатанд дэвших гэдгээс хамаараад ялгаатай байна. Хэдийгээр сонгогчийн зүгээс улс төрийн сонголт хийхэд боловсрол тодорхой хэмжээний үзүүлэлт болдог хэдий ч намаас нэр дэвших эрхээ авах процесс дээр энэхүү үзүүлэлт нөлөөлөхгүй байна. Тухайлбал улс төрийн голлох хоёр намаас нэр дэвших эрхээ авахын тулд боловсролоос илүүтэй хөрөнгө санхүү, танилын хүрээлэл голлох нөлөө үзүүлж байгааг судалгаанд оролцогчид дурдаж байлаа.

“Уг нь бол олон нийтэд боловсролтой байх нь чухал байдаг боловч нам дотор бол хэн мөнгөтэй, хэн олон хүнд нөлөөлж чадаж байгаа нь нэр дэвшиж байна. Тэгэхээр мөнгөтэй хүмүүст илүү ихийг боломжийг өгч байна. Тэгэхээр боловсролтой, зарчимтай залуучууд улс төрд олноор орж байж л энэ байдал өөрчлөгдөх байх. Улс төрд зөв явахын тулд зөв хүмүүсийн хүрээлэлд л орох нь чухал санагддаг.”

Орон нутгийн сонгуулийн хүрээнд буюу аймаг болон дүүргүүдийн хувьд намаасаа нэр дэвших эрхээ авахын тулд боловсролтой байхаасаа илүүтэй мөнгө болон танил тал нөлөөлж байна. Нийслэл болон орон нутгийн хувьд тодорхой ялгаа харагдсан нь орон нутгийн түвшинд боловсролыг илүүд үзэх, цааш ахиж дэвших боломж гэж харах байдал нийслэлээс илүүтэй байна. Тухайлбал орон нутгийн намд өөрийн байр сууриа бэхжүүлэх, тодорхой хүрээллийн бий болгоход боловсрол, ур чадвар чухал нөлөөтэй байна. Харин дүүргүүдийн хувьд хүн ам олонтой, нэр дэвших хүсэл сонирхолтой намын гишүүд олон байдгаас хамаараад нам доторх нэр дэвшигчдийн өрсөлдөөн их байдаг. Тиймээс дотоод сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийн зүгээс тавигдах шалгуурт боловсролын хүчин зүйлс мөнгө болон танил тал, хүрээлэл гэх хүчин зүйлст дарагддаг байна.

Улсын их хурлын түвшинд Улсын их хуралд нэр дэвшигчдийн хувьд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ялгаатай нь боловсрол хамгийн чухал нөлөөтэй гэх үзүүлэлт судалгаанд оролцогчдын зүгээс давамгайлж байна. Хэдийгээр намаас нэр дэвших эрхээ авахад тодорхой хэмжээний хөрөнгө санхүү, танил тал шаардаж байгаа ч мөнгөтэй танилтай гээд муу боловсролтой гэсэн үг хараахан биш юм. Цаашлаад урт хугацааны улс төрийн зорилго тавин төлөвлөж байгаа хүний хувьд боловсрол, ур чадвар хамгийн голлох шалгууруудын нэг болж байна. Нөгөө талаар боловсрол ур чадвар нь тухайн хүний санхүүгийн болон нийгмийн хүрээллийн бүрдэлтэд голлох нөлөөтэй байна.

Харин сонгогчдын зүгээс улс төрийн эрх мэдлийг хүлээлгэхийн тулд тодорхой хэмжээнд өөрийгөө бэлдэж боловсорсон хүнийг сонгох сонирхол өндөр байдаг. Улс төрийн алба нь нэн ялангуяа хууль боловсруулах хэмжээнд мэдлэг, өндөр ур чадвар шаарддаг тул хууль эрх зүй болон эдийн засаг санхүүгийн мэдлэг өндөртэй, тодорхой хэмжээнд эзэмшсэн мэдлэгээ ашиглан хуримтлуулсан туршлагатай хүн байх нь тун УИХ-д нэр дэвшихэд нэн чухал байна.


Боловсрол болон хүйсийн харьцаа Боловсрол нь нийгэмд өөрийн байр сууриа тогтоох нэг төрлийн хүчин зүйл болдог чухал хэмжигдэхүүн билээ. Тиймээс ч улс төрийн өрсөлдөөнд цаашид урт хугацааны карьер төлөвлөлтөд боловсролын зэрэг, хаана ямар боловсрол эзэмшсэн, ярам ур чадвартай гэдэг салшгүй чухал нөлөөтэй байдаг. Иргэд сонгогчдын зүгээс яг адилхан боловсролтой эмэгтэй болон эрэгтэй нэр дэвшигчдээс эрэгтэйг нь сонгох магадлал өндөр байдаг хэмээн судалгаанд оролцогч онцолж байна. Тиймээс эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдтэй адил хэмжээнд улс төрийн оролцоотой байхын тулд илүү өндөр боловсрол эзэмших шаардлагатай болж байгаа дүр зураг ажиглагдаж байна.

“Эсрэг хүйсийн хоёр хүн байхад эмэгтэйчүүд хоёрт тавигддаг. Хэрвээ би эрэгтэй байсан бол гэж бодох үе олон байсан. Цаашидаа энэ байдал өөрчлөгдөх байх.”

АН-ын гишүүн, эмэгтэй

Улс төрийн үйл ажиллагаанд оролцохдоо хөрөнгө санхүү, болон хүрээллийн хувьд харьцангуй сул талтай байгаа эмэгтэйчүүд болон залуучууд бусад нэр дэвшигчидтэй адил тэнцүү хэмжээнд гарч өрсөлдөх гол арга зам нь боловсролын түвшин болон болж байна. Боловсрол ур чадварыг эзэмших үйл явц нь цаашлаад нийгмийн капитал, санхүүгийн капиталаа бүрдүүлэх гол үндэс суурь нь болох юм. Тухайлбал 2016 болон 2020 оны аймаг дүүргийн иргэдийн төлөөлөгчдийг боловсролын төвшинг харьцуулбал бүрэн дунд тусгай тунд боловсролтой төлөөлөгчид бүгд эрэгтэй нэр дэвшигчид байна. Харин УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 20 хувийг бүрдүүлж байгаа эмэгтэйчүүдийн боловсрол эрэгтэйчүүдээс илүү байгаа нь өндөр боловсролтой байснаар хүлээн зөвшөөрөгдөх, нэр дэвших боломжийг нэмэгдүүлдэг нь харагдаж байна.

График 12. 2016 болон 2020 оны сонгуульд суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн боловсролын зэрэг хүйсээр.




Сүүлийн хоёр удаагийн сонгуульд УИХ-д нэр дэвшигчдийн боловсролын төвшнийг хүйсээр нь харьцуулан харвал эмэгтэйчүүдийн боловсрол эрчүүдээс илүү байна. Тухайлбал эмэгтэй нэр дэвшигчдийн дунд докторын зэрэгтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрчүүдээс 10 орчим хувиар илүү байна.

Мэргэжлийн давуу тал Судалгаанд оролцогчдын зүгээс улс төрд ороход, сонгуульд нэр дэвшихэд давуу тал болохуйц мэргэжлүүдэд “эрх зүйч, эдийн засагч, инженер, нийгэм судлаач, эмч, багш, сэтгүүлч” гэсэн мэргэжлүүдийг илүү давамгайл нэрлэж байна. Эмч болон багш хэмээх мэргэжлүүд нь орон нутгийн хувьд хамгийн их ард иргэдтэй тулж харьцдаг гэдэг утгаараа тодорхой хүрээнд танигдсан байдаг нь ихээхэн давуу тал болдог байна. Харин эрх зүйч, эдийн засагч мэргэжлүүд нь ИТХ болон УИХ нь хууль тогтоомж болон төсөв

санхүүгийн ажил гол төлөв хийж гүйцэтгэдэг учир илүү тохиромжтой хэмээн үзэж байлаа.

Нөгөө талаас хууль тогтоох, иргэдийг төрд төлөөлөх байгууллагуудад салбар бүрийн төлөөлөл байх шаардлагатай хэмээн нэг хэсэг нь үзэж байна. Ингэхдээ мэргэжилдээ сайн байхаасаа илүүтэй тухайн салбарын асуудлыг мэддэг, ойлгодог хүмүүс сонгогдох, улс төрч болох ёстой хэмээн үзэж байлаа.

График 13. Аймаг дүүргүүдийн ИТХ-ын төлөөлөгчдийн мэргэжлийн байдал.



Аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг мэргэжлийн бүтцээр нь графикт харууллаа. Үүнд судалгаанд оролцогчдын дурдсанчлан эдийн засагч, инженер, эрх зүйч, багш, эмч мэргэжилтэй төлөөлөгчид дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэргэжлийн бүтцэд ч мөн адил тус мэргэжлүүд давамгайлжээ. Харин мэргэжилгүй буюу бүрэн дундаас доош боловсролтой төлөөлөгчдийн эзлэх хувь хамгийн бага байна. Судалгааны үр дүнгээс харахад улс төрийн карьерт мэргэжлийн сонголт чухал нөлөөтэй байна.

2.2.3 Гэр бүлийн байдал

Улс төрийн карьер ахиулах, сонгуульд өрсөлдөж ялалт байгуулахад гэр бүлийн байдал хэрхэн нөлөөлдөг талаар тодруулахад судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь их, бага ямар нэг хэмжээгээр нөлөөлдөг талаар дурдсан. Харин ямар тойрогт, хаана, аль түвшинд өрсөлдөхөөс шалтгаалаад хэрхэн нөлөөлөх нь янз бүр байдаг байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын олонх нь гэр бүл зохиосон байх нь сонгогчдын шийдвэрт сайнаар нөлөөлдөг, эсрэгээрээ ганц бие

байх нь сонгуульд нэр дэвшихэд сөргөөр нөлөөлдөг талаар дурдаж байв. Энэ талаар 2016 оны Орон нутгийн сонгуульд өрсөлдөөд ялагдсан нь тухайн үед гэр бүл зохиогоогүй байсан нь тодорхой хэмжээнд нөлөөлсөн талаар БЗД-ийн нэгэн төлөөлөгч онцолж байсан. Харин эмэгтэй улс төрчдийн хувьд ганц бие байх, өрх толгойлсон ээж байх, гадаад нөхөртэй байх зэрэг нь улс төрийн карьерын хувьд эмзэг тал болдог талаар олонх эмэгтэй оролцогчид илэрхийлж байсан. Эрэгтэй улс төрч өрх толгойлсон байхыг илүү эергээр үнэлдэг ч, эмэгтэй улс төрчдийг доромжлох, гүтгэх, үл ойшоох үзэгдэл аль ч түвшний сонгуульд ажиглагддаг байна. Судалгаанд оролцогчдын зүгээс эрэгтэй улс төрчдийн гэр бүлийн асуудлыг хүмүүс төдийлөн хайхардаггүй ч эмэгтэй улс төрчдийн гэр бүлийн аливаа асуудлыг маш хурцаар хөндөж тавьдаг талаар онцолсон.

“...Бодит байдлыг эмэгтэй хүн гэдэг утгаар нь хүлээн зөвшөөрдөггүй хандлагууд их байна л даа. Эхнэрээсээ салчихсан эрэгтэй хүн бол зүгээр байдаг. Тэр бол асуудал биш... Гадаад нөхөртэй хүн ерөнхийлөгчид нэр дэвшинэ гэхэд хүмүүс яаж хүлээж авч байна. Манай нам дээр ч гэсэн ялгаагүй нэг жоохон салж сарнисан бол одоо тэр хүн улс төрд байх ёсгүй гэдэг ч юм уу. Энэ бол ёстой байж боломгүй явдал гэдэг. Гэтэл эрчүүд эхнэрээсээ салсан битгий хэл хэд хэдэн эхнэр сольчихоод байхад л энэ бол асуудал биш ээ, хүний амьдрал гэж хардаг. Тэгэхээр ер нь бол эмэгтэйчүүдийг л илүү их эмзэг хүлээж авдаг тийм хандлага байна.”

Өмнөговь аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Үүнээс гадна нийтлэг гардаг асуудал бол гэр бүлдээ зарцуулах цаг багасдаг явдал юм. Ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд гэр бүл, үр хүүхдээ анхаарахын сацуу улс төрийн ажилд оролцох, удирдлагуудад үнэлэгдэхийн тулд илүү хөдөлмөрлөх, хичээл зүтгэл гаргах гэх мэт хүндрэлтэй асуудал эрчүүдээс илүү тулгамддаг. Нөгөөтгээгүүр эрэгтэй улс төрчид гэр бүл, улс төрийн ажлыг хослуулах боломжтой төдийгүй ар гэрийн ажлыг ихэнх тохиолдолд эмэгтэйчүүд хариуцдаг тул асуудал харьцангуй бага байдаг бол эмэгтэйчүүд зарим тохиолдолд гэр бүл, улс төр хоёроос сонголт хийх шаардлага ч бий болдог талаар зарим залуу улс төрчид ярьж байв. Үүнийгээ дагаад улс төрч эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлт хойшлох, гэр бүлийн тогтворгүй байдал үүсэх эрсдэл бий болдог байна.

“...Эмэгтэй хүний хувьд гэр бүлийн байдлаас их шалтгаална. Ялангуяа улс төрд бол ар гэрийг нь сайн авч явах гэр бүлийн хүн чухал. Эрчүүдийн хувьд бол өөр байх. Улс төрд идэвхтэй эмэгтэйчүүд гэр бүлийн хувьд тогтвортой бус байх тал харагддаг.”

Дүүргийн ИТХ-д нэр дэвшигч, эмэгтэй

Цаашлаад гэр бүл, нийгмийн дээрх асуудлаас үүдэн эмэгтэйчүүдийн улс төр дэх идэвх, оролцоо сул байдаг талаар бусад оролцогчид хэлж байв. Хэдийгээр хувь хүний сонголтын асуудал мэт боловч бодит байдал дээр эмэгтэй хүн улс төрийн карьер ахиулахын тулд эрэгтэйчүүдээс илүү тууштай байдал, хичээл зүтгэл зарцуулах

шаардлагатай байдгийг илэрхийлж байна. Зарим талаар эмэгтэй улс төрчийн гэр бүлийн байдал нь тухайн хүний мэдлэг боловсрол, ур чадвараас ч чухал шалгуур үзүүлэлт болдог талаар судалгааны зарим оролцогчид дурдаж байсан.

Орон нутагт сонгуульд өрсөлдөж буй залуу улс төрчдөд эцэг, эхийн нэр хүнд танигдалт маш чухал нөлөөтэй байгааг олон оролцогчид хэлж байв. Жишээ нь Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчийн хуралд МАН-аас нэр дэвшигч дурдахдаа “...Миний хувьд бол аав ээж нь ингээд л одоо сайн ч гэдэг юм уу, олон жил хүмүүст танигдчихсан учраас орон нутгийн сонгуульд дэвшээд явж байхад аягүй их нөлөөлж байгаа юм. Зарим хүмүүсийг болохоор одоо аав нь тийм гэсэн, ингэсэн гэсэн. Ээж нь тийм байсан гэсэн энэ тэр гэдэг явган яриа хүн болгоны аманд явдаг юм байна лээ. Тэгээд сөрөг хүчин нь ч тиймэрхүү юмыг нь аягүй их сэвдэг...” Ялангуяа ахмад сонгогчдын хувьд энэ шалгуурыг чухалд тооцдог болохыг уг асуудлыг хөндөж ярьсан оролцогчид дурдаж байлаа. Цаашилбал гэр бүлийн гишүүдээс олон нийтийн дунд нэр хүнд муутай байх нь тухайн улс төрчийн амжилтад сөргөөр нөлөөлж байгааг судалгааны зарим оролцогчид онцлон дурдаж байсан юм.

Эцэг эхийн танилын хүрээ улс төрд ороход давуу тал болохоос гадна аль нийгмийн давхаргаас гаралтай зэрэг нь улс төрийн нөөцийн маш том ялгааг гаргадаг байна. Эцэг, эх нь хөрөнгө бэлтэй байх тусмаа өндөр боловсрол эзэмших боломжоор хангагдаж, залуу улс төрчдөд тулгамддаг хамгийн хүнд асуудал болох санхүүгийн асуудлаа шийдүүлж, нэг ёсондоо тэгш бус гарааны нөхцөл бий болж байгаа талаар цөөнгүй оролцогчид дурдсан юм. Энэ нь эргээд мэдлэг, ур чадвараас гадна санхүүгийн хүчин зүйл улс төрийн амжилтад нөлөөлдөг болохыг тодотгож байв.

“Зарим албан тушаал хашиж байгаа ижил насны залуучууд энэ тэрийг харахаар өмнөөс нь аав ээж энэ тэр нь аягүй сайн карьер хийчихсэн. Тэгээд мөнгөтэй, бизнестэй тэд нар бол илүү хурдан яваад байгаа нь илт байна л даа...2010 онд Учрал, Тэмүүлэн, Оюун-Эрдэнэ, Номтойбаяр энэ тэр гээд бид нар чинь бүгдээрээ л адилхан гараатай эхэлсэн гэж үзэж байгаа шүү дээ. Тэгж байхад минийх бол хамаагүй удаан явж байгаа, яг бор зүрхээрээ өөрийнхөөрөө хүчээр явж байна гэсэн үг...”

МАН-ын гишүүн, эрэгтэй

УИХ-ын сонгуулийн түвшинд “харь” гаралтай эсэх талаар хар пи-ар гарах нь түгээмэл байдгаас гадна орон нутагт дэвшиж буй тохиолдолд тухайн нутагт төрсөн эсэх нь чухал байдаг талаар аймаг, дүүргийн иргэдийн төлөөлөгчид өөрсдийн туршлагаас дурдаж байсан. Үүнээс гадна тухайн орон нутагт аль нэг угсаатан давамгайлж оршин суудаг бол өөр угсаатан ястныг сонгох нь маш бага байдаг төдийгүй энэ үзэгдэл нийслэлийн зарим тойрог дээр ч ажиглагддаг талаар судалгаанд оролцогч залуу улс төрчид илэрхийлж байв.

Энэ мэтчилэн гэр бүлийн байдал нь хувь хүний мэдлэг, ур чадвар, үзэл баримтлал гэх мэт бусад хүчин зүйлээс гадна улс төрийн чухал нөөцийн нэг хэвээр байна.

❖ 2.2.4 Олон нийтэд танигдсан байдал

Улс төрд амжилттай байхын тулд олон нийтэд танигдсан байх нь чухал нөлөөтэй. Тэр утгаараа хувь улс төрч өөрөө ямар дүр төрхөөр олон нийтэд танигдах болон хэрхэн яаж танигдах гэдэг нь тухайн улс төрчийн цаашдын үр дүнг тодорхойлох чухал сонголт, шийдвэр байдаг. Судалгаанд оролцогчдын дүгнэж байгаагаар иргэд, сонгогчид таньдаг хүнээ сонгох магадлал ихээхэн өндөр байдаг. Ганцаарчилсан ярилцлагуудын үр дүнд үндэслэн улс төрчдийн хувьд сонгогчдод танигдах боломжуудыг доорх байдлаар тодорхойллоо.

- Ажил мэргэжлээрээ танигдах
- Улс төрчийн дүр төрх буюу имиж бүрдүүлэлтээрээ танигдах
- Хичээл зүтгэлээрээ сонгогчдод танигдах боломж өндөр байна.

Ажил мэргэжлээрээ танигдах Улс төрд хүч сорьж байгаа хүмүүсийн ажил мэргэжил нь харилцан адилгүй давуу сул талтай боловч сонгогчдод танигдах боломж нь нийгмийн ухааны салбарын мэргэжилтнүүд тэр дундаа сэтгүүлч, багш, судлаачдад бусад салбарын мэргэжилтнүүдтэй харьцуулахад илүү өндөр байна. Нөгөө талаас сонгогчид хуульч, эдийн засагч мэргэжилтэй хүмүүсийн илүүтэй сонгох магадлал өндөр байдаг нь өмнөх сонгуулиудын үр дүнгээс харагдана. Тийм ч учраас залуу улс төрчид мэргэжил дээшлүүлэх, дахин шинэ мэргэжлээр суралцах тохиолдол элбэг байна. Энэ нийгмийн хүлээлт нь өнөөгийн бодит нөхцөл байдал дээр үндэслэсэн гэж хэлж болно. Тухайлбал иргэдийн ахуй амьдралд тулгамдсан асуудлууд нь шударга ёсны тэр дундаа авлигал хээл хахууль, тэгш бус байдал байгаа тул иргэд хуульч, эрх зүйч мэргэжилтэй хүмүүсийг илүү хуулийн хүрээнд шударга ёсыг тогтоож чадна гэж үздэг.

Улмаар улс төрч болоход, ур чадвар эзэмшихэд нөлөөлж болох мэргэжлийн талаар асуулт асуухад бүх түвшинд нийгмийн шинжлэх ухааны мэргэжлийн санал болгосон байгаа нь сонирхол татаж байна. Тодруулбал эдийн засагч, хуульч, сэтгүүлч, улс төр судлаач, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч гэсэн хариултууд эзэлж байна. Ялангуяа орон нутагт багш, эмч байх нь олон хүнтэй ажилладаг тул давуу тал болдог гэж үзжээ. Олон хүнтэй харилцах, яриа болон харилцааны чадвар өндөр байх нь улс төрчдөд ихээхэн давуу талтай.

Нөгөө талаас мэргэжлийн нэр хүнд тухайлбал инженер, байгалийн ухааны мэргэжилтэй байх нь иргэдийн хувьд итгэл үнэмшил төрүүлдэг.

Улс төрчийн дүр төрх буюу имиж бүрдүүлэлтээрээ танигдах Улс төрчдийн хувьд уран итгэгч, тэмцэгч дүрээр танигдах болон амлалт өгөх зэрэг нь нэгэнт иргэдийн хувьд хуучирсан хандлага болж байна. Залуу улс төрчдийн үзэж

байгаагаар иргэдэд танигдах хамгийн зөв арга нь эрдэм боловсролоороо танигдах түүнчлэн иргэдтэйгээ илүү ойр байж идэвх зүтгэлтэй ажиллах зэрэг нь чухал гэж үзэж байна.

Манай улс төрчдийн өмнөх түүхүүдээс харахад худал амлалтууд өгдөг, тойрогтоо ажилладаггүй зэрэг нь иргэдийн бухимдлыг төрүүлдэг, тухайн улс төрчид итгэх итгэлийг үгүй хийдэг хандлагууд юм. Тиймээс сонгогчдын хүсэл сонирхол нь илүү тэдэнтэй ойр байж асуудлуудыг нь шийдвэрлэхэд сэтгэл гарган ажилладаг улс төрчийг сонгох магадлал өндөр байдаг. Түүнчлэн тойрогтоо ажиллаж амьдардаг, тухайн тойрогт өсөж төрсөн байх нь тухайн улс төрчийн олон нийтээс өндөр үнэлгээ авахад дэмжлэг болдог. Иргэдийн зүгээс ирж байгаа энэхүү хандлага нь шинэ залуу улс төрчд илүү мэргэших, улс төрийн карьераа эхнээс нь зөв нягт нямбай төлөвлөх шаардлагатай байгааг илтгэж байна. Гэвч нөгөө талаас иргэдэд танигдах арга барил нь бэлэг сэлт өгөх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг мөнгө санхүү зарцуулах зайлшгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Энэ нь эргээд тухайн улс төрчдөд хүндрэл учруулдаг байна.

Олон нийтэд танигдах бас нэгэн чухал суваг нь нийгмийн сүлжээнд идэвх оролцоотой байх юм. Нөгөө үед иргэдтэй холбогдох хамгийн дөт бөгөөд шууд нөлөөлж болох арга зам нь Facebook, Twitter зэрэг нийгмийн сүлжээгээр дамжуулан оролцох юм. Олон нийтэд танигдах нөлөөлөх энэ арга нь тухайн улс төрчид илүү өндөр боломжийг авч ирэхээс гадна буруу үйлдэл гаргавал олон нийтэд нэр хүндээ асар богино хугацаанд алдах, цаашлаад улс төрийн карьер сүйрэх эрсдэл ч байна. Олон нийтийн сүлжээнд идэвх оролцоотой байх нь тухайн улс төрчөөс хувь хүний илүү их нөөцүүдийг шаардаж байдаг. Тухайлбал улс төрчийн харагдах байдал, царай, дүр төрх, биеийн өндөр нам зэрэг улс төрчийн гадаад үзэмж нь цахим орчинд нөлөөтэй байна.

Хичээл зүтгэлээрээ сонгогчдод танигдах Судалгааны үр дүнд шинэ залуу улс төрчид монголын улс төрийн нөхцөл байдалтай танилцах, сонгогчдоо мэдэрч ажиллах нь амжилтын үндэс болсон чухал ойлголт гэдэг нь харагдаж байна. Энэ нь манай сонгогчдын хандлага, зан үйлтэй холбоотой юм. Манай сонгогчид аль ч түвшний улс төрчид өөрсдөд нь илүү их анхаарал халамж хандуулах, байнгын харилцаа холбоонд байх, асуудлуудаа тэр бүрд нь шийдүүлэх сонирхолтой байдаг. Энэ байдал нь улс төр дэх залуучуудад өөрийгөө таниулахад нь чухал нөлөөтэй. Сонгогчдын хүслийг биелүүлж ажиллах нь тухайн улс төрчөөс ихээхэн хичээл зүтгэл шаарддаг. Энэ боломж нь анхан болон дунд шатны засаг даргын ажлыг хашиж буй улс төрчдөд илүү их байна. Өөрөөр хэлбэл иргэдтэй илүү ойр ажиллах тэдний аж ахуй асуудлуудыг амжилттай шийдвэрлэж, тухайн албан тушаалдаа сайн ажиллах нь улс төрчийн карьерт эерэг нөлөөтэй. Түүнчлэн анхан болон дунд шатанд амжилттай ажиллаж өөрийгөө таниулж чадсан улс төрчид ахисан түвшний сонгуульд нэр дэвшээд ялалт байгуулах магадлал нь өндөр

байгаа юм. Нөгөө талаасаа анхан болон дунд шатны албан тушаалтнууд ажлын гүйцэтгэл хангалттай биш бол иргэдийн зүгээс итгэл алдаж, тухайн тойрогт сонгуульд өрсөлдөх зэрэг цаашдын үйл ажиллагаанд нь сөрөг нөлөө үзүүлдэг.

☉ 2.2.5 Турилага

Судалгаанд оролцогчдын дүгнэснээр улс төрчдийг үнэлэх иргэд, сонгогчдын үнэлэмж нь тэдний амжилтыг тодорхойлоход нэн чухал нөлөөтэй. Иргэд, сонгогчдын улс төрчдийг үнэлэх шалгуурт тухайн улстөрчийн туулж ирсэн замнал, мэргэжлийн болоод улс төрийн туршлага дээгүүр байр эзэлж байна. Залуу улс төрчдийн хувьд олон жилийн мэргэжлийн болон улс төрийн туршлага хуримтлуулаагүй байдаг нь иргэдийн итгэл, хүндэтгэлийг хүлээхэд сул тал болдог.

2016 болон 2020 оны УИХ-ын гишүүдийн ажлын туршлагыг салбараар нь авч үзвэл төрийн улс төрийн албанд ажилласан туршлага хамгийн өндөр байна. Хувийн салбар болон төрийн захиргааны албанд ажилласан туршлага удаалж байна. Энэ нь улс төрд нөлөөлөх, нэр дэвших, сонгогдох боломж хязгаарлагдмал хүрээнд байгааг илэрхийлж байна.

Улс төрийн төрийн туршлага нь өргөн утгаараа тухайн хүний улс төрийн талбарт хуримтлуулсан нөөц юм. Улс төрд зарцуулсан хугацаа их байх тусам улс төрийн замналдаа бүрдүүлсэн хүрээлэл, олон танигдсан байдал нь нэмэгддэг шууд хамаарал ажиглагдаж байна.

Залуу хүн учраас турилагагүй гэгддэг үе зөндөө байгаа. Тиймээс анхан шатнаас нь үе шаттай дээшлээд явах ёстой.

Судалгаанд оролцогч МАН-ын гишүүн, 34 настай, эрэгтэй

Мөн улс төрийн нам доторх аливаа өрсөлдөөнд тухайн намд хэзээ элссэн хугацаа нь чухал нөлөөтэй байдаг ажээ. Тухайлбал намын гишүүнээр эрт элссэн байх нь намын болоод намаар дамжиж очих байр суурь албан тушаалд хүрэх “оочир” дараалалд урдуур зогсох боломж олгодог. Тэднийг намын шат шатанд ажиллаж ирсэн намын жирийн гишүүдийн зовлон жаргалыг мэдэх давуу талтай гэж үздэг байна. Энэ нь залуучууд туршлагын хувьд дутуу гэж үнэлэгдэх, нэг талаасаа шатлан дэвших, нөгөө талаасаа иргэний улс төрийн боломжийг хязгаарласан хязгаарлалт болж байна. Гэвч шатлан дэвших зарчимд цаг хугацааны дараалал бус ур чадварын шалгуурыг гол болгох нь зүйтэйг судалгаанд оролцогчид онцолж байна.

Боловсролын салбартаа ажиллаад энэ чиглэлд хийх ёстой олон өөрчлөлтүүдийг мэдэрч, үүнийг өөрчилнө гэсэн эрмэлзэлтэй намд элссэн. Үүнийгээ ч боломж олдох үеүдэд намынхандаа нээлттэй илэрхийлж байсан. Гэвч шийдвэр гаргах түвшинд өрсөлдөх, бодлого хэрэгжүүлэх боломжтой албан тушаалуудад чиний хийх гэсэн бодлого, шийдлүүд огт хамаагүй, намд зүтгэсэн хугацаа фракцаараа шийдэгдэж байна. Энэ бол маш хэцүү.

МАН-ын гишүүн, 36 настай, эмэгтэй

Улс төрийн туршлага нь улс төрийг сонирхон судлах, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, санал бодлоо олон нийтэд хүргэх, намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох зэргээр хуримлагдаж эхэлдэг. Судалгаанд оролцогчдын дүгнэснээр хамгийн ихээр туршлагаждаг цэг нь улс төрийн сонгуульд нэр дэвших, өрсөлдөх байна. Сонгуулийн үеийн сайн дурын зохион байгуулалт, сонгуулийн албан ёсны кампанит ажилд оролцох зэргийг үүнд багтаан үзэж болно.

2016 болон 2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн статусыг насны бүлгээр харьцуулан үзэхэд 35 хүртэлх насны залуу нэр дэвшигчдийн дийлэнх хувь нь намын байгууллага болон хувийн хэвшилд ажиллаж байсан бол нас ахих тусам улс төрийн албан тушаал эрхэлж байсан нэр дэвшигчдийн хувь нэмэгдсээр 55-с дээш насны нэр дэвшигчдийн 72 хувь нь улс төрийн алба хашиж байна.

Мөн ажил мэргэжлийн салбартаа өндөр туршлага хуримтлуулж, иргэдэд танигдсан мэргэжилтнүүд улс төрд ороход тухайн хүнийг мэргэжлийн туршлагаар нь үнэлж хүлээж авдаг. Нөгөө талаас туршлагатай мэргэжлийн хүн төрд орж ирлээ гэж үнэлдэг, мөн улс төрийн бус мэргэжлийн ажлаа хийвэл нийгэмд илүү хэрэгтэй гэж шүүмжлэн үздэг гэжээ. Гэвч энэ хандлага нь мэргэжлийн эмч, инженер, эдийн засагч, хуульч, сэтгүүлч зэрэг тодорхой цөөн мэргэжлийн хүрээнд үйлчилж байна.

📍 2.2.6 Танилын хүрээ

Энэ хэсэгт улс төрд танилын хүрээ нь залуучууд, эмэгтэйчүүдийг нам дотор байр сууриа бэхжүүлэхэд болон сонгуульд нэр дэвшиж ялалт байгуулахад хэрхэн нөлөөлөл үзүүлж буйг дүгнэхийг зорилоо. Улс төрд танилын хүрээ нь намд элсэх, намын дэргэдэх байгууллагын үйл ажиллагаанд оролцох, улмаар нэр дэвших, сонгогдох зэрэгт тодорхой нөлөөлөл үзүүлж байгаа. Гэвч чухам уг нөлөөлөл нь залуучууд, эмэгтэйчүүдийг улс төрд амжилт гаргахад дэмжлэг, саадын аль нь болж буйг бид оролцогчдын хариултуудыг нэгтгэн дүгнэх байдлаар тодорхойлохыг зорьсон болно. Юун түрүүнд улс төр дахь танилын хүрээний нөлөөнөөс илүүтэй нийгмийн бүхий л салбарт танил тал хэрхэн нөлөөлөл үзүүлдэг тухайд дурдах нь үндсэн асуудлаа илүү тодотгоно. Танилын

хүрээ гэдэг урьдаас мэддэг байх, ажил хэргийн холбоотой байх буюу хүрээлэл, сүлжээ зэргээр ч ойлгож болно. Нөгөөтээгүүр бие биенээ таньдаг байх нь аливаа асуудлыг хурдан, хялбар байдлаар шийдвэрлэх арга зам буюу шийдвэр гаргагч ч тэр асуудалд өөрөөр ханддаг. Ялангуяа бид аливаа нэг ажил хөөцөлдөх эсвэл мэдээлэл авах, мөн тухайн асуудал нь хэн нэгнийг таних эсэхээс үл хамаарч шийдвэрлэгдэх байсан ч тэр дүрэм журмын дагуу гэхээс илүүтэй тухайн салбар дахь танил нэгнээ хайх нь элбэг байдаг. Тэгвэл энэ байдал улс төрийн намд ч тодорхой нөлөөллөө хадгалсаар байна. Гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олон гэх мэт нийгэмшлийн агентууд нь бидний шийдвэр гаргалт болон үзэл бодол, үнэт зүйлс, үнэлэмж зэрэгт онцгой нөлөөлөл үзүүлж байдаг. Энэ нэг талаас улс төрийн намд элсэж үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцоход хэн нэг танилаасаа мэдээлэл дэмжлэг авсан байх, нөгөө талаас улс төрийн намд дотор өөрийн орон зайг бий болгохыг зорьж буй бол өөрийн итгэлтэй хүмүүсээ сонгон оруулах талтай. Учир нь улс төрийн намд хэн илүү дэмжлэгтэй буюу хүрээлэлтэй нь нэр дэвшихээ эрхээ олж авах болон аливаа хамтын шийдвэрт давуу тал олж авдаг. Өөрөөр хэлбэл аль нэг талаараа холбоо хамаарал бүхий адилсах шинжтэй байхыг зорьдог гэж хэлж болно. Энэ талаар судлаач Д.Ганхуяг “Монголын нийгмийн харилцааны онцлог” өгүүлэлдээ “Ажаад байхад Монголын нийгмийн харилцааны субъектүүд бие биедээ маш ойрхон (газар зүйн утга энд хамаарахгүй), хүмүүсийн харилцаа садан төрөл, нутаг ус, танил талын холбоонд илүүтэй түшиглэсэн, хүмүүсийн харилцаа холбооны аливаа тогтвортой хэлбэр нийгэмд бүхэлд нь эерэг болон сөрөг хүчтэй нөлөөлөл үзүүлэх магадлал ихтэй, аливаа асуудлыг хууль номоос гадуур шийдэх үндэслэл дээгүүр байдаг онцлогтой. Нэг үгээр хэлбэл монгол бол танил тал, хамаатан садангийн орон мөн. Энэ нь онолын хэллэгээр бол монголын нийгмийн харилцаамжийн макро ба микро түвшний хүрээ хэт ойрхон, машид холилдсон гэсэн үг юм” гэжээ.

Танилын хүрээний нөлөөллийг дараах байдлаар ангилан авч үзье. Үүнд:

- Нутаг усны холбоо
- Нэг үеийнхэн, төгсөлтийнхөн (мэргэжлийнхэн)
- Намын хамаарал
- Цахим сүлжээ
- Клуб, ТББ, сан зэрэг болно.

Нутаг усны холбоо Монголчуудын нутгархаг байдал олон зүйл дээр ажиглагддаг. Тухайлбал үндэсний баяр наадмаараа өөрийн нутгаас бөх төрвөл ихэд хүндэтгэн авч үздэг нь нэг жишээ юм. Цаашлаад бүхий л салбарт нэг нутгийнх байх нь бие биенээ дэмжих, хамтран ажиллах нөхцөл болно. Тухайлбал УИХ гишүүд өөрийн сонгогдсон тойрог болон нутгийнхаа хүмүүсийг албан тушаалд байршуулах зэргээр өөрийнхөө нөлөөллийг тэлэх оролдлого хийдэг. Сонгогчдын хувьд ч нэр дэвшигчийг сонгохдоо тухайн тойрогтоо төрж өссөн

эсвэл ажиллаж амьдардаг байхыг чухалчилдаг. Тэр тусмаа бүх шатны сонгуульд нэр дэвшигчид дэвших тойргоо сонгохдоо өөрийн төрсөн нутгаас эсвэл амьдарч буй газарт дэвших сонирхолтой байдаг. Энэ талаар судалгаанд оролцогч хариулахдаа

Мөн аймаг, сумдын нутгийн зөвлөлийн бол тухайн нутгийн иргэдийг өөр хоорондоо уулзах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэг бөгөөд улс төрчдийн хувьд ч чухал байгууллага юм. Судалгаанд оролцогчдын хувьд тухайн орон нутгийнхаа нутгийн зөвлөлийн тэргүүн, тэргүүлэгчээр гишүүнээр ажилладаг тухай дурдсан болно.

Нэг үе, төгсөлтийнхөн Дунд сургуульд 8-12 жил, их дээд сургуульд 4-6 жил хамт суралцаад ирэхээр өөр хоорондоо ойр дотно болон хамтач сэтгэлгээтэй болох бий. Энэ байдал нь цаашид ажил амьдралын олон талбарт хамран ажиллах, биенээ дэмжих чухал холбоо хамаарал болдог байна. Мөн ижил мэргэжил, сонирхолтой байх эсвэл тухайн салбарын асуудлыг хөндөж өөрийгөө хамаатуулах тохиолдол байна. Эрүүл мэндийг салбарынхан эмч мэргэжилтэй хүнийг дэмжих, боловсролын салбарынхан багш хүнийг дэмжих зэргээр ажиглагддаг. Жишээлбэл УИХ-н гишүүн Н.Учрал “Монголын залуу багш нарын холбоо”-ны тэргүүнээр ажилладаг бөгөөд үргэлж боловсролын салбарын ажилтан, алба хаагчдын эрх ашгийг талаар санаа бодлоо илэрхийлдэг байдал нь боловсролын салбарынхны дэмжлэгийг тодорхой хэмжээнд авдаг.

Намын хамаарал Сонгуулийн үр дүнд олонх болсон нам төрийн эрх мэдлийг авч бодлогоо хэрэгжүүлэх ба өөрийн намын боловсон хүчнээ төрийн албан байршуулдаг. Товчхондоо нэг намын гишүүд төрийн болон хувийн ажил албан хашиж буйгаас үл хамааран бие биенээ дэмжих хандлагатай. Мөн нам дотор өөрийн багаа бүрдүүлэх зорилгоор итгэж болох намд байр сууриа бэхжүүлсэн нэг нь бусдыгаа намд элсүүлэх, намд доторх чухал албан тушаалд байршуулах ч тохиолдол бий. Орон нутгийн төвшинд ялгаагүй намын шийдвэр гаргах бүтцэд өөрийн ойрын хүрээллийн хүмүүсээ оруулахыг зорьдог байдал ажиглагддаг. Мөн энэ тухайд судалгаанд оролцогч “Улс төрд зөв явахын тулд зөв хүмүүсийн хүрээлэлд л орох нь чухал санагддаг” гэж хариулсан бөгөөд намд элссэн дараа ч тэр нам доторх аль нэг бүлэгт багтах шаардлага гардаг байх нь. Судалгаанд оролцогчид намын удирдлагын төвшинд болон намд нөлөө бүхий нэгний дэмжлэгийг авахгүйгээр нэр дэвших эрхээ олж авах нь бэрхшээлтэй гэдгийг ч дурдаж байсан юм.

Хот хөдөө гэлтгүй сонгуулийн насны хүн амын дунд голлох байр суурь эзлэх бүлэг бол залуучууд тэр дундаа их, дээд сургуулийн оюутнууд байдаг. Тийм учраас их, дээд сургуулийн оюутны холбоо, аймаг сумын оюутны холбоо, залуучуудын холбоо зэрэг нь сонгуулийн үеэр идэвхтэй ажилладаг. Мөн эдгээр холбооны үйл ажиллагаанд оролцох явцдаа улс төрийн намын сонголт хийх,

улмаар тухайн багаараа улс төрд ордог бөгөөд залуучууд, оюутнуудыг татах зорилгоор улс төрийн намууд дэргэдээ ахмад, залуучууд, эмэгтэйчүүдийн зэрэг байгууллагуудыг байгуулдаг. Энэ нь залуучууд болон эмэгтэйчүүдийг улс төрд орох, хүрээллээ бий болгох, нэр дэвших, намын удирдлага болон гишүүдтэй холбоо харилцаа тогтооход дэмжлэг болж байна. Судалгаанд оролцогч МАН-ын гишүүдийн хувьд НАМЗХ, НАМЭХ, НАМОХ зэрэг байгууллагын үйл ажиллагаанд татагдан оролцож, улмаар намын гишүүнээр элссэн тухай дурдсан болно. Тухайлбал судалгаанд оролцогч ИТХ төлөөлөгч хэлэхдээ: *“НАМЗХ гээд залуучуудын холбоо байгаа. Тэр шугамаараа бид нар 1000 залуучуудын чуулган, 1000 залуусын шинэ жил гэх мэт ажлууд зохион байгуулдаг байсан. Би сонгуульд орохынхоо өмнө 2020 оны зуун ТББ байгуулаад охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах зорилгоор Баянзүрх дүүргийнхээ залуу эмэгтэйчүүдийг цуглуулж уулзалт хийж байсан. Тэндээс энэ хүн юунд зориод, яагаад ингээд яваад байдаг вэ гэдгийг хүмүүс ойлгосон байх гэж бодож байна”* гэсэн болно.

Клуб, ТББ, сан Улс төрчдөд томоохон дэмжлэг болох бүлэг бол төрөл бүрийн сонирхлын бүлэг, клуб зэрэг болно. Тухайлбал төрөл бүрийн спортын холбоод, урлагийн клуб, сан, ИНБ болон ТББ зэргээр дамжуулан хүрээллээ тэлэх, олон нийтэд өөрийгөө таниулах зэрэгт ач холбогдолтой байдаг байна. Судалгаанд оролцогчдын хариултаас дүгнэвэл ижил зорилгоор хэсэг бүлгээрээ эвлэлдэн нэгдэж тухайн бүлгийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулах явцдаа олонд танигдаж улмаар улс төрд орсон тохиолдлууд ч байна. Судалгаанд оролцогч энэ тухайд *“Нэгэн үндэс”* гээд хүмүүнлэгийн ажил хийж байлаа. *Тэгээд тэгж мэдэрсэн хүмүүс нь, залуучууд нь нийлээд “Нэгэн үндэс” гэж юм байгуулаад тэгээд хүүхдүүд рүү чиглэсэн ажил хийсэн дээ. Жилд нэг мянга орчим хүүхдэд тусалдаг бэлэг өгдөг. Эхлээд бэлэг өгдөг байсан. Сүүлдээ бид нар сургалт руу чиглэсэн бэлэн өгөх нь хүнд хэрэггүй юм байна гээд. Тэгээд л хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд рүү ханддаг болоод. Тэгээд улс төрд орсон. Бүгдээрээ бас гэр бүл, үр хүүхэдтэй болоод. Тэгээд 2015 оноос хойш энэ жоохон суларсан юм байна. Тэгээд “Эхлэл хөгжлийн форум” гээд улс төрийн социал демократ үзэлтэй залуучууд цугларсан Германд төгссөн залуучууд голчлон. Бид нар улс төрийн нийгмийн чиглэлээр аягүй их сургалтууд хийдэг байсан.*

Ийм байдлаар улс төрд орох нь тухайн салбарын сонгогчдын дэмжлэг авах бөгөөд сонгогчид өөрийн аль нэг талаараа ижилсэх хүмүүсийг дэмжих магадлалтай байдаг байна. Мөн сонгуульд ялалт байгуулахын тулд нэр дэвшигч тухайн тойргийн сонгогчдын хүн амзүйн мэдээлэлд дүн шинжилгээ хийж ямар онцлогтой гэдгээс хамаарч урьдаас тухайн чиглэлээрх клуб, сонирхлын бүлгүүдийг улс төрийн зорилгоор байгуулдаг байна. Ялангуяа сонгуулийн өмнөх жил урлаг, спортын арга хэмжээ, уулзалт, чуулган зохион байгуулагдах нь их болдог. Спортын холбоонуудын тэргүүн ихэвчлэн улс төрч байдаг. Энэ нэг

талаас тухайн спортын холбоо улс төрд нөлөө бүхий хүнээр дамжуулан холбооны үйл ажиллагааг дэмжүүлэх зорилготой байдаг бол улс төрчдийн хувьд тухайн спортыг дэмжигчдийг саналыг татах зорилготой байдаг.

Орон нутагт хамгийн нөлөө бүхий холбоо бол морин спорт, уяачдын холбоо, нутгийн зөвлөл зэрэг байдаг. Жишээлбэл УИХ-дарга асан М.Энхболд уяачдын холбооны тэргүүнээр ажиллаж байсан. Уг холбооны гол давуу тал нь сум тус бүрд 10-15 гишүүн төлөөлөлтэй, мөн тухайн сумандаа уяач хүн нэр хүндтэй, санхүүгийн чадавхтай байдаг зэрэг нь олон нийтийн санаа бодолд нөлөөлөл үзүүлдэг байдаг байна. Мөн намын дэргэдэх байгууллагад зөвхөн улс төрд орохын тулд бус харилцаа холбоогоо тэлэх зорилгоор ч орох хэсэг байх бөгөөд ийм төрлийн залуучуудын томоохон байгууллага бол JCI гэх байгууллага юм. Уг байгууллага нь олон нийтэд чиглэсэн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлдэг бөгөөд гишүүнчлэлийн хувьд нэлээд хатуу дэг журамтай байдаг байна.

Цахим сүлжээ. Цахим сүлжээ иргэдийн мэдээллийн гол эх сурвалж гэдгийг олон судалгааны үр дүнгээс харах боломжтой бөгөөд сонгогчдын саналд ч шийдвэрлэх нөлөөлөл үзүүлдэг. Тийм учраас улс төрчид хийж хэрэгжүүлж буй ажил боон өөрийн хувь үзэл бодлоо хуваалцах, өөрийгөө олонд таниулах зорилгоор цахим сүлжээг идэвхтэй ашигладаг. Мөн сонгуулийн үеэр тухайн нэр дэвшигчийг дэмжих бүлэг, санаачилга ч цахим орчинд идэвхтэй өрнөдөг бөгөөд улс төрчийн хувьд биечлэн уулзаж танилцаагүй боловч цахим сүлжээгээр дамжуулан өөрийн хүрээлээ бий болгох тохиолдол байдаг.

Тухайлбал ОНМХ, нийгмийн сүлжээг ашиглах байдал нь нас болон улстөрчийн сонгогдсон улс төрийн албан тушаалаас хамаараад харилцан адилгүй байна. УИХ-н гишүүний хувьд ажлын алба нь улс төрийн коммуникацыг тогтмол хийх, бүх сувгийг ашиглах шаардлагатай байдаг. Учир нь ямар ажил хийж байгааг байнга мэдээлж, иргэд, нийгэмтэйгээ ойр ажиллаж, асуудлыг шийдэхийн төлөө уйгагүй ажиллаж байгаагаа үзүүлж байгаа явдал юм. Энэхүү байдал нь нийгэмд сайшаагдвал маш хурдан олонд танигдах, дэмжигчид ихсэх, холбоо сонирхлын бүлгүүдтэй хамтран ажиллах зэрэг танилын хүрээ нэмэгдэж байна.

Дундаас анхан шат руу шилжихэд тухайн улстөрчөөс хамааран харилцан адилгүй ашиглагдаж байна. Нийгмийн зүгээс социал орчныг нийгмийн оролцооны нэг хэлбэр гэж харах, хол байсан улстөрч, шийдвэр гаргагч нартай ойр байх үүлэн ертөнц хэмээн үзэн санал бодлоо хүчтэй илэрхийлдэг болсон. Тэхээр социал хүрээнд хэрхэн өөрийгөө илэрхийлэх гэдэг бол коммуникацын аргыг маш сайн судлах, ур чадвараа нэмэгдүүлэх бодит хэрэгцээ үүсэж гэж ойлгох хэрэгтэй.

Эдгээрээс дүгнэж үзвэл танилын хүрээгээ ямар зорилгоор ашиглаж буйгаас үл хамааран улс төрийн карьерт чухал нөлөөтэй байна. Ямар зорилго гэдгийг тодруулбал танилын хүрээгээ ашиглаж дүрэм, журмын бус байдлаар давуу байдлыг олж авах тохиолдлыг хамаатуулсан болно. Мөн танилын хүрээгээр

дамжуулан улс төрийн намд бат итгэл бүхий баг бүрдүүлэх, улмаар урт хугацаанд бие биеэ дэмжих бүлэг бий болдог. Судалгаанд оролцогч залуучууд сонгуульд нэр дэвшихэд сурталчилгааны зардал маш өндөр гардаг гэдгийг онцолсон бөгөөд хэвлэлийн зардал, ухуулагчийн зардал зэрэгт чамгүй зардал гардаг байна. Харин ийм тохиолдолд танилын хүрээ тодорхой зардлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг болох боломжтой бөгөөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, цахим орчинд дэмжиж ажиллах, хандив тусламж өгөх зэргээр нөлөөлдөг байна. Жишээ дурдвал 2020 оны УИХ-ын сонгуульд АН-аас нэр дэвшихээр горилогч Ж.Эрдэнэбүрэнгийн дэнчингийн 100 сая төгрөгийг нутгийнх нь мянгат малчид хандиваар бүрдүүлсэн байна.

2.2.7 Тууштай байдал, идэвх зүтгэл (Залуучуудын улс төрийн нам дахь оролцооны хэлбэр улс төрийн карьерт нөлөөлөх нь)

Улс төрийн намын тогтвортой үйл ажиллагаанд шинэ гишүүд, идэвхтэн, залуучуудын оролцоо чухал байдаг. Сонгуульд ялалт байгуулах, улс төрийн дэмжлэгээ өргөтгөх зэрэгт залуучуудыг татан оролцуулах нь нийгэм дэх дэмжлэгийн суурь болдог төдийгүй залуучууд нь намын дотоод үйл ажиллагааны нэг хэсэг болж байдаг. Нөгөө талаас залуучууд тодорхой улс төрийн намыг хувийн болон оршин буй хүрээлэл, нийгмийн учир шалтгааны улмаас сонгон элсдэг.

Улс төрийн намд залуучууд ямар шалтгааны улмаас элсдэг вэ гэдэгт хариулахаар өнгөрсөн хугацаанд судалгаанууд янз бүрийн хариулт өгсөн байдаг боловч Анжело Панебианкогийн намын гишүүдийн ангилал нь энэ сэдвээрх судалгааны тулгуур хэвээр байсаар байна.³⁴ Тэрээр хоёр төрлийн намын идэвхтнүүд байдаг гэсэн ба эхнийх нь нийтлэг зорилго (намын идеологи, албан ёсны зорилго) зэрэгт татагдан нэгдсэн буюу түүний нэр томъёогоор “итгэгчид” байдаг. Харин дараах бүлэг нь тодорхой сонгомол зорилго (материаллаг болон статуст чиглэсэн) зэрэгт нэгдсэн буюу “карьер хөөгчид” гэж ангилжээ.³⁵

Европын зургаан ардчилсан оронд хийсэн нэгэн судалгаанд намын залуучуудыг ямар зорилгоор тухайн намд элссэнээс нь хамаарч гурван ангилалд хувааж болно гэжээ.³⁶ Эхнийх нь (Moral Minded) намд ёс суртахууны итгэл үнэмшил, идеологиос шалтгаалан элсэж тухайн намд өөрийн итгэл үнэмшлээрээ бодлогын асуудалд нөлөөлөх, өөрчлөлт оруулах зорилготой бүлэг байдаг гэжээ. Хоёрдугаар бүлэгт (Social Minded) тодорхой намын үйл ажиллагаа, байгууллагаар дамжуулан нийгмийн шинэ хүрээлэлд орох буюу ижил төстэй санаа бодолтой хүмүүстэй уулзах, шинэ найзтай болох, улс төрийн үзэл бодлоо солилцох зэрэг ач холбогдлыг үнэлсний улмаас элссэн хүмүүс хамаардаг. Гуравдугаар бүлэгт (Professional Minded) мэргэжлийн улс төрч болох эсвэл улс төрийн үйл

³⁴ Sejin Koo “Does policy motivation drive party activism? A study of party activists in three Asian democracies” Party Politics pp.2-3.

³⁵ Ibid., p. 3.

³⁶ Michael Bruter, Sarah Harrison “Tomorrow’s Leaders? Understanding the Involvement of Young Party Members in Six European Democracies” Comparative Political Studies Vol 42 N 10, pp. 1264-1266.

ажиллагаанд оролцон ажлын байртай болох боломжийг эрэлхийлсний улмаас элссэн хүмүүс байдаг гэжээ. Энэ бүлгийн гишүүдийн хувьд улс төрийн үйл ажиллагаа нь үндсэн ажил болж, намын улс төрийн үйл ажиллагаанд бусад хоёр бүлгээс илүү идэвхтэй оролцох хандлагатай байдаг байна.³⁷

Дээрх гурван бүлгийг тайлбарласнаар буюу хувийн итгэл үнэмшил эсвэл намд элссэнээр үүсэх материаллаг болон материаллаг бус боломж, ашиг тусыг харгалзахаас гадна тухайн хүний гэр бүлийн байдал, боловсрол, гэр бүлийн хэн нэгэн гишүүн намд элссэн байсан болон намын зүгээс элсэхийг урьсан зэрэг нь намд элсэх шалтгаан болж байдаг.³⁸

Товчоор бол хувь хүн аливаа намд элсэх төрөл бүрийн шалтгаан байж болох бөгөөд намд элссэнээр олж болох боломж, ашиг тус болон хувь хүний нөөц боломж, итгэл үнэмшил зэргээс элсэх эсэх нь хамаардаг байна.

Монголын улс төрийн голлох намууд буюу энэ судалгаанд авч үзсэн МАН, АН, МАХН, ХҮН зэрэг намууд нь үүсэл, идеологи, бүтэц, үйл ажиллагааны цар хүрээний хувьд ихээхэн ялгаатай ба өмнө бүлэгт дурдсанчлан ХҮН, МАХН зэрэг намуудын залуучуудын байгууллагууд МАН, АН-ын залуучуудын байгууллагуудтай харьцуулахад хязгаарлагдмал, цөөн бүлэг хүмүүсийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Ялангуяа МАН нь социализмын үеийн нэг намын дэглэмээс өвлөгдөж ирсэн институтийн бүтэц, нөөцийн улмаас бусад намуудтай харьцуулахад өргөн цар хүрээнд үр дүнтэй ажиллах чадвартай залуучуудын байгууллагыг байгуулах боломжтой байв.

Намын хэмжээ, бүтцээс гадна тухайн нам төр засагт ямар хэмжээнд төлөөлөлтэй, Засгийн газар байгуулах эрхтэй эсэх нь залуучуудын нам дахь улс төрийн оролцоонд мөн нөлөөлдөг. Хэрвээ аль нэг нам хууль тогтоох байгууллагад цөөн төлөөлөлтэй мөн жижиг хэмжээтэй тохиолдолд намын дотоод үйл ажиллагаа нь бодлого боловсруулах, өөрчлөх чиглэлд төвлөрдөг.³⁹ Харин улс төрийн нам нь төрийн албаны томилгоонд нөлөөлөх боломжтой буюу хууль тогтоох байгууллагад олон суудалтай мөн засгийн эрхийг барьж буй бол “карьер хөөгчид” улс төрийн систем, намд олон байх хандлагатай байдаг байна.⁴⁰

МАН нь 1996-2000 оныг эс тооцвол 1992 оны шинэ ардчилсан үндсэн хуультай болсноос хойших бүх ээлжит бүрэн эрхт парламентын хугацаанд УИХ-д суудлаа тогтвортой хадгалж, Засгийн газрыг дангаараа эсвэл эвсэл байгуулах замаар удирдаж байв. Өөрөөр хэлбэл энэ нь МАН-д УИХ болон Засгийн газарт нөлөөгөө тогтвортой хадгалах боломж олгож байсан юм. Цаашлаад энэ нөхцөл

³⁷ Ibid., p. 1266.

³⁸ Regina Weber “Why do young people join parties? The influence of individual resources on motivation” Party Politics, 2020 pp. 500-501.

³⁹ Sejin Koo “Does policy motivation drive party activism? A study of party activists in three Asian democracies” Party Politics p. 12.

⁴⁰ Michael Bruter, Sarah Harrison “Tomorrow’s Leaders? Understanding the Involvement of Young Party Members in Six European Democracies” Comparative Political Studies Vol 42 N 10, p. 1272.

байдал нь МАН-ын гишүүд, залуучуудад төрийн албанд ажиллах боломж олгосон буюу МАН-д гишүүн байх нь төрийн албанд орох, шат ахих давуу тал болдог байна. БЗД-ын ИТХ-д 2020 онд сонгогдсон нэгэн төлөөлөгч яагаад намд элсэх болсон шалтгаанаа тайлбарлахдаа:

“Аль нэг намд элсэж байж дээшээ ахих боломжтой. Нам нь угаасаа системтэй байна шүү дээ. Доор байгаа хүмүүс намын гишүүнчлэлтэй байж дээш татдаг эсвэл нэг танил ахтай хүн. Тэр утгаараа карьер хөөгөөд цаашаа явъя гэвэл намд элсэх ёстой юм байна гэж элссэн.”

Гэхдээ дээр дурдсанчлан зөвхөн намд элссэн байх нь улс төрийн карьерыг бүрэн тодорхойлохгүй бөгөөд намын ямар байгууллагад харьяалагдаж, ямар үйл ажиллагаанд хэрхэн оролцож буй гэдгээс хамаарч тухайн хувь хүний улс төрийн карьерт тодорхойлогдох тохиолдлууд энэ судалгаагаар ажиглагдсан.

Намын харьяа байгууллагад олон жил тууштай ажиллах буюу намын анхан шатны нэгжээс эхлэн албан тушаал дэвших боломжтой байдаг нь МАН-д кейс дээр ажиглагдсан. Тодруулбал 2020 оны орон нутгийн сонгуулиар Налайх дүүргийн ИТХ-д сонгогдсон нэгэн төлөөлөгч 2011 оноос 2020 он хүртэлх хугацаанд МАН-ын Налайх дүүрэг салбар Оюутны холбоог (НАМОХ) байгуулахаас эхлээд дүүргийн үүрийн хорооны дарга, НАМОХ-ны Хяналтын хорооны дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга цаашлаад тус дүүргийн НАМЗХ-ны ерөнхийлөгчөөр сонгогдож байжээ.

☉ 2.2.8 Ур чадвар

Өнөөгийн нийгэм хувь хүнээс олон төрлийн ур чадвар шаардах болсон. Академик мэдлэг, боловсролоос гадна хувийн ур чадварууд (soft skill) нь тухайн хүний нийгэмд үнэлэгдэх, амжилттай байхад чухал нөлөөтэй байна. Улс төрчдийн хувьд олон нийтийн дэмжлэгийг авах, нийгэмд танигдах, өөрийн хэв маягийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй хувь хүний ур чадваруудыг нь нийтлэг байдлаар авч үзвэл:

Харилцааны чадварууд Илтгэх, олон нийтийн өмнө цэгцтэй ярих чадвар нь орчин үеийн нийгэм гэлтгүй иргэншлийн бүхий л цаг хугацаанд улс төрчид, нийгмийн зүтгэлтнүүдийн хамгийн чухал ур чадвар байсаар ирсэн. Улс төрчийн хувьд илтгэх, өөрийгөө илэрхийлэх ур чадвар нь нэг талаасаа олонд танигдах давуу тал болохын зэрэгцээ хувь хүний хувьд өөртөө итгэх итгэлтэй байж улс төрийн үйл ажиллагаагаа явуулахад нь дэмжлэг болж байна. Уг ур чадвар нь тухайн хувь хүний төрөлх харизм буюу зан чанарт тулгуурлан өөрийн хэв маягаар бүрэлддэг заяагдмал бус чанар юм. Улс төрчийн карьерын эхэн үед харилцааны чадварууд нь эрч хүчтэй, өөртөө итгэлтэй байдлаар улс төрд тодорхой хэмжээнд танигдахад нь дэмжлэг болно. Нийт улс төрчийн замналын туршид илтгэх, мэтгэлцэх, бусдад нөлөөлөх харилцааны чадварууд чухал үр нөлөөгөө хадгалсаар байх бөгөөд эдгээр чадварууд дээр нэмэгдэн амжилттай хэлэлцээр хийх, биеэ зөв зохистой авч явах зэрэг зэрэг чадварууд улс төрчийн төлөвшил, харагдах үзэмжийг тодорхойлох чухал нөлөөтэй байна. Улс төрчдийн

хувьд олон нийтийн өмнө өөрийн үзэл баримтлалаа тодорхой илэрхийлэх нь нийгэмд, сонгогчдын дунд итгэл үнэмшил төрүүлэх, тэдний саналыг авах тулгуур хүчин зүйлсийн нэг болдог

Хэлэлцээр хийх, ятган үнэмшүүлэх чадвар Улс төрчдийн дунд хэлэлцээр хийх ятган үнэмшүүлэх ур чадвар нь өөрийн хүсэл зоригийг гүйцэлдүүлэх, бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд голлох зэвсэг нь болох учиртай. Хэлэлцээрт амжилт муутай оролцдог, өөрийгөө болон санаа бодлоо улс төрийн хүрээнд хангалттай илэрхийлдэггүй улс төрчид сөрөг дайралт, элдэв гүтгэлэгт хялбар өртөх, эрх ашгаараа хохирох, хэлсэн санаагаа буруугаар ойлгуулах зэрэг сул талтай байна. Түүнчлэн улс төрчийн нэр хүнд үргэлжид олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн анхааралд байдаг эмзэг шинж чанартай юм. Энэ нэр хүндээ хэрхэн цаашид авч явах, олон нийтэд өөрийнхөө талаарх ойлголтыг зөвөөр өгөх, эергээр чиглүүлж чадах эсэх нь улс төрчийн хэлэлцээр хийх, ятган үнэмшүүлэх ур чадвараас хамаарна.

Биеэ зөв авч явах соёл Хэвлэл мэдээлэл болон дижитал технологийн хөгжлийн нөлөөгөөр улс төрчдийн олон нийтийн болон цахим орчинд биеэ зөв авч явах чадамжтай эсэхийг иргэд алхам тутамдаа хянах боломж бүрдсэн. Тиймээс улс төрчөөс бас нэгэн шаардагдах хувь хүний ур чадвар нь биеэ зөв авч явах соёл юм. Манай улс төрийн өнгөрсөн үеийг сөхөх юм бол олон нийтийн газар архи согтууруулах ундаа хэрэглэсэн байдалтай үзэгдсэн, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ цахим сүлжээнд шууд бичлэг хийсэн, хэн нэгэн доод тушаалын хүнийг ёс бусаар загнаж зандарсан зэргээс эхлүүлээд бусдад бэлгийн дарамт үзүүлсэн, хүний амь нас, албан тушаалын хэрэгт нэр холбогдсон зэрэг улс төрчдийн ёс зүйгүй үйлдлүүдийг харж болно.

Дашрамд дурдахад улс төрчдөд шаардагдах хувь хүний ур чадварыг уг судалгаагаар тодорхойлохыг зориогүй бөгөөд хувь хүний эдгээр ур чадварууд нь судалгааны хүрээнд тодорхойлсон хувь хүний бусад 7 хүчин зүйлийг өөрийн нөөцөөр нөхөх боломжийг олгодгоороо ихээхэн чухал.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Хувь хүнээс шаардагдах улс төрийн нөөц дундаас хамгийн нөлөө бүхий нь хөрөнгө санхүүгийн нөөц бололцоо байна. Учир нь улс төрийн аливаа үйл ажиллагаа нь өндөр өртөгтэй, санхүүгийн чадамжийг тогтмол шаарддаг. Хөрөнгө санхүүгийн шаардлага нь улс төрийн үйл ажиллагаанд голлох нөлөөтэй тул санхүүгийн эмзэг байдал нь тухайн улс төрчийн карьерыг хязгаарлах түүнчлэн бие даасан байдалд нь сөргөөр нөлөөлж байна.

2. Сонгуулийн зардлыг бууруулах, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх замаар улс төрийн өртгийг бууруулах нь санхүүгийн хэт хамаарлаас гарах боломжит гарц юм.

3. Улс төрчдийн үйл ажиллагааны цар хүрээ нь голчлон төлөөлж буй тойргоороо хязгаарлагдаж байна. Тухайлбал аймгийн ИТХ-д нэр дэвших, нийслэлд дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшиж байгаа улс төрчдийн хувьд өрх болон сонгогчдын тоо, газар нутаг, дэд бүтэц зэргээрээ ихээхэн ялгаатай.

4. Сонгогчдод танигдсан байх нь сонгуулийн өрсөлдөөнд санхүүгийн нөөцтэй дүйцэхүйц чухал нөлөө үзүүлдэг. Учир нь сонгуулийн зардлын дийлэнх нь нэр дэвшигч сонгогчдод өөрийгөө таниулж, сурталчлахад зарцуулагддаг байна. Улс төрчдийн хувьд ажил мэргэжлээрээ олон түмэнд танигдах, улс төрчийн дүр төрх буюу имиж бүрдүүлэлтээрээ танигдах, хичээл зүтгэлээрээ танигдах зэрэг нь түгээмэл байна. Иргэдтэй илүү ойр ажиллах тэдний аж ахуй асуудлуудыг амжилттай шийдвэрлэж, тухайн албан тушаалдаа сайн ажиллах нь өнөөгийн нөхцөлд улс төрчийн карьерт эерэг нөлөөтэй гэж судалгаанд оролцогчид үзсэн.

5. Улс төрийн нам доторх өрсөлдөөнд боловсрол нь мөнгө санхүү болон эрх мэдэл, танил тал зэрэг үзүүлэлтийг хараахан давж чадахгүй байна. Гэсэн хэдий ч залуу болон эмэгтэй улс төрчдийн хувьд өндөр боловсрол эзэмшсэнээр хөрөнгө санхүү, сүлжээ зэрэг суурь нөөцүүдийн тэгш бус байдлыг нөхөх боломжтой байна. Өөрөөр хэлбэр нөөцийн тэгш бус байдлыг бууруулахад боловсрол чухал нөлөөтэй.

6. Залуу болон эмэгтэй улс төрчдийн хувьд гэр бүл зохиосон эсэх, гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн нэр хүнд зэрэг нь улс төрийн замналд нь чухал нөлөөтэй. Тэр дундаа орон нутгийн сонгогчдын хувьд нэр дэвшигчийн нас, хүйсээс үл хамааран нутаг ус, уг гарвалийг чухалчилж байна. Тухайн улс төрчийн эцэг эхийн нэр хүнд, түүх нь сонгуулийн үед чухал нөлөөтэй байдаг.

7. Олон нийтээс улс төрчдийн гэр бүлд тавих шалгуур хүйсийн хувьд харилцан адилгүй байна. Гэр бүл цуцлуулсан, гэр бүлийн хүн нь гадаадын иргэн байх зэрэг ижилхэн нөхцөлд эмэгтэй улс төрчдөд эрэгтэйчүүдээс илүү хатуу шалгуур тавьж, ялгавартай ханддаг гэжээ.

Улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулснаар ар гэртээ зарцуулах цаг багасдаг нь аль ч хүйсийн улс төрчид тулгамддаг хэдий ч эмэгтэйчүүдийн хувьд энэ нь илүү хүндээр тусдаг. Хэрэв асуудалд шийдэл олоогүй тохиолдолд гэр бүл төлөвлөлт хойшлох, улс төрийн карьер эсвэл гэр бүлийн аль нэгийг сонгох шаардлагатай болох нь түгээмэл.

8. Улс төр нь сонгууль, олон нийтийн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй өргөн хүрээтэй. Үүнд тухайн улс төрчийн хүрээлэл, сүлжээ нь чухал нөөцөд орно. Улс төрчдийн танилын хүрээ, үүсгэсэн сүлжээ нь нутаг усны холбоо, нэг үеийнхэн, төгсөлтийнхөн, намын бүтэц, цахим сүлжээ, эдгээрийг хэлбэржүүлсэн төрөл бүрийн холбоо, клуб, ТББ гэсэн үндсэн хэлбэрүүдтэй байна. Эдгээр нь урлаг соёл, спорт, нийгмийн алдартнуудаас эхлээд мэргэжилтэн, жирийн иргэн хүртэл нийгмийн бүхий л давхарга хүрээг хамарч байна.

9. Залуу болон эмэгтэй улс төрч амжилт үзүүлэхэд хувь хүний хүчин зүйлийн хувьд дараах нөөцүүд голлох нөлөөтэй байна. Үүнд:

- Хөрөнгө, Санхүү
- Боловсрол
- Гэр Бүлийн Байдал
- Туршлага
- Танил Тал, Сүлжээ
- Олон Нийтэд Танигдсан Байдал
- Тууштай Байдал
- Ур Чадвар

3.1 Өнөөгийн улс төрийн амьдрал дахь залуучууд болон эмэгтэйчүүдийн оролцооны нийгмийн суурь хүчин зүйлс

Энэ бүлэгт улс төрийн оролцооны хүрээнд жендерийн болон нийгмийн үе хоорондын харилцааны нөхцөл байдлын талаар эргэцүүлэх болно. Үүний тулд өнөөгийн нийгэм, соёлын суурь нөхцөл байдал, тэдгээрт хамаарах хүчин зүйлсийг авч үзэх зайлшгүй шаардлага гарч байна.

Ноёлох соёл ба үнэт зүйлсийн өөрчлөлт.

Монголын нийгэм уламжлал, шинэчлэлийн харилцан үйлчлэлийн дунд явж ирсэн буюу нүүдэлчдийн уламжлалт хүй элгэний ёсон, буддизм, шаманизм, социалист хамтач ёсны үзэл ба аж төрөх ёс, шашингүйн үзэл, ардчиллын үеийн эрх, эрх чөлөөний үнэт зүйлс, олон ургалч байдал, чөлөөт зах зээлийн хувьч үзэл ба амьдрах арга барил зэрэг нь нэг талаас, өөр хоорондоо зөрчилдөж, нөгөө талаас, нөхөн гүйцээж зохиролдож явсаар өнөөгийн үнэт зүйлсийн тогтолцоог бүтээсэн нь дамжиггүй. Монголчуудын уламжлалт соёлд нийгмийн үе хоорондын болон жендерийн харилцаанд консерватив хэв маягийн үнэт зүйлс, зарчмууд давамгайлж ирсэн нь тодорхой юм. Уламжлалт ноёлох соёл нь нийгмийн үеүд хоорондын харилцаанд ерөнхийдөө ахмад настныгаа хүндлэн дээдлэх, бага балчрыг сурган тэтгэх хэв шинжийн зан үйлийг хэлбэржүүлдэг бөгөөд энэ суурь зарчим нь цаашид залуу үеийг ахмад үед захируулан орхиж, ахмад үеийн байр суурь, үүрэг, туршлагыг илүү чухалчилж, хүч, эрх мэдлийн бүтцэд ахмад үеийг илүү өргөмжилсөн байна. Харин жендерийн хувьд эцгийн эрхт ёс, эрэгтэйчүүд давамгайлсан нийгмийн бүтэц, харилцааг бэхжүүлж ирсэн гэж хэлж болно.

Уламжлалт ноёлох соёлын тогтолцоон дахь ийм үнэт зүйлс, зарчмуудыг наад зах нь соёлын чухал бүрэлдвэр болсон ардын билиг сургаал, зүйр үгсийн сангаас харж болох юм. “Ахмадыг алд хүндэл, дүүг дэлэм хүндэл”, “Тарчиг залуугаас тартай хөгшин дээр”, “Амны салиа арилаагүй байхад, ахтайгаа тэмцээд ахицыг олохгүй”, “Ах нь сургадаг, дүү нь сонсдог”, “Аялах ахын зан, дүүхэлзэх дүүгийн зан”, “Ахмадад өргөмж, залууд сургамж” зэргээр зүйр үгс нь соёлын утга санаа, бэлэг тэмдгийн зүйлийг агуулж, нийгмийн харилцаанд нөлөөлсөөр ирсэн нь бий. Жендерийн харилцааны хүрээнд нэгэн адил энэ мэт соёлын баримт сэлтийг олж харж болно. Өөрөөр хэлбэл дээрх соёлын бүрэлдвэрт жендерийн уламжлалт дэг ёсыг тунхагласан агуулгыг олноор олж харж болох бөгөөд тэр бүхнийг эс тоочин, энд яригдаж буй улс төрийн оролцоотой шууд холбогдох зүйр үгийг энд дурдаж байна. “Тэмээн толгой тэвшинд багтдаггүй, Тэнтгэр хатан зарга шүүдэггүй,

Ямаан толгой ямбанд багтдаггүй, Янтгар хатан зарга шүүдэггүй” гэсэн зүйр үг нь эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцоог үгүйсгэсэн уламжлалд суурилсан хэвшмэл ойлголтыг илэрхийлж байгаа юм.

Гэвч, нийгмийн соёлын ноёлох үнэт зүйлс нь хэзээ ч хувиршгүй зүйл биш, хөгжлийн явцад өөрчлөгдөж байдаг юм. Үнэн хэрэгтээ, өмнөх тогтолцоо буюу социалист нийгмийн үед нийгмийн үеүдийн болон жендерийн уламжлалт хийгээд ноёлох соёлын тогтолцоо нэг их хөндөгдөж өөрчлөгдөлгүй, зарим талаар баяжиж, бэхжиж ирсэн байна. Учир юу гэвэл тэдгээр нь коммунист үзэл суртал, социалист аж төрөх ёсны суурь зарчмуудтай илтэд зөрчилдөж байгаагүйтэй холбоотой. Харин ардчиллын үеийн хүний эрх, эрх чөлөөний үнэт зүйлүүд нь уламжлалт ноёлох соёл, түүний зарчмуудтай зөрчилдөж, сорилт, өөрчлөлтөд дуудсаар ирлээ. Товчхондоо, сүүлийн гуч гаруй жилийн хугацаанд уламжлалт ноёлох соёлын тогтолцоо ба ардчиллын үеийн соёлын тогтолцооны зөрчил дунд амьдарч ирсэн байна.

Өнөөдөр ардчиллын үеийн соёлын тогтолцоо, үнэт зүйлс аажим аажмаар байр сууриа олж авсаар байгаа ба ардчилал залуучуудын оролцоогүйгээр, жендерийн тэгш байдлыг хангахгүйгээр хөгжихгүй, бэхжихгүй, ардчилалд залуучуудын болон эмэгтэйчүүдийн оролцоо амин чухал зүйл гэдгийг хүлээн зөвшөөрч байна. *Гэсэн хэдий ч, нийгмийн үеүдийн болон жендерийн харилцааны уламжлалт ноёлох соёл өнөө хэр нь манай нийгэмд нөлөөллөө хадгалсаар байгаа бөгөөд хүч, эрх мэдлийн бүтэц, баялгийн хуваарилалтын институтүүдэд, олон нийтийн санал бодолд биежсэн хэвээр байгаа юм. Тиймээс, улс төрийн шийдвэр гаргах түвшинд залуучууд болон эмэгтэйчүүдийн төлөөлөл, тэдний нийгэмд үзүүлэх нөлөө хангалтгүй байхад хүргэж байна. Тэдний улс төрийн сонгуульд нэр дэвших боломжийг хязгаарлаж буй дэг ёс, хэвшмэл ойлголт, хэм хэмжээ, хандлага зэрэг соёлын хүчин зүйлүүд оршоор байна.*

Шигтгээ 3.1.1 Уламжлалт үнэт зүйлс ба өөрчлөлт

Нөхцөл байдал өөрчлөгдөж байна. Залуучууд олноороо улс төрд орж ирэх болж, эмэгтэйчүүд удирдах албан тушаалд томилогдож байна, улс төрийн талаарх хэвшсэн ойлголтууд өөрчлөгдөж байна. Гэвч, уламжлалт эцгийн эрхт ёс гэдэг чинь хэдэн зуун мянган жил яваад ирсэн цусны кодонд орчихсон зүйл юм. Тэр дороо ала болно гэж байхгүй. Одоо ч, улс төрийн амьдралд байсаар байна. Нөгөө биеэ засаад, гэрээ зас, дараа нь төр засгийг гэсэн их хааны сургаал явж л байна. Эмэгтэй хүн төрийн үйл хэрэгт манлайлах гэдгийг дундаж сэтгэхүүд шууд хүлээж авахгүй л байна. Улс төр, намын амьдралд карьер хөөгөөд хутгалдаад ирэхээр олон зүйл дээр уламжлалт үзэл, хэвшмэл ойлголтууд байсаар байгааг харж болно. (Ярилцлагад оролцогч, эмэгтэй, 50 настай)

Засаглал ба ардчиллын хөгжил.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улс ардчиллыг бэхжүүлэх чиглэлээр ахиц дэвшил гаргаж ирсэн ч, өдгөө ардчилсан институтууд нь авлига, тэгш бус байдал, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зэрэг томоохон хийгээд тулгамдсан сорилтуудтай хэвээр байна. Ирэх жилүүдэд улс төрийн институтууд нь иргэдийн сайн сайхан байдал, амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд улс төрийн институтуудад шинэчлэл хийж чадах эсэх, уул уурхайн баялгийг зохистой ашиглах, баялгийн хараал, Голланд өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлж, зохицуулж чадах эсэх нь Монголын ардчиллын хувь заяаны асуудлууд байх болно. Сүүлийн арван жилд Монгол улс ардчиллын хөгжлийн үзүүлэлтээр дорвитой урагшилж чадаагүй нь дэлхийн улс орнуудын ардчиллын индексээр 2010 онд 167 улсаас 64, 2014 онд 61-т, байсан бол 2020 онд 61-т эрэмбэлэгдсэн хэвээр өө сэвтэй ардчилал бүхий орнуудын ангилалд байгаагаас харж болно. Дээд үнэлгээ 10 оноо бүхий 5 шалгуур бүхий үзүүлэлтээс манай улсын хувьд улс төрийн оролцоо (5.56), улс төрийн соёл (5.63) гэх хоёр шалгуур нь бусад шалгуураас хамгийн бага байна. Мэдээж ардчиллын хөгжил бол тасралтгүй үйл явц учраас урт удаан хугацаа шаардана. Гэвч ардчилсан институтүүдийн байнгын идэвхтэй оролцоо, хяналтгүйгээр ардчиллын хөгжил зогсонги байдалд орно.

Ардчилал бол төрийн тогтолцооны байж болох хувилбаруудаас хамгийн зохистой хэлбэр гэдгийг иргэд өргөнөөр ойлгодог, ийм итгэл үнэмшилтэй байх нь ардчилсан тогтолцоог бэхжүүлэхэд чухал шаардлагатай. Аливаа улсын ардчиллын ирээдүй нь залуу үеийнхэн төр засгийн ардчилсан хэлбэрийг тууштай дэмжиж байгаа эсэхээс ихээхэн хамаарна. Энэ нь иргэд ардчиллын талаар нийтлэг ойлголттой байна гэсэн үзэл санаан дээр тулгуурладаг. Монголын залуучуудын санал бодлын судалгааны зарим үр дүнгээс харахад олонх нь манай улсын хувьд ардчилал засаглалын хамгийн сайн хувилбар, гэхдээ засаж сайжруулах хэрэгтэй гэж үздэгийн дээр өнөөгийн улс төрийн засаглалын шинж чанарыг хагас дутуу ардчилсан хэмээн тодорхойлдог байна. Түүнчлэн аливаа улсад ардчилсан засаглалыг төлөвшүүлэхэд улс төрийн шийдвэр гаргах түвшинд залуучуудын болон эмэгтэйчүүдийн оролцоог хангах шаардлагатай хэмээн үзсэн байна. Улс төрд залуучууд болон эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь ардчиллын хувь заяанд холбогдох чухал асуудал мөн. Учир нь ардчилал улс төрийн эрх, эрх чөлөө хаана хангагдаж байна тэнд мөн чанараар орших боломжтой. Өнөөдөр залуучуудын улс төрийн оролцооны нийтлэг бөгөөд үндсэн хэлбэр нь сонгууль болж байна. Залуус сонгуулийг ардчиллын чухал үнэт зүйл, улс төрийн оролцооны үндсэн хэлбэр, өөрсдийн дуу хоолойг төрд хүргэх боломж хэмээн үздэг. Сонгуулийн оролцоо мэдээж чухал гэвч, ардчилалд сонгуулийн оролцооноос гадна улс төрийн шийдвэр гаргах түвшинд дээрх хоёр бүлгийн хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх нь асар чухал юм. Улс төр жирийн иргэдэд

улам бүр хаалттай зүйл болж хувирах бүрийдээ эрх мэдлийн элитийн давхарга (power elite) олон түмнээс тасран нарийсах төлөвт ордог. Ингэх тусам, хүн амын хамгийн чинээлэг өчүүхэн хэсэг болон улс төрийн элитүүдийн хэлхээ улам бүр нягтрах, улс төрийн өв залгамж ихээхэн нийтлэг зүйл болж ирэх учиртай. Олон түмэн улс төрийн үйл хэрэгт оролцох боломж нээлттэй хэвээр үлдэх ч, үнэн хэрэгтээ нийгмийн хамгийн чухал шийдвэрүүдийг гаргахад тэдний бодит нөлөө хумигдах эрсдэлтэй.

Институтийн чадавх сул байгаа нь залуучууд, эмэгтэйчүүдийн зүгээс улс төрийн нам, улс төрийн сонгууль, засгийн газрын байгууллагуудад итгэх итгэл итгэл доогуур байхад нөлөөлж байна. Угтаа тэдний ийнхүү итгэл доогуур байгаа байдал нь улс төрийн оролцоог, ялангуяа шийдвэр гаргах түвшний оролцоог өдөөх хүчин зүйл болно гэж таамаглаж болох ч, бодит байдал дээр тийм биш байгаа юм. Энэ нөхцөл байдал юунаас болж байна вэ? Монгол улсад улс төрийн оролцоог хангах ардчиллын институтүүд хангалттай хөгжиж, төлөвшиж чадахгүй байгаа юм. *Монголын ардчилал сул талтай байна, тэр дундаа улс төрийн оролцоо хамгийн сул тал нь болж байна. Үүнд улс төрийн шийдвэр гаргах түвшинд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоо дутмаг байгаа нь нөлөөлж байгаа юм. Залуучууд, эмэгтэйчүүд сонгуульд нэр дэвшихэд учирч буй институтийн саад бэрхшээлүүд нь юуны өмнө, улс төрийн намын, цаашилбал сонгуулийн болон төрийн албаны тогтолцоонд агуулагдаж байгааг тэмдэглэх хэрэгтэй.*

Шигтгээ 3.1.2 Улс төрийн нам ба шинэчлэл

Миний бодлоор улс төрийн намын манлайлал жендерийн тэгш байдлыг хангахад аймаар дутагдаж байна. Иргэний нийгмийн болон олон улсын байгууллагууд нь сайн ажиллаж байгаа. Энэ чиглэлд ганцхан ажиллаж чадахгүй институ бол улс төрийн нам байна. Намын дэргэд залуу улс төрчдийг бэлтгэдэг хөтөлбөрүүд бас дутагдаж байна. Эмэгтэйчүүдийг бэлддэг хөтөлбөр мөн дутагдалтай. Эдгээр нь хэвшмэл ойлголтуудыг эвдэж шинэчлэлд бэлдэх хэрэгтэй. Эндээс салахын тулд улс төрийн намууд соргогоор мэдрээд, удирдлагууд нь аягүй зоригтой л алхам хийх хэрэгтэй. (Ярилцлагад оролцогч, эмэгтэй, 34 настай)

Улс төрийн намууд шинэчлэгдэхгүй байна. Залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог хангах чиглэлээр бүр бүтцийн өөрчлөлтүүд хийгдэхгүй бол нам доторх хуучинсаг зүйлс хадгалагдсаар л байна. Залуучуудыг улс төрийн соёл, ёс зүй, боловсролд системтэй бэлтгэх хөтөлбөр байхгүй байна. Улс төрийн төдийгүй төрийн байгууллагын томилгоог хуучин арга барилаараа л хийж байна. Хаана очно дандаа л улс төрд хуучин байсан эрэгтэйчүүд томилогддог. (Ярилцлагад оролцогч, эрэгтэй, 30 настай)

Нийгмийн тэгш бус байдал ба ялгарал.

Ардчиллын онолч Роберт Даль эдийн засгийн хүрээ ардчилагдах тусам улс төрийн ардчиллын бодит суурь тавигдах талаар үзэл санаа дэвшүүлсэн байдаг. Өдгөө судлаачид 1) Ардчилал, зах зээлийн даяаршлын эрин дэх нийгмийн баялаг, орлогын хуваарилалтын асуудал, ерөөс дэлхий дахины капитализмын хөгжлийн чиг хандлага тэгш бус байдлыг бүтээж буй тухай, 2) Ардчилсан засаглалын хөгжилд тулгарч буй сорилтууд, тэр дундаа ардчиллын чанар ба тогтвортой байдалд нийгмийн тэгш бус байдлын үзүүлэх нөлөөллийн тухай, 3) Ардчилсан засаглалын үе дэх нийгмийн тэгш бус байдлыг бууруулах чадавхын тухай асуудлууд нь XXI зуунд илүү чухал байр суурь эзлэх талаар тэмдэглэжээ. Монгол улсын хувьд нь ардчиллын институтын чиг үүргийг хүчтэй шүүмжлэх үндэслэлүүдийн нэг бол нийгмийн тэгш бус байдал, ядуурлын түвшин буурахгүй явж ирсэнд оршино. Монголын ардчиллын тэгш бус байдал, ядуурлыг бууруулах чадамж нь авлига, хээл хахуулийн тогтолцоотой ихээхэн холбогдож ирэх нь дамжиггүй. Улс төрийн ардчилал эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулах чадамж сул байгаагийн нэг тод илрэл бол ядуурлын түвшин тууштай хадгалагдаж ирсэн явдал мөн.

Ардчилал бол нийгмийн давхраажлын нээлттэй тогтолцоог дэмжиж, түүний хөрс суурь болж байдаг юм. Энэ тогтолцооны үед хүмүүс хувьд нийгмийн байр суурь өгсөх, уруудах хөдөлгөөнд орших ба бусад тогтолцоонуудтай харьцуулахад нийгмийн хөдлөнгө чанар (social mobility) илүү их байна гэсэн үг юм. Нийгмийн баялгийн тэгш бус хуваарилалт нь тэгш бус амьдралын нөхцөлийг ч, тэгш бус боломжийг ч бүтээдэг. Энэ хоёрыг шууд адилтгаж болохгүй хоёул тэгш бус хуваарилалтын үр дүн ч гэсэн, тэгш боломжийг бүтээх нь ардчилсан тогтолцооны үеийн нээлттэй нийгмийн мөн чанарт илүү нийцнэ. Нийгмийн тэгш бус байдал нь улс төрийн оролцооны ялгаатай байдалд хөтөлж байгаа нь дамжиггүй. Нийгэм эдийн засгийн статус доогуур байдал нь залуучууд, эмэгтэйчүүдийн улс төрд оролцох боломжийг хязгаарлаж, ялангуяа, шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоо нь үл гүйцэлдэх зүйл гэсэн итгэл үнэмшлийг бий болгожээ. Өнөөгийн Монголын нийгэм дэх нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал нь жендерийн болон үе хоорондын тэгш бус байдлыг өөртөө агуулдаг. Энэ нь гэр бүл, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, боловсрол гээд нийгмийн амьдралын бусад талбарын нэгэн адил улс төрийн талбарт ч ихээхэн нөлөөтэй. Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал нь нэг талаас, улс төрийн амьдралд чинээлэг, статус өндөр эрчүүдийн өмнө эмэгтэйчүүд, нөгөө талаас, чинээлэг, статус өндөр ахмадууд, дунд үеийнхний өмнө залуучууд гэсэн тэгш бус нөхцөл байдал, гарааны шударга бус зурхайг үүсгэж байна. Ламаонуир “түүхэнд улс орнуудын нийгмийн тэгш бус байдал нь ардчиллыг сулруулах утгаар өөр хоорондоо адилхан үр нөлөөтэй байгаагүй гэдэг дээр олон судлаачид санал нэгдэж болно, гэвч, энэ нь өнөө хэр нь ардчиллын хувьд маш чухал асуудал хэвээр байна” гэжээ.

Шигтгээ 3.1.3 Бэл бэнчин ба улс төр

Мөнгө, эрх мэдэл байхгүй болохоор хэцүү, улс төрд тийм хүмүүс л ордог гэсэн ойлголт жишиг болсон. Улс төрд ороход мөнгө санхүүгийн байдал шийдвэрлэх нөлөөтэй болохоор олон хүмүүс боломжгүй болж байна. Эсвэл мөнгө санхүүтэй хүний хамааралд орно гэсэн үг. Залуучуудын хувьд өөрийгөө болон гэр бүлийн санхүүгээ шийдвэрлэсэн байх гэдэг өндөр босго байх учир тэд улс төрийг амьдралаа өөд татах арга зам гэж хардаг. Тиймээс эдийн засгийн хувьд намын удирдлагаас, хэн нэгэн ахмад улс төрчийн өмнө үзэл бодол, зарчим, үнэт зүйлээ орхин хараат байдал үүсэж байна. Эмэгтэйчүүдийн хувьд ар гэрийн дэмжлэг, санхүү ихээхэн чухал юм шиг байдаг. Хэрэв үгүй бол мөн л залуучуудын нэгэн адил нөхцөл байдал үүсэж байдаг нь харагддаг. (Ярилцлагад оролцогч, эмэгтэй, 38 настай)

Чөлөөт зах зээлийн хөгжил.

Чөлөөт зах зээлийн хөгжил нь нэг талаас, улс төрөөс гадуур ажил амьдралаа авч явах боломжийг бүрдүүлнэ, нөгөө талаас, улс төрд жам ёсны шаардлагаар оролцон, иргэний хувьд шаардлага тавих боломж бүрдэнэ. Монгол улс чөлөөт зах зээлийн хөгжил хангалттай түвшинд явагдахгүй, бизнест ирэх төрийн байгууллагын дарамт, шахалттай, бизнес эхлүүлэх, төлөвшүүлэхэд төсвийн оролцоо (бараа үйлчилгээ худалдан авах, зээлд хамрагдах, дэмжлэг авах) ихтэй байгаа нь хүмүүс “улс төрөөр оролдохгүй бол улс төр чамаар оролдоно” гэдэг утгыг өөрийн орны онцлогтойгоор ойлгох болсон юм. Энэ нь улс төр бол нийгмийн баялаг хуваарилах, түүнээс үр шим хүртэх маш чухал, үндсэн эх булаг гэсэн утга санаатай бөгөөд улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх бус, хувийн ашиг хонжоо, үр шимийг гүйцэлдүүлэх зорилгод ашиглах болжээ. Чөлөөт зах зээлийн хөгжилд бус улс төрийн хуваарилалтад илүү найдах болсон нийгэмд улс төрийн рент хайгч бүлэг нийгмийн давхарга болтлоо бойжиж, залуучууд эдийн засгийн ашиг сонирхол бүхий улс төрийн бүлгүүдийн замналыг улс төрийн оролцооны гол жим болгоход хүргэж байна.

Шигтгээ 3.1.4 Чөлөөт зах зээл ба улс төр

Улс төрд орох юм бол том дарга болчих юм байна. Эрх мэдэлтэй болчих юм бол бизнесээ явуулна, улс төр чинь хувийн бизнест хүртэл нөлөөлдөг болчихлоо шүү дээ. Чөлөөт зах зээлийн зүй тогтол нь хөгжсөөд том хувийн компаниуд нь төлөвшөөд, хувийн хэвшлийнхэн болон төрийн өмчит компаниуд амьдралд хүрэлцэх хэмжээний цалин өгөөд ирвэл улс төр рүү ийм утгаар орох хүн шууд цөөрнө. Тэд нар чинь сайхан амьдрахын тулд ийм юм хийгээд байна. Улс төрд орсон хүн болгон мөнгөтэй болоод байхаар чинь хүн болгонд тийм мөрөөдөл бий болоод байна шүү дээ. Улс төр рүү ороход нэгдүгээр шалтгаан нь миний ойлгосноор хувийн ашиг сонирхол, амьдралын баталгаа л гэдэг юм харж байна л даа. 500 мянга төгрөгийн цалингаар яаж амьдрах юм бэ. Солонгост захын ажил хийхэд л гурван сая төгрөг ба авч байна шүү дээ. Монголд залуус байраа томруулж чадахгүй байна. Тэгээд залуучууд улс төрд ороод гайгүй явчихаар бүгд жишиг болгож хараад улс төрд зүтгээд байна. (Ярилцлагад оролцогч, эрэгтэй, 40 настай)

Залуучуудыг амжилттай ажиллахад төрөөс бодлогоор дэмжих хэрэгтэй. Ялангуяа анх бизнес эрхэлж байгаа залуучуудаа дэмжих нь чухал. Манайд эрүүлээр бизнес эрхлэх боломж хомс, хэрэв алдаа гаргавал бараг гэмт хэрэгтэн болоход л ойрхон байдаг. Улс төрд орж байгаа залуучууд хэн нэгний халаасанд орохоос л зайлсхийх хэрэгтэй. Үгүй бол хэзээ нэгэн өдөр хэн нэгний өмнөөс шоронд орох ч эрсдэлтэй. Одоо төрийн байгууллагуудаас ТББ болон компани хэн нэгний нөлөөгөөр ажил авч хийж байна. Улс төрчид өөрийн хамаарал бүхий компани, ТББ-аар дамжуулан төрийн мөнгийг үрэн таран хийж байна. Бусад улс оронд шинэ компаниудыг дэмжих дэмжлэг өндөр бол Монголд энэ нь эсрэгээрээ л байна. (Ярилцлагад оролцогч, эрэгтэй 34 настай)

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, залуучуудын хувьд улс төрөөс ангид үйл ажиллагаа явуулах боломжгүйд, эсвэл улс төрд зах зээлийн зүй ёсны шаардлагыг тавьж чадахгүйд хүргэж байгаа гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, бизнесмен эмэгтэйчүүд, залуучууд улс төрийн ийм бохир ертөнцөд нэг бол улс төрөөс дайжих, хүнийсэх, эсвэл түүнд бохир арга замаар тоглоход хүрдэг. Үүнийг үл тэвчсэн бизнесменүүдийн төлөөлөл олон нийтэд үзэл бодлоо илэрхийлж, өнөөгийн улс төрийг хурцаар шүүмжилж байгаа жишээ цөөнгүй бий.

☉ 3.2 Улс төрч залуучууд эмэгтэйчүүдэд нийгэм соёлын хүчин зүйлс нөлөөлөх нь

Залуучуудын улс төрийн оролцоо ба нийгмийн үеүдийн харилцаа

Энэ удаагийн чанарын судалгааны үр дүнд тулгуурлан залуучуудад улс төрийн идэвхтэй үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээл, сорилтын талаар авч үзэх болно. Олон нийтийн санал бодлын зарим судалгааны үр дүнгээс харахул Монголын улс төрийн шийдвэр гаргах түвшинд залуучуудын төлөөлөл бага байгаа нь залуучуудад танил талын дэмжлэг дутмаг, залуучууд нэр дэвшсэн ч тэднийг сонгодоггүй, залуучуудад сонгуулийн кампанит ажлыг зохион байгуулах нөөц хангалтгүй, залуучуудад улс төрийн туршлага бага зэрэг учир шалтгаантай талаар дурдсан байдаг. Харин чанарын судалгааны үр дүн залуучуудын улс төрийн сонгуульд нэр дэвших болон тэдэнд тулгарч буй асуудалд холбогдох нийгмийн зарим үйл явц, үзэгдэлд анхаарлаа хандуулах болно.

Улс төр залуужихуй ба үе солигдолт

Залуучуудын улс төрийн оролцоо нь зөвхөн энэ үеийнхний нийгмийн зан үйл, үйл ажиллагаа, идэвхт байдлаас хамаарах зүйл биш бөгөөд угаас нийгэм дэх үе хоорондын харилцаанаас үлэмж хамаарах асуудал юм. Үе хоорондын харилцаа нь нийгмийн соёлын тогтолцооны шинж чанарыг агуулж байх ба тухайн нийгмийн ноёлох соёлын тогтолцоо, үнэт зүйлс, уламжлал, зан заншил зэргээр нөхцөлдөж байдаг. Социологич Маннхаймын үзсэнээр нийгэмд өмч, эрх мэдэл, нэр хүнд гэсэн хэмжүүртэй ангийн бүтэц бий болдог шиг *залуу*, *дунд*, *ахмад* гэсэн үеүдийн хоорондын харилцаанд суурилсан бүтэц буй болох бөгөөд энэ нь эргээд тэдгээрийн байр суурь хийгээд үүргийг тодорхойлж байдаг. Өмнөх бүлэгт тодорхойлсончлон, Монголын уламжлалт ноёлох соёлд ахмад настан илүү хүндлэгдэх хэв шинж бүхий харилцаа оршиж ирсэн билээ. Энэхүү нийгмийн харилцаанд ахмад гэдэг үг нь *нэгдүгээрт*, мэдээж ахмад буюу хүй элгэний утгаар ураг төрөл, овгийн ахлагчийг, хүний амьдралын мөчлөгөөр ахмад настныг, хөдөлмөр үйл ажиллагаагаар тэтгэврийнхнийг, *хоёрдугаарт*, тухайн бүлэг хүмүүсээс арай илүү оймс илээсэн ахимаг насны бүлэг хүмүүсийг гэсэн давхар утга санааг илэрхийлж ирснийг тэмдэглэх хэрэгтэй.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд улс төрийн үе солигдох байдал эхэлсэн бөгөөд харьцангуй залуу үе улс төрийн өндөр эрх мэдэлд гарч ирэх үзэгдэл бий болсон юм. Тухайлбал, Австри, Финлянд, Шинэ Зеланд, Эл Сальвадор, Гүрж, Гайана зэрэг орнуудын төрийн удирдлагад 1980-аад оны залуучууд буюу шинэ мянганыхан сонгогдон гарч ирсэн бөгөөд манай улсын хувьд ч дэлхийн хамгийн залуу төрийн удирдагчтай улс орнуудын тоонд орж байна. Ер нь ойрхны улс төрийн сонгуулиудад, залуучууд урьд өмнөхөөс илүү нэр дэвших, сонгогдох явдал Монгол улсад ч ажиглагдаж байна. УИХ, болон орон нутгийн өөрийн удирдах байгууллагад залуу үеэс нэр дэвших, сонгогдох байдал урьд өмнөхөөс илүү байсан бөгөөд ерөнхийдөө улс төрийн үе солигдох үйл явц өрнөж байна. Насыг дээдлэх, ахмадыг хүндэтгэн үзэх уламжлалт үнэт зүйлс бүхий манай нийгмийн ноёлох соёлд, нийгмийн үеүдийн харилцаа, бүтцэд суурь өөрчлөлт бий болж байна хэмээн үзэж болох юм. Улс төрийн амьдралд ахмад хүнийг илүүд үзэх үзэлд тодорхой өөрчлөлт бий болж, залуучуудыг дэмжих хандлага өсөн нэмэгдэх болсныг харж байна. Үүнийг нэг талаас, улс төрийн амьдралд үе солигдох, нөгөө талаас, улс төр залуужих (*rejuvenating politics*) хэмээн нэрлэх нь бий. Судлаачид нийгмийн үеүдийг хүүхдийн бүүмийнхэн (1946-1960), Х үеийнхэн (1960-1980), Ү буюу мянганыхан (1980-1995), Z буюу дижитал үеийнхэн (1995-2010), Алфа буюу нэн шинэ үеийнхэн (2010- хойш) гэж ангилах нь бий. УИХ-ын болон орон нутгийн сүүлийн сонгуулийн үйл явцаас харахад манай улсад улс төрийн хүрээнд Х үеийнхний жанжилж асан хүчний бүтцэд шинэ мянганыхан түрж орж үе сэлбэж байгааг анзаарч байна.

Сүүлийн сонгуульд үе солигдолт явагдсан, залуучууд маш ихээр нэр дэвшсэн. Залуу үеийг дэмжиж хандлага өөрчлөгдөж байгаа нь харагдсан. (Ярилцлагад оролцсон, 34 настай, эмэгтэй)

Олон нийтийн хандлага өөрчлөгдөж байна. Залуучуудаа дэмжихийг хүсэж байгаа тал ажиглагдсан юм. Би чинь УИХ-д бас нэр дэвшсэн шүү дээ. 1980-аад оны сүүл 90-ээд оноос өмнө нь хүмүүжсэн, түүнээс хойш хүмүүжсэн хүмүүсийн хандлагын маш том ялгаанууд ажиглагдаж байна. Өнөөг хүртэл бол 1990-ээд оноос өмнө хүмүүжсэн, боловсрол эзэмшсэн сургууль, төгссөн хүмүүс л удирдаад байна шүү дээ. Харин түүнээс хойших үеийн хандлагын ялгаа нь илүү залуучуудаа дэмжье гэдэг. Гэхдээ өмнөх үеийнхэн ч залуучуудаа дэмжье гэх болжээ. (Ярилцлагад оролцогч, 37 настай, эрэгтэй)

Залуучууд бол мэдээж нэр дэвших шаардлагатай байдаг. Хүн болгон дэвшиье би залуу хүн гарна, ингэнэ тэгнэ, чадна, зүтгэнэ гээд байдаг. Залуучуудын хувьд яалт ч үгүй үеийн л нөлөөлөл байдаг гэж хардаг. Яг ингээд намын барьж байгаа тэр үеийнхэн өөрсдөө аягүй их үеэрээ түрж орж ирдэг. Дараа үе нь гарч ирэхэд заавал өмнөх үеэ бүхлээрээ бараг түрж орж ирдэг. Тэгж байтал нас нь яваад өгчихдөг. Тэгэхээр залуучуудын хувьд насны залуу үеийн нөлөөлөл фракцлалын хүртэл асуудал ихтэй дээ.

Улс төр залуужих, үе солигдох асуудал нь яагаад чухал болохын тухайд хоёр зүйлийг тэмдэглэж болно. Нэгдүгээрт, уламжлалт соёлын нөлөө нь залуучуудын оролцооны учир холбогдлыг доогуур үнэлэх хандлага, түүнийг дэмжсэн хэвшмэл ойлголтыг төлөвшүүлж, энэ нь хувь хүмүүсийн харилцаанаас хальж институтчилэгдэж ирсэн тул улс төр залуужих шаардлагатай байгаа юм. Хоёрдугаарт, улс төрийн үе солигдох, залуучуудаар сэлбэх явдал туйлын хөшүүн байх ба улс төрд уламжлалыг хадгалах чиглэл давамгайлж, өөрчлөн шинэчлэгч хүчин удааширч ирсэн учраас улс төр залуужих хэрэгцээтэй болсон байна. Судлаачид залуучуудыг нийгмийн өөрчлөлтийн агент хэмээн энэ үеийнхний нийгмийн үүргийг чухалчилж ирсэн нь ийм учиртай. Ялангуяа шинэ зуунд улс орнуудын нийгэм, улс төрийн хөгжлийн хурд урьд өмнөхөөс илүү бөгөөд бодлогын шинэчлэлүүд энэхүү хурдыг гүйцэхийн тулд шил даран ар араасаа хөвөрч байна. Энэ удаагийн чанарын судалгааны үр дүнд тулгуурлан залуучуудын өмнө сонгуульд нэр дэвшихэд тулгарч буй дараах саад, бэрхшээлүүдийн талаар авч үзэх боломжтой.

Насыг дээдлэх үзэл ба “Х” үеийнхний ноёрхол

Дээр дурдсан нийгмийн үеүдийн уламжлалт соёл зөвхөн Монголд байдаг зүйл биш, тухайлбал Азийн орны хувьд эдгээр улс орнуудын улс төрийн амьдралын ижилсэл бий болж байдаг. Энэ нь улс төрд ахмад үеийнхний байр суурь харьцангуй өндөр байдаг явдал юм. Азийн орнуудын удирдагчдын хувьд улс төрийн нас нэлээд хожуу байгааг БНХАУ, БНСУ, Япон улс, Энэтхэг зэрэг орны одоогийн удирдагчид, улс төрчдийн насны байдлаас харж болно. Монголын

их хаан Чингисийн “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” хэмээх үг нь улс төрд хүмүүс насны багадаа орж суралцаж, туршлагажих хэрэгтэй гэхээс илүүтэй нас тогтсон, ажил амьдрал жигдэрсэн үедээ орох нь зүйтэй гэсэн утга санааг хүчтэй бий болгодог. Ахмадыг залуугаас илүү нийгмийн байр суурьд өргөмжлөх соёлын үнэт зүйлс нь хувь хүний туулж өнгөрүүлсэн цаг хугацаа, үзэж амссан амьдралын туршлагыг хүндэлж буй утга санааг агуулж байдаг. Энэ нь эргээд залуучуудыг улс төрийн амьдралд шинэ, туршлага хомс гэдгээр нь ялгаварлан гадуурхах үндэс болдог ажээ. Нийгмийн шинжлэх ухаанд насыг дээдлэх үзэл (ageism), эрийн цээнд буюу насанд хүрэгсдийг илүүд үзэх (adultcentrism) зэрэг нэр томъёо бий бөгөөд насны байдалд суурилан хэн нэгэнд ялгавартай хандах байдлыг илэрхийлдэг.

Анх орж байгаа залуучуудад бол ямар шатнаас нь хамаарна. Оюутан залуус бол мэдээж туршилагасаад байх юм байхгүй анхан шатнаасаа туршилага сууна. Дунд түвшинд, арай өндөр түвшинд карьер хөөж, шинээр орж ирж байгаа залуучуудыг улс төрийн амьдрал мэдэхгүй, нам мэдэхгүй гээд жийчих гээд байдаг. Улс төр өөр туршилага учраас тэр хүмүүс үнэхээр мэдэхгүй, мэдэхэд цаг хугацаа хэрэгтэй. (Ярилцлагад оролцогч, 37 настай, эмэгтэй)

Залуу хүн гэхээр туршилагагүй, түүхийгээрээ, мэдлэг боловсролгүй гэж массаараа хардаг. Тэгээд нөгөө олон нийтийн ихэнх нь ардчиллаас өмнө амьдарч байсан ахимаг настнууд социализмын үеийн үзэл баримтлалаараа л дүгнэдэг нь л байх гэж боддог. (Ярилцлагад оролцогч, 29 настай, эрэгтэй)

Намайг 2016 онд нэр дэвших гээд явж байхад нийгэмд бүү хэл манайхан ах дүү дотроос ч тийм үг цухуйлгаж байсан. Чи бол арай болоогүй шүү, хүүхэд ухааны юм ярьж байсан. Тэгээд би бол өөрийгөө болчихсон гэж бодож байсан. Одоо УИХ-ын сонгууль дээр ийм үзэл бодлыг эвдэж байна. (Ярилцлага оролцогч, 36 настай, эрэгтэй)

Өнөөдөр залуучууд гэр бүлийнхээ асуудлыг шийдээгүй байж яаж улс төрд явах юм бэ, хэцүү байхгүй юу. Залуучууд явах нь зөв, гэхдээ шатлалаараа яв. Юу ч ойлгоогүй байж улс төрд гараад том албан тушаал дээр очлоо шүү дээ. Хөгшичүүл гэдэг бол муу ч бай, сайн ч бай амьдралын туршилагаар наана цаанатай харчихсан, гарах эрсдэлийг байнга тооцож авдаг. (Ярилцлага оролцогч, 35 настай, эрэгтэй)

Улс төрд насыг гол болгох үзэлд шүүмжлэлтэй хандах үзэл нь Монголын улс төрийн талбарыг залуучууд бүрэн эзлэх, улс төр бүрэн залуужих, улс төрийн ахмад үе залуу үеэр бүрэн солигдох тухай нэг талаас, уриа лоозонгийн шинжтэй зүйл биш, нөгөө талаас, ахмад үеийнхний нийгмийн үүрэг, байр суурийг үгүйсгэж буй хэрэг биш юм. Дээр дурдсанчлан, нийгмийн харилцаа гэдэг бол үеүд хоорондын зохирол, тэнцвэртэй харилцаа, харилцан шүтэлцээг хэлж буй юм. Монгол улсад залуу үеийнхэн улс төрд орох, ялангуяа сонгуульд нэр дэвшихэд залуу үед хамаарч буй учраас амьдралын болон улс төрийн туршлага дутмаг гэж үзэх, хандах байдал нийтлэг байна.

Улс төрийн сөрөг соёл ба өв залгамжлал

Хэдийгээр Монголын улс төрд үе солигдох, залуужих үйл явц явагдаж байгаа ч, шинэ мянганыхны өмнөх (Х, цаашилбал түүний өмнөх) үеүдийн улс төрчдийн ноёрхол буюу хөшигний ард явцуу ашиг сонирхлын төлөө улс төрийн шийдвэр гаргах, намын голлох улс төрийн томилгоог хийх, залуу улс төрчдийг хүчний болон санхүүгийн хамааралд байлгах явдал байсаар байна. Өөрөөр хэлбэл, Х үеийнхний энэ ноёрхол нь улс төрд шинээр орж ирж буй Y буюу мянганыханд улс төрийн сөрөг соёл, улс төрийн намын дотоод ардчиллын сул хөгжил, фракцын буюу явцуу бүлэглэлийн улс төр, рент хайх үзэгдлийг өвлүүлэн өгч байгаа гэж үзэж байна. Эндээс, өнөөдөр Монголд өрнөж буй улс төрийн үе солигдох үйл явц нь залуу үеийнхэн цаг үеийн шаардлагаар түрж орж ирж буй байдал уу, аль эсвэл бохир улс төрийн зорилготойгоор бэлтгэгдсэн өвийг залгамжлал уу гэдгийг онож дүгнэхэд хүндрэлтэй юм. Залуучууд, залуу үеийнхэн өөрсдийн нийгмийн үеийнхээ үнэт зүйлс, үзэл бодол, зарчимд суурилсан улс төрийг хийх боломж энэ тохиолдолд хязгаарлагдмал болж ирэх бөгөөд өмнөх үеийнхний бий болгосон улс төрийн соёлыг эзэмшсэнээр өөрчлөлт шинэчлэлийн агент байх үүрэг нь хумигдаж байгаа юм. Улс төрийн ахмад Х үеийнхэн үе бол төрийн социализмын үед улс төрийн нийгэмшил нь явагдсан бөгөөд харин Х үеийнхний дэд бүлэг болох 1970-аад оныхны хувьд улс төрийн нийгэмшил нь нийгмийн шилжилтийн үе тохиосон завсрын шинжтэй гэж хэлж болох юм. Төрийн социализмын болон ардчиллын улс төрийн үнэт зүйлсийн баримжаа хосолмол байдлаар төлөвшсөн гэсэн утгатай.

Улс төрд шинэ үе гарч ирж байгаа нь илэрхий байна, хамгийн гол асуудал бол өмнөх үеийн улс төрчид нь байр сууриа бүрэн тавьж өгөх болоогүй, нэг хэсэг нь тэдний ард сууж байна, өмнөх үеийнхэн өөрсдийн муу үзэл хандлага, бохир арга барилыг дамжууламгүй, залуучууд түүнээс суралцамгүй байгаа юм. (Ярилцлагад оролцогч, 46 настай, эмэгтэй)

Улс төр бохир зүйл гэдэг нь нэг их сүртэй өөрчлөгдөөгүй байх. Эрэгтэйчүүдийн хийдэг зүйл ч гэдэг нь нэг их өөрчлөгдөөгүй байх. 1990 ээд оны хүүхдүүд гарцан дээр зогсож байна. Шинэ үе гарч ирж байна. Тэрнээс өмнөх үе бол бохирдсон үеийнхэн. (Ярилцлагад оролцогч, 36 настай, эрэгтэй)

Х үеийнхний буюу шилжилтийн үед Монголд төлөвшсөн улс төрийн сөрөг соёл буй агаад тэдний хувьд улс төр бол хувийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх, нийгмийн баялгаас хувь хүртэх гол талбар билээ. Ямар аргаар хамаагүй эрх мэдэлд хүрэхийг чухалчилна. Мэдээж Х үеийнхний хувьд бүхэлдээ энэ соёлыг илэрхийлэхгүй ч, тэдний улс төр хийх голлох арга зам нь ийм соёлын орчинд явагдсан. Х үеийнхний дунд улс төрийн сөрөг соёлыг тээгч, амьдралын зорилго ба арга хэрэгсэл нь үүгээр тайлбарлагдах дэд бүлэг байгаа юм. Хоув, Штраус нар (2000) нийгмийн үеүд бол 1) нэг үеэ мэдэрч буй хүмүүс, 2) хуваалцаж буй итгэл

үнэмшил ба зан үйлийн хэлбэрүүд, 3) хуваалцаж буй түүх буюу хүүхэд, өсвөр насандаа амссан амьдралын туршлага гэж хэлсэн байдаг. 1970-аад оныхны хувьд улс төрийн үеийн талаарх мэдрэмж, ойлголт ижил, улс төрийн талаарх итгэл үнэмшил адил, зан үйл төсөөтэй, хүүхэд, өсвөр насандаа улс төрийн байгууллагад оролцсон түүх, амссан туршлага нийтлэг юм. Өнөөдөр Х үеийнхнээс Y үеийнхэн буюу мянганыхан ийм улс төрийн сөрөг соёлыг хэрхэн өвлөн авч байгаа вэ? гэсэн асуулт сонирхол татаж байна.

	Х үеийнхэн	Y үеийнхэн буюу мянганыхан	Z үеийнхэн	Альфа үеийнхэн
Үнэт зүйлс	Төрийн социализм ба ардчиллын холимог үнэт зүйлс	Завсрын буюу нэг талаас, өмнөх үнэт зүйлсийг дамжуулагч, нөгөө талаас шинийг эрэлхийлэгч	Ардчилсан үнэт зүйлс	
Амьдралын нөхцөл ба хэв маяг	Нийгэм, эдийн засгийн тодорхойгүй ба тогтворгүй байдал, индивидуализмын эхлэл, популяр соёлын ба ТВ, видео тоглоомын залуу насандаа компьютерын ертөнцтэй тулгарсан, эрин үе, их бага интернэтийн хэрэглээ, мэдээллийн технологийн хөгжил ба мэдээллийн нийгмийн үүсэл	Нийгмийн олон янзын зөрчилдөөн, Дижитал технологийн (email, sms) эрин үе ба анхны дижитал иргэд, хүүхэд насандаа компьютерын хэрэглээ, брэндэд үнэнч, мэдээллийн хэрэгслээс хараат байдал, нийгмийн бодит болон виртуал харилцааны хослол, өмнөх үеийн үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрөх, нийгмийн идэвх, текстийн оронд визуал, аудио мэдээллийг чухалчлах	Дэлхий нийтийн хэлхээ холбоо, харилцаа холбооны гол талбар бол нийгмийн сүлжээ, фэйсбүүк үндэстэн, мэдээллийн хэрэглэгч ба түгээгч, маш сайн техник хэрэгслийн ур чадвар, хурдан шийдвэр гаргах, олон соёлд толерант, уян хатан, ухаалаг байдал, онлайн хэлхээ холбоо, блог хөтлөх, хөгжим сонсох, имэйл бичих олон үйлдэл,	Шинэ хүлээлт, боловсрол ба ажил эрхлэлтийн шинэ төрөл, хандлага

Социологич Маннхаймын (1952) үзсэнээр аль ч нийгэм нь нийгмийн үеүдийг алгасаж хөгждөггүй, дийлэнхдээ нийгмийн эрс өөрчлөлт гэнэтийн шинжтэй хийгддэггүй нь аль ч үед завсрын үе байдагт оршино. Монголд ардчилал нийгэм, улс төрийн ноёлох соёл болж эргэлтгүй төлөвших, Х болон тэрнээс өмнөх үеийнхний өвлүүлж ирсэн улс төрийн сөрөг соёлыг хэрхэн сөрөн

зогсож, даван туулах нь Z болон альфа үеийнхнээс хамаарна. Y үеийнхэн буюу мянганыхан дараагийн үеэ улс төрийн шинэ соёлд хөтлөх залгамж үеийнхэн болно. Маккриндл, Волфингэр нар (2010) түүхэн цаг үед буй хүмүүсийн нийтлэг туршлага нийгмийн үеийг тодорхойлох ба энэ нь технологийн мэдлэг хийгээд амьдралын туршлагыг илэрхийлдэг гэжээ. Мэдээллийн болон технологийн хөгжил, хувьсал нь нийгмийн үеүдийн амьдралын хэв маягийг хурдтай өөрчилж байна.

Цүнх баригч

Залуучуудын улс төрийн оролцоог судлах явцад “цүнх баригч” хэмээх ойлголттой зайлшгүй тулгарах болно. Монголын залуучууд улс төрд орох, улмаар улс төрийн карьерыг улс төрийн сонгуульд нэр дэвших хүртэл ахиулахад энэ үйл явц институтын ямар орчинд хэрэгждэг талаар сонирхон үзэх шаардлагатай болно. Монгол улсад ерөөс улс төрд оролцохын тулд 1) бизнесийнхэн улс төрийн нам, улс төрчдийг санхүүжүүлэх замаар улс төрийн албан тушаалд очих, 2) намын дотоод аппарат, түүний дэргэдэх байгууллагуудаар дамжин аль нэг улс төрчийн юм уу фракцын хүн болж байж албан тушаал горилох, 3) улс төрийн өв залгамжлал буюу улс төрчийн гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хэлхээ холбоогоор дамжин улс төрд орох, улс төрийн албан тушаалд томилогдох, 4) төрийн улс төрийн бус албан тушаалтнууд улс төрчдөд, улс төрийн өөрсдийн хашиж буй алба, эрхэлж буй ажлаар давуу тал гаргах, үйлчлэх байдлаар улс төрд орох гэх мэт замналууд 20 жилийн өмнөөс бий болсон гэж хэлж болох юм. Улс төр судлаач Климагийн тодорхойлсончлон, энэ бүхэн нь улс төрийн клиентелизмийн үүсэл гарвал, хөгжлөөр тайлбарлагдах болно.

Залуучуудын хувьд дээрх дурдсануудаас намын дотоод аппарат, түүний дэргэдэх байгууллагуудаар дамжин аль нэг улс төрчийн юм уу фракцын хүн болох замаар албан тушаалд очих нь улс төрчийн карьерын нийтлэг замнал бөгөөд үүнийг олон нийтийн дунд “цүнх баригч” хэмээн гоочилсон, шүүмжилсэн аясаар нэрлэх болжээ. Бүр цаашилбал цүнх баригч залуучуудын давхарга эсвэл томоохон бүлэг нь “бөгс долоогч” гэсэн жижиг бүлгийг ч өөртөө агуулж байдаг гэжээ. Бөгс долоогч хэмээх нэр томъёо нь нийгмийн хувьд илүү доромж агуулга бүхий бөгөөд залуучуудын хувьд өөрийн гэсэн үнэт зүйл, зарчим, үнэ цэнэ, үзэл баримтлалаа бүрэн гээж, чухамдаа өөрийг нь гэжээн тэтгэдэг улс төрчийг бүх талаар тахин шүтэж, түүнд үнэнчээ харуулахын тулд янз бүрээр магтан өргөмжлөхийг хэлж буй бололтой. Дээрх нэр томъёонуудаас гадна, залуучууд ах нар буюу ахмад үеийнхнийхээ дэмжлэгээр төрийн албанд томилогдох байдлыг “крандуулах”, “лифтээр өгсөх” ойлголтоо илүүтэй илэрхийлдэг байна. Зарим тохиолдол улс төрийн сонгуульд нэр дэвшихэд ч ийм нэршлээр хэлүүлж болох юм.

Ерөнхийдөө, улс төр хийж буй залуу хүн бүрийг “цүнх баригч”, “бөгс долоогч” хэмээн үзэх олон нийтийн хандлага нь энэ үеийнхний улс төрийн оролцоог үгүйсгэх, ач холбогдлыг бууруулах байдлаар нөлөөлж байж болохыг хэвшмэл ойлголтын сөрөг үр дагавар гэсэн ойлголтоор тайлбарлаж болно.

Санхүүгийн хараат байдал

Залуучуудын сонгуульд нэр дэвшихэд тулгардаг томоохон бэрхшээлийн нэгд мөнгө, санхүүгийн чадавх болох нь тодорхой байна. Улс төрийн намууд сонгуульд залуучууд нэрээ дэвшүүлэхэд ил болон далд хэлбэрийн ихээхэн хэмжээний мөнгө зарцуулах хэрэгтэй болдог. Намууд гишүүдээс нэр дэвшүүлэхдээ мөнгө, санхүүгийн ихээхэн хэмжээний дэнчин, барьцаа, төлбөр зэргийг шаарддаг учраас энэ түвшин дэх залуучуудын улс төрийн оролцоог хязгаарлах бодит хүчин зүйл нь санхүүгийн өндөр босго юм.

Мөнгө санхүүгийн ийм босго нь залуучуудын хувьд бизнесийн салбараас улс төрд орж ирэх, бизнесменүүд болон бэл бэнчин бүхий улс төрчдийн ивээн тэтгэлэгт хамрагдах шаардлагыг бий болгож байна. Өнөөдөр Монголын улс төрд амжилттай яваа залуучуудыг аль нэг компани, корпорацын төлөөлөл болгох, эсвэл аль нэг бүлэг, фракцын халаасны хүн гэж төсөөлөх, тайлбарлах хандлага олон нийтийн санал бодолд хүчтэй хэвээр байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

▪ Уламжлалт ноёлох соёлын хүрээн дэх консерватив хэв маягийн үнэт зүйлс, зарчмууд нь залуучууд болон эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог үгүйсгэх, хязгаарлах агуулгатай байна.

▪ Дээрх уламжлалт ноёлох соёл нь өмнөх нийгмийн тогтолцооны хадгалагдаж, зарим талаар баяжиж, бэхжиж явсаар ардчиллын үетэй золгосон бөгөөд шинэ нийгмийн соёлын тогтолцоотой зөрчилдөж, сорилттой тулгарсаар ирсэн.

▪ Уламжлалт ноёлох соёлын тогтолцоо өөрчлөгдөж байна, энэхүү өөрчлөлтийн нэг илрэл нь ардчилалд залуучуудын болон эмэгтэйчүүдийн оролцоо амин чухал зүйл гэдгийг хүлээн зөвшөөрөх үйл явц юм.

▪ Монгол улсад улс төрийн оролцоог хангах ардчиллын институтүүд хангалттай хөгжиж, төлөвшиж чадахгүй байгаа юм. Монголын ардчилал сул талтай байна, тэр дундаа улс төрийн оролцоо хамгийн сул тал нь болж байна. Үүнд улс төрийн шийдвэр гаргах түвшинд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоо дутмаг байгаа нь нөлөөлж байна.

▪ Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал нь нэг талаас, улс төрийн амьдралд чинээлэг, статус өндөр эрчүүдийн өмнө эмэгтэйчүүд, нөгөө талаас, чинээлэг, статус өндөр ахмадууд, дунд үеийнхний өмнө залуучууд гэсэн тэгш бус нөхцөл байдал, гарааны шударга бус зурхайг үүсгэж байна.

▪ Чөлөөт зах зээлийн хөгжил нь улс төрөөс хамааралтай, ялангуяа бохир улс төрийн нөлөө их үед нэг талаас, залуучууд, эмэгтэйчүүдийн эрүүл саруул, зүй ёсны оролцоог хумьж, бохир улс төрд татан оруулах, нөгөө талаас, улс төрөөс дайжих, хүнийсэх хандлагад түлхэж байна.

▪ Монгол улсад улс төр залуужих, үе солигдох үйл явц өрнөж буй ч, залуу үеийнхэн улс төрд орох, ялангуяа сонгуульд нэр дэвшихэд залуу үед хамаарч буй учраас амьдралын болон улс төрийн туршлага дутмаг гэж үзэх, хандах байдал нийтлэг байна.

▪ Улс төр дэх Х үеийнхний ноёрхол нь улс төрд шинээр орж ирж буй Ү буюу мянганыханд улс төрийн сөрөг соёл, улс төрийн намын дотоод ардчиллын сул хөгжил, фракцын буюу явцуу бүлэглэлийн улс төр, рент хайх үзэгдлийг өвлүүлэн өгч байна.

▪ Ерөнхийдөө, улс төр хийж буй залуу хүн бүрийг “цүнх баригч”, “бөгс долоогч” хэмээн үзэх олон нийтийн хандлага нь энэ үеийнхний улс төрийн оролцоог үгүйсгэх, ач холбогдлыг бууруулсаар байна.

▪ Өнөөдөр Монголын улс төрд амжилттай яваа залуучуудыг аль нэг компани, корпорацын төлөөлөл болгох, эсвэл аль нэг бүлэг, фракцын халаасны хүн гэж төсөөлөх, тайлбарлах хандлага олон нийтийн санал бодолд хүчтэй хэвээр байна.

- Хэдийгээр, ноёлох соёл өөрчлөгдөж, эмэгтэйчүүдийн улс төрийн нөлөө нэмэгдэж байгаа ч гэсэн өнөө хэр нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог жендерийн дэг ёс хязгаарласан хэвээр байгаа юм.

- Өнөөдөр улс төрчдийн зүгээс хийж гүйцэтгэж байдаг хар сүлд цэнгүүлэх, уул овоо тахих, сүм дуган барих, суварга босгох, нутаг усны ой тэмдэглэх зэрэг зан үйлдлэгийн зүйлс нь улс төрд жендерийн тэгш бус байдлыг хадгалах, хэвшмэл ойлголтыг хадгалах нэг нөхцөл болж байна.

- Эмэгтэйчүүд үр хүүхдээ төрүүлж, өсгөж, гэр бүлийн гишүүддээ анхаарал тавьж байх ёстой гэсэн жендерийн үүргийн талаарх хэвшмэл ойлголт нь эмэгтэй хүн улс төр хийхэд олон нийтийн зүгээс тааламжгүй хандах шалтгаан болсоор байна.

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. <https://www.legalinfo.mn/law/details/367>
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946 он. <https://www.legalinfo.mn/law/details/1271>
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн конвенц 1954 он. <https://www.legalinfo.mn/law/details/1293>
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 2020 он. <https://www.legalinfo.mn/law/details/15826?lawid=15826>
- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2005 он. <https://gec.gov.mn/list/79>
- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2011 он. <https://gec.gov.mn/list/79>
- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2015 он. <https://gec.gov.mn/list/79>
- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2019 он. <https://www.legalinfo.mn/law/details/14869>
- Улс төрийн намын тухай хууль. 2005 он. <https://www.legalinfo.mn/law/details/508>
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль. 2020 он. <https://www.legalinfo.mn/law/details/15125>
- Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль. 2011 он. <https://www.legalinfo.mn/law/details/253>
- АН-ын дүрэм. 2017 он. <http://www.ivote.mn/parties/view/4>
- МАН-ын дүрэм. 2017 он. <http://www.nam.mn/rules>
- ХҮН-ын дүрэм. 2018 он. <http://www.hunnam.mn/?id=248>
- МАХН-ын дүрэм. 2019 он. <https://maxh.mn/%D0%BC%D0%B0%D1%85%D0%BD-%D1%8B%D0%BD-%D0%B4%D2%AF%D1%80%D1%8D%D0%BC/>
- МАН-ын Хүний нөөцийг бүрдүүлэх, шилж сонгох, дэвшүүлэх, хариуцлага тооцох журам. Бага хурлын 2015 оны 12 сарын сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралт.
- Монгол Улсын Их хурлын сонгуульд “Зөв хүн электорат” эвслээс нэр дэвшүүлэх дотоод журам. 2020 он.
- 2020 оны УИХ-д сонгогдсон нам, эвслийн дэмжлэг, суудлын тоо. <https://ikon.mn/elections/2020>
- Women in politics 2020. IPU. <https://www.ipu.org/resources/publications/infographics/2020-03/women-in-politics-2020>
- Youth empowerment. IPU. <https://www.ipu.org/our-impact/youth-empowerment>

Мянганы хөгжлийн зорилтууд. www.undp.mn

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Үндэсний статистикийн хороо. www.1212.mn

ТАНИЛЦ: АН, МАН-аас сонгуульд нэр дэвшиж буй эмэгтэйчүүд. <https://ikon.mn/n/1vvs> 2020 оны 5 сарын 18

Тогтвортой хөгжлийн зорилтууд. <http://sdg.1212.mn/>

УДШ-д бүртгэлтэй 36 улс төрийн нам байгаа. <http://www.supremecourt.mn/nam>

Үндсэн хууль батлалцсан эмэгтэй парламентчдад хүндэтгэл үзүүлэв <http://www.shuud.mn/a/47617> 2012-01-10 нийтэлсэн.

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо Үндэсний Статистикийн хороо. 2019 он. https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Civil_servants_2019.pdf&ln=Mn

УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх боломж. <https://ikon.mn/opinion/1v0l>

Олон мандаттай том тойргоос авах сургамж. <https://ikon.mn/opinion/1u27>



UIH.MN
СУДАЛГААНЫ САН